

**ДЭЛХИЙН ДОПИНГИЙН ЭСРЭГ АГЕНТЛАГ**

**ДЭЛХИЙН ДОПИНГИЙН  
ЭСРЭГ ХУУЛЬ**

**2015 он**

Улаанбаатар хот  
2018 он

## **ДЭЛХИЙН ДОПИНГИЙН ЭСРЭГ ХУУЛЬ**

“Дэлхийн допингийн эсрэг хууль” нь анх 2003 онд батлагдан, 2004 оноос хүчин төгөлдөр болж, улмаар 2009 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс нэмж өөрчилсөн хувилбар нь хүчин төгөлдөр болсон. Доорх бичиг баримтыг 2013 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Өмнөд Африкийн Иохансбург хотноо байрлах Дэлхийн Допингийн Эсрэг Сангийн Удирдах Зөвлөлөөс баталсан нэмэлт өөрчлөлттэйгээр гаргасан. Энэхүү нэмэлт өөрчлөлт орсон Дэлхийн допингийн эсрэг хууль нь 2015 оны 1 сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон.

## **АГУУЛГА**

<b>ДЭЛХИЙН ДОПИНГИЙН ЭСРЭГ ХУУЛЬ .....</b>	<b>3</b>
<b>ДЭЛХИЙН ДОПИНГИЙН ЭСРЭГ ХӨТӨЛБӨР, ДҮРМИЙН ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ .....</b>	<b>11</b>
<b>ХУУЛЬ .....</b>	<b>11</b>
<b>ДЭЛХИЙН ДОПИНГИЙН ЭСРЭГ ХӨТӨЛБӨР .....</b>	<b>11</b>
<b>ОЛОН УЛСЫН СТАНДАРТУУД .....</b>	<b>12</b>
<b>ШИЛДЭГ ПРАКТИКИЙН ЗАГВАР БОЛОН ЗААВАРЧИЛГААНУУД .....</b>	<b>13</b>
<b>ДЭЛХИЙН ДОПИНГИЙН ЭСРЭГ ХУУЛИЙН ҮНДСЭН ХАРЬЦАА .....</b>	<b>13</b>
 <b>НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: ДОПИНГИЙН ХЯНАЛТ</b>	
<b>ТАНИЛЦУУЛГА .....</b>	<b>14</b>
<b>1-р зүйл: ДОПИНГИЙН ТОДОРХОЙЛОЛТ .....</b>	<b>16</b>
<b>2-р зүйл: ДОПИНГИЙН ЭСРЭГ ХУУЛИЙН ЗӨРЧИЛ .....</b>	<b>16</b>
2.1. Тамирчны өгсөн дээжинд хориотой бодис буюу түүний метаболитууд, эсвэл шинэ тэмдгүүд илрэх .....	16
2.2. Тамирчин хориотой бодис хэрэглэсэн буюу хэрэглэхийг завдах .....	18
2.3. Тамирчин дээж өгөхөөс зайлсхийх, татгалзах, дээж өгөөгүй байх .....	19
2.4. Байршлын мэдээлэлтэй холбоотой алдаа .....	19
2.5. Допингийн хяналтын аль нэг хэсгийг хурамчаар үйлдэх буюу үйлдэхийг завдах .....	19
2.6. Хориотой бодис буюу хориотой арга эзэмших .....	20
2.7. Хориотой бодис буюу хориотой арга хил давуулах буюу хил давуулахыг оролдох .....	20
2.8. Тэмцээнд оролцож байгаа болон тэмцээнд оролцоогүй аль нэг тамирчинг хориотой бодис буюу	

хориотой арга хэрэглүүлэхээр захиран тушаах буюу захирамжлан тушаахыг оролдох .....	21
2.9. Хүндрэлтэй байдал .....	21
2.10. Хориотой холбоо .....	21
<b>3-р зүйл: ДОПИНГИЙН НОТОЛГОО</b> .....	23
3.1. Допингийг нотлох стандарт, үндсэн санаанууд .....	23
3.2. Баримтыг нотлох, дүгнэлт гаргах аргууд .....	23
<b>4-р зүйл: ХОРИОТОЙ ЖАГСААЛТ</b> .....	25
4.1. Хориотой жагсаалтыг гаргах ба хянах .....	25
4.2. Хориотой жагсаалтад багтаасан хориотой бодис болон хориотой аргууд .....	26
4.3. Хориотой жагсаалтад эм болон аргуудыг оруулах шалгуур үзүүлэлт .....	27
4.4. Эмчилгээний зорилгоор чөлөөлөх (TUEs) .....	28
4.5. Мониторингийн хөтөлбөр .....	33
<b>5-р зүйл: ШИНЖИЛГЭЭ</b> .....	34
5.1. Шинжилгээний зорилго .....	34
5.2. Шинжилгээний хамрах хүрээ .....	34
5.3. Шинжилгээний үйл ажиллагаа .....	36
5.4. Шинжилгээ тараах төлөвлөлт .....	37
5.5. Шинжилгээнд тавигдах шаардлагууд .....	38
5.6. Тамирчны байршлын тухай мэдээллүүд .....	38
5.7. Зодог тайлсан тамирчид тэмцээнд буцан ирэх .....	39
5.8. Шалгалтын мэдээлэл цуглуулах .....	39
<b>6-р зүйл: ДЭЭЖИЙГ ШИНЖЛЭХ</b> .....	40
6.1. Магадлан итгэмжлэгдсэн баталгаат лаборатори ашиглах .....	40
6.2. Дээжийн шинжилгээ хийх зорилго .....	41
6.3. Дээжийн судалгаа .....	41
6.4. Дээжийн шинжилгээ хийх болон шинжилгээний хариу өгөх стандарт .....	41
6.5. Цаашид дээжинд хийх шинжилгээ .....	42

<b>7-р зүйл: ҮР ДҮНГИЙН МЕНЕЖМЕНТ .....</b>	43
7.1. Үр дүнгийн менежментийн төлөө хүлээх хариуцлага .....	43
7.2. Сөрөг аналитик үр дүнгийн талаар хянаж үзэх .....	46
7.3. Сөрөг аналитик үр дүнг хянаж үзсэний дараа өгөх мэдэгдэл .....	46
7.4. Хэвийн бус шинжилгээний хариуг хянаж үзэх .....	47
7.5. Хэвийн бус шинжилгээний хариуг хянаж үзэх ба сөрөг паспортын өгөгдлүүд .....	49
7.6. Алдаа гарсан эсэхийг хянан үзэх .....	49
7.7. 7.1-7.6 зүйлд заагдаагүй бусад допингийн эсрэг хуулийн зөрчлийг хянан үзэх .....	49
7.8. Өмнө нь сэргээшийн журам зөрчсөн байсныг тогоох .....	50
7.9. Хэсэгчлэн хүчингүй болгох журамд хамарагдах зарчмууд .....	50
7.10. Үр дүнгийн менежментийн шийдвэрийн талаар мэдэгдэл хийх .....	52
7.11. Спортоо орхих .....	52
<b>8-р зүйл: ГАРГАСАН ШИЙДВЭРИЙГ АНХААРЧ ШУДАРГААР ХҮЛЭЭН АВАХ ЭРХ .....</b>	52
8.1. Шударга хэлэлцүүлэг .....	52
8.2. Үйл явцын хэлэлцүүлэг .....	53
8.3. Хэлэлцүүлгээс татгалзах .....	53
8.4. Шийдвэрийн талаар мэдэгдэх .....	53
8.5. Спортын арбитрийн шүүхийн өмнөх нэг удаагийн хэлэлцүүлэг .....	54
<b>9-р зүйл: ХУВЬ ХҮНИЙ ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮНГ АВТОМАТААР ХҮЧИНГҮЙ БОЛГОХ .....</b>	54
<b>10-р зүйл: ХУВЬ ХҮНД ОНОГДУУЛАХ ШИЙТГЭЛ .....</b>	55
10.1. Допингийн эсрэг хууль зөрчигдсөн үйл ажиллагааны үр дүнг хүчингүй болгох .....	55
10.2. Хориотой бодис буюу хориотой арга хэрэглэсэн,	

хэрэглэхийг завдсан буюу эзэмшсэн, олдсоны төлөө эрх хасах .....	55
<b>10.3. Бусад допингийн эсрэг дүрэм зөрчсөний төлөө хүлээх хариуцлага .....</b>	<b>56</b>
10.4. Алдаа гараагүй буюу санаандгүй үйлдэл байсан тохиолдолд эрх хасах хугацааг хүчингүй болгох ...	58
10.5. Ноцтой алдаа гараагүй буюу санаандгүй үйлдэл байсан тохиолдолд эрх хасах хугацааг багасгах ....	59
10.6. Алдаа гаргаснаас бусад тохиолдолд эрх хасах хугацааг арилгах, багасгах буюу хүчингүй болгох .....	60
10.7. Хэд хэдэн зөрчил гаргах .....	64
10.8. Допингийн эсрэг хууль зөрчсөн талаарх комиссийн шийдвэр гаргасан буюу дээж авсны дараах тэмцээнүүдийн дүнг хүчингүй болгох .....	65
10.9. Спортын арбитрын шүүхийн зардал олгосон болон хуурамч шагналын мөнгийг байршуулах ....	66
10.10. Санхүүгийн үр дагавар .....	66
10.11. Эрх хассан хугацаа эхлэх .....	66
10.12. Эрх хассан хугацаан дах статус .....	68
10.13. Шийтгэлийн талаар автоматаар нийтлэх .....	71
<b>11-р зүйл: БАГТ ГАРАХ ҮР НӨЛӨӨ .....</b>	<b>72</b>
11.1. Багийн спортом шалгалт хийх .....	72
11.2. Багийн спортом гарах үр нөлөө .....	72
11.3. Үйл ажиллагааг зохион байгуулж байгаа этгээдүүд багт илүү шийтгэл оногдуулж болно ....	72
<b>12-р зүйл: СПОРТЫН БАЙГУУЛЛАГАД ӨГСӨН ШИЙТГЭЛ .....</b>	<b>72</b>
<b>13-р зүйл: ДАВЖ ЗААЛДАХ .....</b>	<b>73</b>
13.1 Давж заалдах шийдвэрүүд .....	73
13.2 Допингийн эсрэг хууль зөрчсөн, түүний үр дагавар, хэсэгчлэн хүчингүй болгох, шийдвэр хууль тргтоомжийг хүօээн зөвшөөрөх зэрэг асуудлаар гаргасан шийдвэрийн эсрэг давж заалдах .....	74

13.3	Допингийн эсрэг байгууллагаас цаг хугацаанд нь гийдвэр гаргаж чадаагүй байх .....	77
13.4	Эмчилгээний зорилгоор ашиглах бодистой холбоотой давж заалдах .....	78
13.5	Давж заалдах шийдвэрийн талаарх мэдэгдэл .....	78
13.6	Хуулийн 3 болон 4 дүгээр бүлгийн шийдвэртэй холбогдуулан давж заалдах .....	78
13.7	Лабораторийн магадлан итгэмжлэлийг цуцлах буюу татгалзах шийдвэрийн талаар давж заалдах .	78
<b>14-р зүйл: НУУЦЛАЛ БА МЭДЭЭ</b>		79
14.1	Сөрөг аналитик үзүүлэлт, энгийн бус үзүүлэлт, бусад допингийн эсрэг хууль зөрчсөн үйлдлийн талаарх мэдээлэл .....	79
14.2	Допингийн эсрэг хууль зөрчсөн шийдвэрийн талаар мэдэгдэх ба хавтаст хэрэгт оруулах материал хүсэх .....	80
14.3	Олон нийтэд зарлах .....	81
14.4	Статистик тоо баримт .....	82
14.5	Допингийн хяналтын мэдээллийн клирингийн газар .....	82
14.6	Өгөгдлийн нууцлал .....	83
<b>15-р зүйл: ӨРГӨДӨЛ ГАРГАХ БА ШИЙДВЭРИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ</b>		84
<b>16-р зүйл: СПОРТОД ӨРСӨЛДӨЖ БАЙГАА АМЬТДЫН ДОПИНГИЙН ХЯНАЛТ</b>		84
<b>17-р зүйл: ХЯЗГААРЛАЛТ ХИЙХ ДҮРЭМ</b>		85
<b>ХОЁРДУГААР ХЭСЭГ: БОЛОВСРОЛ БА СУДАЛГАА</b>		
<b>18-р зүйл: БОЛОВСРОЛ</b>		86
18.1	Үндсэн зарчим ба гол зорилго .....	86
18.2	Хөтөлбөр үйл ажиллагаа .....	86
18.3	Үйл ажиллагаа явуулах мэргэжлийн журам .....	87
18.4	Зохицуулалт ба хамтын ажиллагаа .....	88

<b>19-р зүйл: СУДАЛГАА .....</b>	88
19.1    Допингийн судалгааны зорилго зорилт .....	88
19.2    Судалгааны төрлүүд .....	88
19.3    Судалгаа болон шинжилгээний хариуг зохицуулах .....	88
19.4    Судалгааны практик .....	89
19.5    Хориотой бодис болон хориотой аргуудыг хэрэглэх талаар судлах .....	89
19.6    Судалгааны үр дүнг буруугаар ашиглах .....	89
<b>ГУРАВДУГААР ХЭСЭГ: ҮҮРЭГ БА ХАРИУЦЛАГА</b>	
<b>20-р зүйл: ГАРЫН ҮСЭГ ЗУРСАН ТАЛУУДЫН НЭМЭЛТ ҮҮРЭГ ба ХАРИУЦЛАГА .....</b>	90
20.1    Олон улсын олимпийн хорооны үүрэг, хариуцлага .....	90
20.2    Олон улсын паралимпийн хорооны үүрэг ба хариуцлага .....	91
20.3    Олон улсын холбоодын үүрэг, хариуцлага .....	92
20.4    Үндэсний олимпийн хороо, үндэсний паралимпийн хорооны үүрэг ба хариуцлага .....	94
20.5    Допингийн эсрэг үндэсний байгууллагын үүрэг ба хариуцлага .....	96
20.6    Томоохон үйл ажиллагаа зохион байгуулагчдын үүрэг ба хариуцлага .....	97
20.7    ДДЭА-ийн үүрэг ба хариуцлага .....	98
<b>21-р зүйл: ТАМИРЧИД БОЛОН БУСАД ЭТГЭЭДҮҮДИЙН НЭМЭЛТ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА .....</b>	99
21.1    Тамирчны үүрэг ба хариуцлага .....	99
21.2    Тамирчныг дэмжих этгээдийн үүрэг ба хариуцлага .....	100
21.3    Бүсийн допингийн эсрэг байгууллагын үүрэг ба хариуцлага .....	101
<b>22-р зүйл: УЛС ОРНУУДЫН ЗАСГИЙН ГАЗРУУДЫГ ТАТАН ОРОЛЦУУЛАХ .....</b>	101

# **ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ: ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ, ДАГАЖ МӨРДӨХ, ЗАСВАР БОЛОН ТАЙЛБАР ХИЙХ**

<b>23-р зүйл: ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ, ДАГАЖ МӨРДӨХ, ЗАСВАР ХИЙХ .....</b>	104
23.1    Хуулийг хүлээн зөвшөөрөх .....	104
23.2    Хуулийг хэрэгжүүлэх .....	104
23.3    Допингийн эсрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ....	106
23.4    Хуулинд нийцэх .....	106
23.5    Хууль болон ЮНЕСКО-ийн конвенцийг дагаж мөрдөж байгаа эсэхийг хянах .....	106
23.6    Хуулийг дагаж мөрдөөгүйгээс шалтгаалан үүсч болох нэмэлт нөхцөл байдлууд .....	107
23.7    Хуульд оруулах өөрчлөлтүүд .....	108
23.8    Хуулийг зөвшөөрөхөөс татгалзах .....	109
<b>24-р зүйл: ХУУЛИЙН ТАЙЛБАР .....</b>	109
<b>25-р зүйл: ШИЛЖИЛТИЙН ЗААЛТУУД .....</b>	110
25.1    2015 оны хуулийн ерөнхий хамрах хүрээ .....	110
25.2    "Лекс Митор-зарчим үйлчлэхгүй тохиолдол буюу хуулийн 10.7.5 ба 17-р зүйлд зааснаас бусад ретроактив бус заалтууд .....	110
25.3    2015 оны хуулиас өмнө гаргасан шийдвэртэй холбоотой өгөгдлүүд .....	110
25.4    2015 оны 1 дүгээр сарын 1-ээс өмнө гаргасан анхны удаагийн зөрчилтэй холбоотой хэд хэдэн удаагийн үйлдэл .....	111
25.5    Хуулийн нэмэлт өөрчлөлтүүд .....	111
<b>ХАВСРАЛТ 1: тодорхойлолтууд .....</b>	112
<b>Тодорхойлолтууд .....</b>	112
<b>ХАВСРАЛТ 2: 10-р зүйлийг хэрэглэх жишээнүүд .....</b>	124
<b>10-р зүйлийг хэрэглэх жишээнүүд .....</b>	124

# **ДЭЛХИЙН ДОПИНГИЙН ЭСРЭГ ХӨТӨЛБӨР БОЛОН ХУУЛИЙН ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ БОЛОН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

Дэлхийн Допингийн Эсрэг Хууль болон Дэлхийн Допингийн Эсрэг Хөтөлбөрийн зорилго:

- Тамирчдыг допingoос анgid спортын тэмцээн уралдаанд оролцуулах, үндсэн эрхийг хамгаалах, түүгээр дамжуулан дэлхий дахинд тамирчдын эрүүл мэнд, шударга байдал, тэгш эрхийг хангах
- Олон улсын болон үндэсний хэмжээнд допингийг илрүүлэх, хэрэглэхээс урьдчилан сэргийлэх талаар тодорхой зохицуулалттай, үр дүнтэй допингийн эсрэг хөтөлбөрүүдийг бий болгох

*Тайлбар: Олимпийн харти болон 2005 оны 10-р сарын 19 өдөр ЮНЕСКО-оос батлагдсан “Спортод допингтой тэмцэх конвенци”-үүд нь Олон Улсын Олимпийн Хороо болон ЮНЕСКО-ийн допingoос урьдчилан сэргийлэх болон, допингтой тэмцэх гол зорилгуудын нэг хэсэг нь бөгөөд Дэлхийн Допингийн Эсрэг Хуулийн үндсэн үргийг тодорхойлсон болно.*

## **Хууль**

Энэхүү хууль нь Спорт дахь Дэлхийн допингийн эсрэг хөтөлбөрийн суурь болсон үндсэн болон нийтлэг бичиг баримт болно. Хуулийн зорилго нь допингийн эсрэг тэмцлийн үндсэн элементүүдийг нэгтгэн допингтой тэмцэх, үр дүнг сайжруулахад оршино. Энэ үр дүнг сайжруулахын тулд допингтой тэмцэх практикт Хуулинд оруулсан тодорхой заалтууд нь тус дэм болно.

Энэхүү хуулийг хүний эрх болон тэгш байдлын зарчмуудад үндэслэн боловсруулсан.

## **Дэлхийн допингийн эсрэг хөтөлбөр**

Дэлхийн допингийн эсрэг хөтөлбөр нь хамгийн зөв зохицлыг хангах бүх элементүүд болон Үндэсний, Олон улсын хэмжээнд допингийн эсрэг хөтөлбөрийг хангах шилдэг тэргүүний туршлагуудыг агуулсан болно. Эдгээр үндсэн элементүүд нь:

Түвшин 1: Хууль

Түвшин 2: Олон улсын стандартууд

Түвшин 3: Шилдэг туршлагын загварууд болон удирдамжууд

## Олон улсын стандартууд

Гарын үсэг зурсан талууд, олон улсын Засгийн газруудтай зөвшилцсөний үндсэн дээр, ДДЭА-аар батлагдсаны үндсэн дээр Допингийн эсрэг хөтөлбөрийн аливаа техникийн болон үйл ажиллагааны салбар дахь олон улсын стандартуудыг боловсруулна.

Олон улсын стандартуудын зорилго нь Допингийн эсрэг хөтөлбөрийн нэг хэсэг болсон техникийн болон үйл ажиллагааг хариуцсан Допингийн Эсрэг Байгууллагуудын хамтын ажиллагааг хангахад оршино. Олон улсын стандартуудыг энэхүү Хуультай уялдуулан хатуу чанд сахин мөрдөх ёстой. Олон улсын стандартуудыг ДДЭА-ийн гүйцэтгэх хорооноос гарын үсэг зурсан талууд, олон улсын Засгийн газрууд болон бусад сонирхол бүхий оролцогч талуудтай зөвшилцсөний үндсэн дээр үе үе хянан хэлэлцэж болно. Олон улсын стандартууд, түүнд орсон засвар өөрчлөлтүүд нь ДДЭА-ийн вэб сайтан дээр хэвлэгдэн гарах бөгөөд Олон Улсын стандартууд болон хянан засварлагдсан хувилбарууд нь заасан хугацаанд хүчин төгөлдөр болно.

*Тайлбар: Олон улсын стандартууд нь энэхүү хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай техникийн нарийвчилсан үзүүлэлтүүдийг багтаасан байна. Олон улсын стандартууд нь гарын үсэг зурсан талууд, олон улсын Засгийн газрууд болон бусад сонирхол бүхий оролцогч талуудтай зөвшилцсөний үндсэн дээр мэргэжлийн шинжээчдээр боловсруулагдан бие даасан бичиг баримт болон хэвлэгдэн гарна. ДДЭА-ийн гүйцэтгэх хороо нь энэхүү Хуулинд ямар нэгэн нэмэлт өөрчлөлт оруулахгүйгээр олон улсын стандартуудад хугацааны нэмэлт өөрчлөлтүүдийг оруулдаг байх нь чухал юм.*

## Шилдэг туршлагын загварууд болон удирдамжууд

Шилдэг туршлагын загварууд болон удирдамжуудыг Хууль болон олон улсын стандарт дээр үндэслэн допингийн эсрэг аливаа салбарт шийдлийг хангахад боловсруулна. Эдгээр загварууд болон удирдамжууд нь ДДЭА-аас санал болгосон байх бөгөөд гарын үсэг зурсан талууд болон сонирхол бүхий оролцогчдод хүртээмжтэй байх хэдий ч заавал биелүүлэх ёстой зүйл биш юм. Допингийн эсрэг бичиг баримтуудын загваруудыг олгохоос гадна гарын үсэг зурсан талуудад зориулсан зарим сургалт, туслалцааг ДДЭА-аас зохион байгуулан явуулна.

*Тайлбар: Сонирхол бүхий оролцогч талууд эдгээр загвар бичиг баримтуудын хувилбаруудаас сонголтхийх боломжтой байна. Зарим оролцогч талууд эдгээр бичиг баримтуудыг хамгийн анхны хувилбараар нь хүлээж авах сонирхолтой байдаг бол нөгөө хэсэг нь нэмэлт өөрчлөлт оруулсан хувилбарыг сонгох боломжтой. Бусад оролцогч талууд нь өөрийнхөө шаардлагыг Хуулийн ерөнхий зарчим болон зохих шаардлаганд нийцүүлэн энэ хувилбаруудад тусган боловсруулж болно. Допингийн эсрэг хурээний загвар бичиг баримт болон удирдамжсууд нь сонирхол бүхий оролцогч талуудын хүсэл зорилго болон шаардлагуудад нийцүүлэн боловсруулагдсан байх бөгөөд нэмэлт өөрчлөлтүүд нь ч түүнд нийцсэн байна.*

## Дэлхийн допингийн эсрэг хуулийн үндсэн ухагдахуун

Допингийн эсрэг хөтөлбөрүүд нь спортын мөн чанар болсон үнэт зүйлсийг хадгалах зорилготой. Энэ нь Олимпизмийн гол мөн чанар бөгөөд хувь хүн бүрийн байгалаас заясан авьяас чадварын цогцод тулгуурлан хүн төрөлхтөний төгс байдалд тэмүүлэх хүсэл юм. Энэ нь “Бид хэрхэн шударга өрсөлдөх вэ?” гэсэн ойлголт юм. Спортын мөн чанар нь хүний оюун санаа, бие бялдар, ухаан бодол юм. Үүнийг спортом дараах үнэт зүйлсээр илэрхийвэл:

- Есзүй, шудрага өрсөлдөөн, шударга байдал
- Эрүүл мэнд
- Төгс гүйцэтгэл
- Зан чанар ба боловсрол

- Баяр баясгалан
- Багийн тоглолт
- Чин сэтгэлээсээ хандах
- Хууль дүрмийг хүндэтгэх
- Өөрийгөө болон бусад оролцогчдыг хүндэтгэх
- Эр зориг
- Олон нийт ба эв нэгдэл

Допинг нь спортын мөн чанарт сөрөг нөлөөтэй юм. Спортын мөн чанарыг хөгжүүлэх замаар допингийн эсрэг тэмцэхдээ энэхүү Хууль нь Допингийн Эсрэг Байгууллага бүрээс тамирчид, залуу тамирчид болон тамирчдыг дэмжигч этгүүдүүдэд зориулсан допингийн эсрэг боловсрол олгох, түүнээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлэхийг шаарддаг юм.

## **НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: ДОПИНГИЙН ХЯНАЛТ ТАНИЛЦУУЛГА**

Хуулийн нэгдүгээр хэсэг нь өөрийн эрх мэдлийн хүрээнд допингийн эсрэг хууль боловсруулах, ашиглах, хэрэгжүүлэх үүрэгтэй Олон улсын Олимпийн Хороо, Олон Улсын Паралимпийн хороо, Олон улсын холбоод, Үндэсний Олимпийн Хороод, Паралимпийн хороод, томоохон үйл ажиллагаа зохион байгуулагчид болон Допингийн Эсрэг Үндэсний Байгууллагууд зэрэг байгууллагуудаас дагаж мөрдөх допингийн эсрэг тусгай хууль зарчмуудыг зааж өгсөн болно. Эдгээр байгууллагуудыг нийтэд нь Допингийн Эсрэг Байгууллага гэж нэрлэнэ.

Допингийн Эсрэг Байгууллага, Тамирчин, хувь хүн бүр энэхүү Хуулийн заалтуудыг заавал дагаж мөрдөх ёстой. Гэвч энэхүү хууль нь допингийн эсрэг байгууллага бүрийн хэрэгжүүлэх ёстой допингийн эсрэг тодорхой хуулиудтай байх хэрэгцээг солих ба үгүйсгэхгүй. Хуулийн зарим заалтуудыг Допингийн Эсрэг Байгууллага бүрийн дүрэмд өөрчлөхгүйгээр хэрэглэх боломжтой байхад зарим заалтууд нь допингийн эсрэг тухайн байгууллагын өөрийн дүрэмд тохируулан уян хатан байхыг зөвшөөрнө. Допингийн Эсрэг Байгууллага бүрээс зайлшгүй хүлээн зөвшөөрч,

мөрдөх ёстой заалтууд байдаг ч өөрийн дүрэмдээ давтан оруулах шаардлагагүй заалтууд байна. Допингийн эсрэг хууль нь тэмцээний дүрмийн адилаар тухайн тэмцээнийг зохион байгуулах спортын дүрэм юм. Тамирчид болон бусад этгээдүүд эдгээр дүрэм журмыг тэмцээнд оролцох нөхцөл болгон хүлээн авч захирагдах ёстой. Гарын үсэг зурсан тал бүр өөрийн удирдлаганд байдаг тамирчид, бусад этгээдүүд болон байгууллагуудад хүчин төгөлдөр байгаа допингийн эсрэг хуулийн талаар мэдэгдэж дагаж мөрдөхийг хүлээн зөвшөөрсөн өөрийн дүрэмтэй байна.

Гарын үсэг зурсан тал бүхэн өөрийн удирдлагад байдаг бүх тамирчид, бусад этгээдүүд болон өөрийн гишүүн байгууллагуудад хүчин төгөлдөр байгаа допингийн эсрэг хуулийн хүрээнд өөрсдийн тодорхой мэдээлэл баримтуудыг ирүүлэх ба эдгээр хуулийг дагаж мөрдөөгүй аливаа тамирчин болон бусад этгээдэд тодорхой үр дагавар үүсэхийг ойлгон хүлээн зөвшөөрсөн гэдгийг баталгаажуулах дүрэм журмыг бий болгоно. Дэлхийн хэмжээнд допингийн эсрэг хууль журмуудыг хэрэгжүүлэх зорилготой спортын тусгай дүрэм журмууд нь эрүүгийн болон иргэний хууль дүрмээс ялгаатай. Эдгээр нь аль нэг улс үндэстний шаардлага болон тухайн хууль журамтай холбоотой эрхзүйн стандартуудаар хязгаарлагдахгүй ч хүний эрх болон тэгш эрхийн зарчмуудыг баримтлана.

Аливаа баримтыг авч хэлэлцэх болон тухайн үүсгэсэн хэргийг авч үзэхдээ бүх шүүхүүд, шүүхийн зөвлөл болон бусад холбогдох байгууллагууд нь энэхүү хууль дахь допингийн эсрэг хуулиудын бодит байдал нь дэлхий дахинд спортын тэмцээн уралдаан үйл ажиллагааг шударга явуулах зорилготой бүх хүмүүсийн зөвшилцлийг илэрхийлдэг гэдгийг ойлгон хүндэтгэх ёстой.

*Тайлбар: Хуулийн 23.2.2 зүйлд Допингийн Эсрэг Байгууллага бүрийн дүрмэнд ямар нэг өөрчлөлтгүйгээр оруулах ёстой заалтууд орсон байна. Жишээ нь: бүх гарын үсэг зурсан орнууд өөрсдийн шийдвэрээ гаргахдаа допингийн эсрэг хууль зөрчсөн тохиолдуудын ижил жагсаалт, ижил баталгаа болон допингийн эсрэг тухайн хууль зөрчсөний төлөө ижил шийтгэл оногдуулна гэвэл зарим нэг хүндрэл үүсэх нь тодорхой. Эдгээр дүрэм журмууд нь Олон улсын холбооны өмнө, Үндэсний түвшинд буюу Спортын Арбитрын шүүх дээр хуралдаан болсон эсэхээс үл шалтгаалан ижил байх ёстой.*

Хуулийн 23.2.2-т заагаагүй зүйл нь Допингийн эсрэг байгууллагаас нэг бүрчлэн дүрмэндээ оруулахыг шаардахгүй хэдий ч заавал дагаж мөрдөх зүйлүүд юм. Эдгээр дүрэм хоёр зүйлд хуваагдана: Нэгдүгээрт, зарим заалтууд нь Допингийн Эсрэг Байгууллагууд нь өөрийн дүрмэндээ давтан оруулах шаардлагагүй. Хоёрдугаарт, зарим заалтууд нь Допингийн Эсрэг Байгууллагууд нь заавал мөрдөх шаардлагатай ч уян хатнаар хэрэгжүүлэх боломж олгодог юм. Жишээлбэл, бүх гарын үсэг зурсан талуудыг ижил шаардлага тавих зорилгоор нэг ижил үр дүнгийн менежмент болон хэлэлцүүлгийн журам ашиглах шаардлагагүй. Орчин үед олон улсын холбоод болон үндэсний байгууллагуудын хүрээнд үр дүнгийн менежмент болон хэлэлцүүлгийн үйл ажилагааны харилцаан ижил үр дүнтэй маш олон үйл ажиллагаабайдал болсон. Энэхүү хуулиар үр дүнгийн менежмент болон хэлэлцүүлгийн үйл ажилагааг яг ижилхэн нэг загвартай байхыг шаардлаггүй ч гарын үсэг зурсан талуудаас ашиглах байгаа төрөл бүрийн аргууд нь хуульд заасан зарчмуудыг хангасан байхыг шаарддаг.

## **1-р зүйл: Допингийн тодорхойлолт**

Допинг гэдэг нь энэхүү Хуулийн 2.1-2.10 зүйлүүдэд заасан допингийн эсрэг хуулийг зөрчсөн нэг буюу хэд хэдэн тохиолдлыг хэлнэ.

## **2-р зүйл: Допингийн эсрэг хуулийн зөрчил**

Хоёрдугаар зүйл нь Допингийн эсрэг хууль зөрчсөн нөхцөл байдал болон үйлдлийг тодорхойлон заах зорилготой. Допингийн хэргийн хэлэлцүүлэг нь энэхүү Хуулийн нэг буюу хэд хэдэн заалтыг зөрчсөн нөхцөл байдал дээр үндэслэн хийгдэнэ. Тамирчид болон бусад этгээдүүд нь Допингийн эсрэг дүрмийн зөрчил, хориотой жагсаалтад орсон бодис болон хориотой аргуудыг мэдээгүйгээс үүдсэн үйлдэлдээ хариуцлага хүлээнэ. Дараах тохиолдолд допингийн эсрэг хууль зөрчсөн гэж үзнэ. Үүнд:

2.1. Тамирчнаас авсан дээжинд хориотой бодис, түүний метаболитууд, маркерууд илрэх

2.1.1. Тамирчин бүр өөрийн биед хориотой бодис ороогүй гэдгийг баталгаажуулах үүрэгтэй. Тамирчин нь өөрийн

биед хийсэн шинжилгэээр илэрсэн аливаа хориотой бодис, түүний метаболит болон маркеруудын төлөө хариуцлага хүлээнэ. Тиймээс энэхүү хуулийн 2.1 хэсэгт заасан допингийн эсрэг хууль зөрчсөнийг тогтоохын тулд тамирчны зүгээс санаатай буюу санамсаргүй байдлаар эсвэл мэдсээр байж тухайн бүтээгдэхүүнийг хэрэглэсэн эсэхийг тодруулах шаардлагагүй.

**2.1.1 зүйлд хийх тайлбар:** Энэхүү хуульд зааснаар допингийн эсрэг хууль зөрчсөн нь тамирчны алдаатай үйлдэл байсан эсэхээс үл хамааран зөрчил хэмээн тооцогдоно. Энэхүү хуулийг спортын холбогдолтой аливаа хэргүүдэд шийдвэр гаргахад “Хатуу хариуцлага”-тай болгон ашиглана. Тамирчны алдаатай үйлдлийг 10-р зүйлд заасанчлан допингийн эсрэг хууль зөрчсөнөөс ямар үр дагавар гаражыг тооцоолоход ашиглана. Энэхүү хуулийг Спортын Арбитрийн Шүүхээс байнга шинэчилж байх болно.

**2.1.2.** Энэхүү хуулийн 2.1-р зүйлд заасан допингийн эсрэг хууль зөрчсөн гэсэн хангалттай баталгааг дараах байдлаар нотлон гаргана. Үүнд: Тамирчин В шинжилгээнээс татгалзан, В шинжилгээг хийлгээгүй тохиолдолд тамирчны “А” шинжилгээнд илэрсэн хориотой бодис, түүний метаболитууд болон маркерууд эсвэл В шинжилгээг хийсэн тохиолдолд В шинжилгээний хариугаар тамирчны биед “А” шинжилгээнд илэрсэн хориотой бодис, түүний метаболитууд болон шинж тэмдгүүд байсан гэдгийг баталсан, эсвэл тамирчны В шинжилгээг хоёр хуруу шилэнд хуваан хийсэн ба хоёр дахь хуруу шилний шинжилгээгээр нэг дэх хуруу шилэнд илэрсэн хориотой бодис, түүний метаболитууд болон маркерууд байгаа нь батлагдсан.

**2.1.3.** Хориотой жагсаалтад багтсан тодорхой хэмжээ ширхэг заасан хориотой бүтээгдэхүүн бодисын тоо хэмжээг зааснаас бусад тохиолдолд аливаа тооны хориотой бодис, түүний метаболитууд болон маркерууд тамирчнаас авсан дээжинд илэрсэн нь допингийн эсрэг хууль зөрчсөн гэж үзнэ.

2.1.4. Энэхүү хуулийн 2.1 зүйлд заасан ерөнхий журмаас гажин хориотой жагсаалт болон Олон улсын стандартууд нь эндогений үүсэж болох хориотой бодисыг үнэлэх тусгай үнэлгээ гаргаж болно.

*2.1.2 зүйлд хийх тайлбар: Допингийн эсрэг байгууллага нь өөрийн менежментийн хариуцлагын хүрээнд өөрийн сонголтоор В дээжийн талаар тамирчин шинжилгээ хийлгэх хүсэлт гаргаж болно.*

## 2.2. Тамирчин хориотой бодис буюу хориотой арга хэрэглэх буюу хэрэглэхийг завдах

2.2.1. Тамирчин бүр өөрийн биед ямар нэгэн хориотой бодис ороогүй бөгөөд ямар нэгэн хориотой аргыг хэрэглээгүй гэдгийг баталгаажуулах үүрэгтэй. Тиймээс хориотой бодис хэрэглэх буюу хориотой арга ашиглах талаар допингийн эсрэг хууль зөрчсөн, алдаатай, санаандгүй, эсвэл зориудын үйлдэл байх ёсгүй.

2.2.2. Хориотой бодис хэрэглэх буюу хориотой арга хэрэглэх үйлдэл амжилттай буюу амжилтгүй болсон нь хамааралгүй. Хориотой бодис буюу хориотой арга хэрэглэх буюу хэрэглэхийг завдсан нь допингийн эсрэг хууль зөрчсөн үйлдэл болоход хангалттай.

*2.2 зүйлд хийх тайлбар: Хориотой бодис хэрэглэхийг завдах буюу хориотой арга хэрэглэсэн гэдэгт тамирчныг буруутгахад нотлох баримтыг зайлшгүй хэрэгтэй. 3.2 зүйлд хийсэн тайлбарт тэмдэглэснээр 2.1 зүйлд заасан допингийн эсрэг хууль зөрчсөнийг тогтооход шаардлагатай нотолгооноос ялгаатай нь хэрэглэсэн буюу хэрэглэхийг завдсаныг тамирчнаас буруутай үйлдлээ хүлээн зөвшөөрөх, гэрчийн мэдүүлэг, баримтаар нотлох, тамирчны биологийн паспорт болон 2.1 зүйлд заасан хориотой бодис байгааг нотлох бүх шаардлагыг хангахгүй байгаа аналитик мэдээ зэргийн нэг хэсэг болгон цуглувансан мэдээллүүд гэх мэтийн бусад аргаар тогтоосон.*

*Жишээ нь: (В дээжийг дахин авч баталгаажуулахгүйгээр) А дээжээс авсан дээжийн дүгнэлтэнд үндэслэн эсвэл бусад дээжинд нотолгоо дутуу байна гэдгийг хангалттай баталсан тохиолдолд В дээжээс дангаар нь авсан дүгнэлтэнд үндэслэн*

*Хориотой бодис буюу арга хэрэглэсэн гэдгийг тогтоож болно.*

*2.2.2 зүйлд хийх тайлбар: Хориотой бодис хэрэглэх буюу хориотой арга хэрэглэхийг завдсан гэдгийг нотлоход тухайн хориотой бодис буюу арга хэрэглэхийг завдсан гэдгийг батлах шаардлагатай болдог. Дотингийн эсрэг хууль зөрчсөнийг энэхүү хуулийн 2.1 болон 2.2 зүйлүүдийг зөрчин хориотой бодис хэрэглэх буюу хориотой арга хэрэглэхийг завдсан зөрчлийг тогтоох хатуу зарчмыг бууруулдаггүй. Тэмцээний бус үед тухайн бодисыг хэрэглэхийг зөвшөөрсөн бөгөөд тамирчин тэмцээнд ороогүй үедээ тухайн бодис ашигласнаас бусад тохиолдолд дотингийн эсрэг хуулийн зөрчилд тооцогдоно. (Гэхдээ тэмцээний үеэр авсан дээжинд хориотой бодис, маркер болон метаболит илэрсэн нь тухайн бодисыг хэзээ хэрэглэснээс үл шалтгаалан допингийн эсрэг хууль зөрчсөнд тооцно.)*

### **2.3. Дээж өгөхөөс зугтаах, татгалзах буюу дээж өгөхгүй байх**

Холбогдох допингийн эсрэг хуульд зөвшөөрснөөр мэдэгдэл өгсөний дараа дээж өгөхөөс зугтаах буюу хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр дээж өгөхөөс татгалзах буюу дээж өгөхгүй байх

### **2.4. Бусад алдаа**

12 сарын хугацаанд бүртгэлтэй шинжилгээний хэсэг дэх аль нэг тамирчин нь гурван шинжилгээг дараалан алгассан буюу алдаатай мэдээлэл оруулах

### **2.5. Допингийн хяналтын аль нэг хэсгийг хуурамчаар үйлдэх буюу хуурамчаар үйлдэхийг оролдох**

Допингийн хяналтын үйл ажиллагааг бүтэн өөрчилсөн ч хориотой аргуудын тодорхойлолтонд багтаагүй аливаа үйлдлийг хэлнэ. Хуурамчаар үйлдэх гэдэгт допингийн хяналтыг санаатайгаар зөрчих буюу зөрчихийг оролдох, допингийн эсрэг байгууллагад хуурамч мэдээлэл өгөх, чухал гэрчүүдтэй ойрхон байх буюу ойрхон байхыг оролдох гэх мэтийн үйлдлүүдийг багтаана.

*2.3 зүйлд хийх тайлбар: Жишээ нь: Тамирчин нь допингийн эсрэг байгууллагын ажилтанд мэдэгдэл өгөх буюу шинжилгээ өгөхөөс сайн дураар зайлсхийж байсан нь тогтоогдвол допингийн эсрэг хууль зөрчсөн гэж тооцно. “Дээж өгөхөөс зайлсхийн” дүрэм зөрчсөн нь тамирчны санаатай буюу санамсаргүй үйлдлээс үл хамаарах тул дээж өгөхөөс зайлсхийх*

*буюу зугтаахыг тамирчны санаатай үйлдэл хэмээн тооцдог.*

**2.5 зүйлд хийх тайлбар:** Жишээ нь: энэхүү заалт нь шинжилгээний явцад дээжийн хяналтын хуудас дээрх хувийн дугаарыг засварлах, В дээжийг авах уед В хуруу шилийг хагалах, эсвэл гадны шингэн нэмэх замаар дээжийг өөрчлөх зэрэг үйлдэл хийхийг хориглодог. Дотингийн хяналтын үйл ажиллагаанд оролцож байгаа допингийн ажилтан болон бусад этгээдийн эсрэг хийсэн хүч хэрэглэсэн үйлдэл нь алдаатай үйлдэлд багтахгүй бол тухайн спортын байгууллагыг сахилгын журамтай холбогдуулан авч үзнэ.

## 2.6. Хориотой арга буюу хориотой бодис эзэмших

**2.6.1.** Тэмцээнд оролцож байгаа тамирчин ямар нэгэн хориотой арга буюу хориотой бодис эзэмших эсвэл тэмцээнд оролцоогүй тамирчин энэхүү хуулийн 4.4 хэсэгт заасан эмчилгээний зориулалтаар тусгай хэрэглэж байгаагаас бусад тохиолдолд тэмцээнээс гадуур эзэмшихийг хориглосон хориотой бодисыг эзэмшсэн буюу бусад хүлээн зөвшөөрөгдөх хэлбэрээр хэрэглэсэн гэдгээ батлаж чадахгүй байгаа тохиолдолд хориотой бодис буюу хориотой арга хэрэглэсэн гэж үзнэ.

**2.6.2.** Тамирчныг дэмжиж байгаа этгээд ямар нэгэн хориотой арга буюу хориотой бодис эзэмших эсвэл тэмцээнд оролцоогүй тамирчинг дэмжиж байгаа этгээд энэхүү хуулийн 4.4 хэсэгт заасан эмчилгээний зориулалтаар тусгай хэрэглэж байгаагаас бусад тохиолдолд тэмцээнээс гадуур эзэмшихийг хориглосон хориотой бодисыг эзэмшсэн буюу бусад хүлээн зөвшөөрөгдөх хэлбэрээр хэрэглэсэн гэдгээ батлаж чадахгүй байгаа тохиолдолд хориотой бодис буюу хориотой арга хэрэглэсэн гэж үзнэ.

## 2.7. Хориотой арга буюу хориотой бодис хил давуулан наймаалсан буюу хил давуулан наймаалахыг оролдох

**2.6.1 болон 2.6.2 зүйлүүдийн тайлбар:** хүлээн зөвшөөрөгдөх шалтгаан гэдэгт жишээ нь эмнэлгийн ямар нэгийн нөхцөлд аль нэг найз буюу хамаатан садан эмчийн зааварчилгаагаар тухайн бодисыг эзэмшиж, жишээ нь: диабеттэй хүүхдэд

*инсулин худалдан авах гэх мэтээр эмнэлгийн нөхцөл байдлаас бусад тохиолдолд хориотой бодисыг наиз нөхөд болон хамаатан садандаа өгөх зорилгоор эзэмших буюу худалдан авах үйлдлийг багтааж үзэхгүй.*

*2.6.2 зүйлийн тайлбар: хүлээн зөвшөөрөгдөх шалтгаан гэдэгт жишээ нь хүриц буюу гэнэтийн нөхцөл байдалтай тэмцэхээр хориотой бодис авч яваа багийн эмчийг багтааж үзнэ.*

2.8. Аливаа тэмцээнд оролцож байгаа тамирчинд хориотой бодис буюу хориотой арга хэрэглэхийг зааварчилсан буюу зааварчилахыг оролдсон, эсвэл тэмцээнд оролцоогүй байгаа тамирчинд тэмцээний бус үед хэрэглэхийг хориглосон аливаа хориотой бодис, хориотой арга хэрэглэхийг зааварчилсан буюу зааварчилахыг оролдох

## 2.9. Хамжих

Допингийн эсрэг хууль зөрчиж байгаа үйлдэлд туслах, зоригжуулах, тусlamж үзүүлэх, хамсаатан болох, хуйвалдах, нуух, болон бусад байдлаар допингийн эсрэг үйлд санаатайгаар хамжин оролцох эсвэл өөр этгээдээс энэхүү хуулийн 10.12.1 зүйлийн заалтыг зөрчих буюу допингийн эсрэг хууль зөрчихийг оролдох

## 2.10. Хориотой холбоо

Тамирчин буюу бусад этгээд Допингийн эсрэг байгууллагын мэргэжлийн болон спортын холбоотой ямар нэгэн албан тушаалд байгаа тамирчныг дэмжих этгээдтэй холбоо тогтоосон нь

2.10.1. Допингийн эсрэг байгууллагын эрх мэдэлтэй холбоотой бол эрх хасуулсан хугацаанд үйлчилнэ.

2.10.2. Допингийн эсрэг байгууллагын эрх мэдэлтэй холбоогүй бол хуулийн дагуу эрх хасуулсан нь үр дүнгийн менежментээс шалтгаалаагүй тохиолдолд эрүүгийн, сахилгын болон мэргэжлийн ёс журам зөрчигдсөн ба тухайн журамтай холбоотой заалтууд нь тухайн этгээдтэй хамааралтай бол допингийн эсрэг хууль зөрчигдсөн гэж үзнэ. Тухайн этгээдийн эрх хасуулсан нөхцөл байдал нь эрүүгийн, мэргэжлийн болон сахилгын шийдвэрээр буюу тухайн оногдуулсан эрүүгийн, мэргэжлийн болон

сахилгын шийдвэрийн нөхцлийн дагуу 6-аас дээш жил хүчин төгөлдөр байна.

2.10.3. Энэхүү хуулийн 2.10.1 болон 2.10.2 зүйлүүдэд заасан хувь хүний зуучлагч буюу нэрийн өмнөөс үйлчилж байгаа. Энэхүү хуулийг хэрэгжүүлэхийн тулд тамирчин буюу бусад этгээдэд допингийн эсрэг байгууллагаас урьд нь тухайн тамирчин буюу этгээдэд оногдуулах шийтгэлийн талаар бичгээр мэдэгдэж байсан буюу ДДЭА-аас тамирчныг дэмжих этгээдэд эрх хасах буюу хориотой холбооноос томоохон хохирол учруулсан буюу тухайн тамирчин, бусад этгээд тухайн холбооноос зайлсхийж чадаж байсан байх шаардлагатай. Допингийн эсрэг байгууллага нь тамирчныг дэмжих этгээдэд тамирчин буюу бусад этгээдэд энэхүү хуулийн 2.10.1 болон 2.10.2 зүйлүүдэд заасан үзүүлэлт нь өөрт нь хамааралгүй талаар тайлбар хийх боломжтойг тайлбарлаж болно. (25-р зүйлд заасан хүчин төгөлдөр болох хугацаанаас өмнө тамирчныг дэмжих этгээдийн эрх хасах хугацаа тохиолдсон үед 17-р зүйлд хамааралгүйгээр энэхүү заалт нь үйлчилнэ). Тамирчин буюу бусад этгээдээс холбоо тогтоосон энэхүү хуулийн 2.10.1 болон 2.10.2 зүйлүүдэд заасан тамирчныг дэмжих этгээд нь мэргэжлийн буюу спортын холбоотой албан тушаалд байхгүй тохиолдолд энэхүү саад бэрхшээл үүснэ. Энэхүү хуулийн 2.10.1, 2.10.2 болон 2.10.3 зүйлүүдэд заасан шаардлагад нийцэх тамирчныг дэмжих этгээдийн талаар мэдэх допингийн эсрэг байгууллага нь тухайн мэдээллийг ДДЭА-д хүргүүлнэ.

*2.10 зүйлд хийх тайлбар: Тамирчин болон бусад этгээд нь допингийн эсрэг хууль зөрчсөн буюу допингтэй холбоотой хэргээр эрүүгийн хариуцлага хүлээж байсан шүүгч, дасгалжуулагч, эмч болон бусад тамирчдыг дэмжих этгээдтэй хамтран ажиллах ёсгүй. Ийм хориотой төрлийн холбоонд дараах зүйлс багтдаг. Үнд: сургалт, стратеги, техник, хоол тэмжээл болон эрүүл мэндийн зөвлөгөө, эмчилгээ авах, шинжилгээнд аливаа биеийн бодис өгөх, эсвэл тамирчныг дэмжих этгээдэд төлөөлөгч буюу агентаар ажиллах боломж олгох г.м. Хориотой холбоо нь аль нэг төрлийн нөхөн төлбөр багтаах албагүй.*

## **3-р зүйл: Допингийн нотолгоо**

### **3.1. Допингийг нотлох стандарт, үндсэн санаанууд**

Допингийн эсрэг байгууллага нь допингийн эсрэг хууль зөрчигдсөн гэдгийг тогтоох үндсэн баримталдаг бодлоготой байх ёстой. Допингийг тогтоох стандарт нь допингийн эсрэг байгууллагаас допингийн эсрэг хууль зөрчигдсөнийг зөвлөлд танилцуулан тухайн зөрчил нь хир зэрэг ноцтой байсныг тайлбарлан өгдөг. Ямар ч тохиолдолд ийм стандарт баталгаа нь энгийн магадлалын онолын үзүүлэлтээс илүү олон байдаг ч магадлалын тэнцвэр нь тухайн асуудлыг эргэлзээтэй байдлаас гарах арга замыг зааж өгдөг. Тухайн журамд тамирчин болон бусад этгээдийн эсрэг гаргасан аливаа гомдлыг баталгаажуулах нотлох баримтыг олохдоо тодорхой нөхцөл байдалд үндэслэн баталгаа гаргах стандарт нь магадлалын тэнцвэрээс илүү бөгөөд тодорхой эргэлзээг давсан баталгаа болдоггүй. Энэхүү хууль нь допингийн эсрэг хууль зөрчсөн тамирчин буюу бусад этгээдийн талаар баталгаа гаргаж байсан буюу тодорхой нөхцөл байдлыг бий болгож байгаа үед баталгааны стандарт нь магадлалын тэнцвэр байна.

*3.1 зүйлд хийх тайлбар: Допингийн эсрэг байгууллагаас дагаж мөрдөх шаардлагатай энэхүү баталгааны стандарт нь мэргэжлийн алдаа гаргасан хэрэгтэй холбоотойгоор ихэнх орнуудад дагаж мөрддөг стандарттай ижил.*

### **3.2. Баримтыг нотлох, дүгнэлт гаргах аргууд**

Допингийн эсрэг хууль зөрчсөнтэй холбоотой баримтыг хүлээн зөвшөөрүүлэх гэх мэтийн зарим баталгаатай аргаар тогтоож болно. Допингийн хэрэгт дараах баталгааны журмуудыг баримтална. Үүнд:

**3.2.1. ДДЭА-аас холбогдох шинжлэх ухааны болон судалгааны байгууллагуудтай зөвшилцсөний үндсэн дээр баталсан болон зэрэгцэн хянах ёстой шийдвэрийн хязгаар буюу аналитик арга нь шинжлэх ухааны хувьд хүчин төгөлдөр байх ёстой гэж үздэг. Ийм шинжлэх ухааны дүгнэлт гаргуулахыг хүссэн аливаа тамирчин буюу бусад этгээд нь аливаа асуудлын урьдчилсан нөхцөл болгож тухайн асуудал болон түүний үндэслэлийн талаар ДДЭА**

-д эхлэн мэдэгднэ. Спортын арбитрын шүүх нь өөрийн санаачлагаар бас ДДЭА-д бас энэ нөхцөл байдлын талаар мэдэгдэж болно. ДДЭА-ийн хүсэлтээр Спортын арбитрын шүүхийн зөвлөл нь тухайн асуудлыг шийдвэрлэх талаар зөвлөлд туслалцаа үзүүлэх холбогдох мэргэжлийн шинжээчийг томилон ажиллуулна. ДДЭА-с энэ мэдэгдлийг хүлээн авсан ба Спортын арбитрын шүүхийн файлыг ДДЭА хүлээн авсанаас хойш 10 хоногийн дотор ДДЭА нь нэг оролцогч болон хуралдаанд оролzon нотлох баримтуудыг холбогдох хуулийн дагуу хүргүүлэх эрхтэй.

3.2.2. ДДЭА-аас магадлан итгэмжлэгдсэн лабораториуд болон ДДЭА-аас хүлээн зөвшөөрсөн бусад лабораториуд дээжийн шинжилгээ болон бусад үйлдлүүдийг олон улсын лабораторийн стандартуудын дагуу хийнэ. Тамирчин болон бусад этгээд нь сөрөг аналитик дүн гарсан хэмээн үзсэн тохиолдолд олон улсын лабораторийн стандартыг зөрчсөн гэсэн саналыг гаргаж болно.

Хэрэв тамирчин буюу бусад этгээд нь өмнөх дүгнэлтээс татгалzan сөрөг анализиз шинжилгээ гарсан хэмээн үзвэл Допингийн Эсрэг Байгууллагаас тухайн үйлдэл нь сөрөг аналитик хариу гаргаагүй гэсэн дүгнэлтийг гаргаж болно.

*3.2.2 зүйлд хийх тайлбар: Гаргасан дүгнэлтээр магадлалын онолын дагуу тамирчин буюу бусад этгээдээс сөрөг аналитик дүн гарсан хэмээн үзсэн тохиолдолд олон улсын лабораторийн стандартыг зөрчсөн гэсэн саналыг гаргахад нөлөө орж болно. Хэрэв тамирчин буюу бусад этгээд ингээж үзсэн тохиолдолд тухайн асуудлыг олон улсын допингийн эсрэг байгууллагад хандан энэхүү татгалзсан үйлдэл нь сөрөг аналитик дүн гарахад нөлөөлөөгүй гэсэн зөвлөлийн хангалттай баталгааг гаргуулж болно.*

3.2.3. Аливаа бусад олон улсын стандарт, Допингийн эсрэг хууль, Допингийн Эсрэг Байгууллагын бусад допингийн эсрэг бодлого журмаас зайлсхийсэн нь сөрөг аналитик үр дүн буюу аливаа допингийн эсрэг хууль зөрчсөн гэсэн хариуг гаргаагүй нь тухайн шинжилгээний хариу болон баримтыг хүчин төгөлдөр болгохгүй. Хэрэв тамирчин буюу бусад этгээд нь аливаа олон улсын стандарт,

допингийн эсрэг хууль болон бодлогоос зайлсхийсэн нь сөрөг аналитик үр дүн буюу аливаа сэргээшийн журам зөрчсөн гэсэн хариуг гаргах шалтгаан болсон бол Допингийн Эсрэг Байгууллага нь тухайн зайлсхийх үйлдэл нь сөрөг аналитик үзүүлэлт буюу допингийн эсрэг хууль зөрчсөн бодит үндэслэл болохгүй гэсэн эсэргүүцлийг гаргана.

3.2.4. Хэрэв шүүх буюу эрх мэдэл бүхий сахилгын мэргэжлийн зөвлөлөөс гаргасан шийдвэрээр тогтоосон баримт нь давж заалдах боломжгүй бөгөөд энэ нь энгийн шүүхийн буюу шударга ёсны зарчмыг ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд тамирчин болон бусад этгээдийн эсрэг маргашгүй нотолгоо болно.

3.2.5. Шийдвэр гаргах зөвлөл нь допингийн эсрэг хууль зөрчсөн талаар Допингийн Эсрэг Байгууллага болон (тус зөвлөлөөс гаргасан аливаа асуултад хариулах, эсвэл тус зөвлөлөөс гаргасан зааварчилгааны дагуу биечлэн буюу утсаар) Зөвлөлд хуралдаанд оролцох, хуралдаан болохоос өмнө тодорхой заагдсан хугацаанд гаргасан шийдвэрийн дараагаар тамирчин буюу бусадэтгээдийн татгалзсан үйлдэлд тулгуурлан допингийн эсрэг хууль зөрчсөн гэж үзээд байгаа тамирчин буюу бусад этгээдийн талаар тайлбар тодорхойлолт гаргаж болно.

## **4-р зүйл: Хориотой жагсаалт**

### **4.1. Хориотой жагсаалтыг хянах, хэвлэх**

ДДЭА нь шаардлагатай тохиолдолд буюу жилээс хэтрэхгүй хугацаанд олон улсын стандарт болгон хориотой жагсаалтыг гарган өгнө. Хориотой жагсаалтын санал болгож байгаа агуулга болон бүх засварыг бүх гарын үсэг зурсан талууд болон улс орнуудын засгийн газарт бичгэн хэлбэрээр нэн даруй хүргүүлнэ. Жил бүрийн гаргасан хориотой жагсаалт болон засваруудыг ДДЭА-аас гарын үсэг зурсан талууд, ДДЭА-ийн итгэмжлэгдсэн болон баталгаат лабораториуд, улс орнуудын засгийн газарт нэн даруй тараан ДДЭА-ийн вебсайтад хэвлэн гарын үсэг зурсан тал бүр нь өөрийн гишүүд болон бусад этгээдүүдэд тараах бүх шаардлагатай арга хэмжээг авна. Хориотой жагсаалт

болон түүний нэмж зассан хувилбаруудад өөрөөр заагаагүй бол Допингийн Эсрэг Байгууллага бүрийн дүрмийн дагуу тухайн хориотой бодисын жагсаалт болон түүний нэмж зассан хувилбарууд нь хэвлэгдэн гарсанаас хойш гурван сарын хугацаанд хүчин төгөлдөр болно.

*4.1 хэсэгт хийх тайлбар: Хориотой жагсаалтыг шаардлагатай гэж үзсэн үедээ хянан шинэчилж хэвлүүлнэ. Гэхдээ магадлалыг нэмэгдүүлэх зорилгоор шинэ хориотой жагсаалтыг шинэчлэгдсэн эсэхээс үл хамааран жил бүр хэвлэн гаргана. ДДЭА нь байнга хамгийн суулийн хориотой Жагсаалтын хувилбарыг өөрийн веб сайт дээр хэвлэн гаргана. Хориотой жагсаалт нь Спорт дах Допингийн эсрэг Олон Улсын Конвенцийн салшгүй хэсэг байна. ДДЭА нь ЮНЕСКО-гийн ерөнхий нарийн бичгийн даргад Хориотой жагсаалтад гарсан аливаа өөрчлөлтийн талаар мэдэгдэнэ.*

**4.2. Хориотой жагсаалтад заасан хориотой бодис буюу хориотой аргууд**

#### **4.2.1. Хориотой бодис буюу хориотой аргууд**

Хориотой жагсаалт нь тамирчдын цаашдын тэмцээн уралдаан болон тэдний уралдах потенциалд сөргөөр нөлөөлж болох (тэмцээний үеэр болон тэмцээний дараа) аль ч үед допинг хэмээн тооцогдох хориотой бодис болон хориотой аргууд, мөн зөвхөн тэмцээний үед хорилгох хориотой бодис болон хориотой аргуудыг тодорхойлно. ДДЭА нь зарим спорт дах хориотой жагсаалтыг өргөжүүлж, нэмэгдүүлж болно. Хориотой бодис болон хориотой аргад энгийн ангиллаар (Жишээ нь: зарим анаболик агентууд) буюу тусгай тайлбартай тусгай бодис буюу аргуудыг багтааж болно.

*4.2.1 зүйлд хийх тайлбар: Тэмцээний үеэр хэрэглэхийг хориглосон бодисыг тэмцээний бус үеэр хэрэглэх нь тухайн бодисын буюу түүний метаболитууд болон маркеруудын Сөрөг Аналитик хариу нь тэмцээний үеэр авсан дээжид илэрсэнээс бусад тохиолдолд допингийн эсрэг хуулийг зөрчсөнд тооцогдохгүй*

**4.2.2. Тусгай бодисууд:** 10-р зүйлийн заалтын зорилгоор хориотой жагсаалтад тодорхойлон заасан анаболик агентууд болон гормонууд, стимулянтууд болон гормоны

антогонистуудаас бусад бүх хориотой бодисуудыг тусгай бодисуудын жагсаалтад оруулна. Тусгай бодисуудын жагсаалт нь хориотой аргуудыг багтаахгүй.

*4.2.2 зүйлд хийх тайлбар: 4.2.2 хэсэгт заасан тусгай бодис нь бусад допингийн бодисуудаас бага ач холбогдолтой буюу бага аюултай хэмээн тооцогдохгүй. Гэхдээ эдгээр нь тамирчнаас спортын гүйцэтгэлээс бусад шалтгаанаар хэрэглэсэн энгийн бодис байдал.*

**4.2.3.** Хориотой бодисын шинэ бүлгүүд: ДДЭА-аас хориотой жагсаалтыг нэмэгдүүлэн 4.1 зүйлд заасанчлан хориотой бодисын шинэ төрөл нэмсэн тохиолдолд ДДЭА-ийн гүйцэтгэх Хороо нь хориотой бодисын шинэ төрөлд багтсан бүх хориотой бодисууд нь 4.2.2 зүйлд заасанчлан тусгай жагсаалтад орох хэсгийг тогтооно.

**4.3.** Хориотой жагсаалтад байгаа бодис болон аргуудын шалгуурууд

ДДЭА нь бодис буюу аргыг хориотой жагсаалтад оруулах эсэх дээр дараах шалгууруудыг авч үзнэ. Үүнд:

*4.3.1. ДДЭА нь тухайн бодис буюу арга нь дараах гурван шалгуур үзүүлэлтийн аливаа хоёрыг хангаж байна гэж өөрийн үндсэн тодорхойлолтоор үзвэл тухайн бүтээгдэхүүнийг аориотой жагсаалтад оруулна гэж үзнэ. Үүнд:*

*4.3.1.1. Эмнэлгийн болон бусад шинжлэх ухааны баримт нотолгоогоор, эм зүйн нөлөөлөл болон туршлагаар тухайн бүтээгдэхүүн буюу арга нь дангаараа буюу бусад бодис эсвэл аргатай хавсрان спортын гүйцэтгэлд эерэг нөлөө үзүүлэх чадалтай.*

*4.3.1.1 зүйлд хийх тайлбар: энэхүү зүйлд зааснаар зарим бодисыг дангаар нь хэрэглэхэд хориотой бодисийн жагсаалтад ордоггүй мөртлөө тодорхой өөр бодистой хавсруулан хэрэглэхэд хориотой жагсаалтад орж болно. Тиймээс бусад бодистой хавсруулан хэрэглэхэд хориотой бодисын жагсаалтад ордог бодисуудыг хориотой жагсаалтад оруулахдаа энэ талаар дурьдан хоёр бодисыг хамтруулан хэрэглэхийг хориглох ёстой*

4.3.1.2. Эмнэлгийн болон бусад шинжлэх ухааны баримт нотолгоогоор, эм зүйн нөлөөлөл болон туршлагаар тухайн бүтээгдэхүүн буюу аргыг ашиглах нь тамирчинд эрүүл мэндэд бодит буюу ноцтой эрсдэл үүсгэдэг.

4.3.1.3. ДДЭА-ийн тодорхойлсоноор тухайн бодис буюу аргыг ашиглах нь хуулийн оршил хэсэгт дурьдсан спортын уур амьсгалыг эвддэг.

4.3.2. Эмнэлгийн болон бусад шинжлэх ухааны баримт нотолгоогоор, эм зүйн нөлөөлөл болон туршлагаар тухайн бүтээгдэхүүн буюу аргыг хэрэглэх нь хориотой бодис буюу хориотой арга хэрэглэсэн мэт нөхцөл байдалд оруулах чадвартай гэдгийг ДДЭА-аас тодорхойлсон бол тухайн бодис буюу аргыг хориотой жагсаалтад оруулж болно.

*4.3.2 зүйлд хийх тайлбар: жил бүрийн үйл ажиллагааны хэсэг болгон бүх гарын зсэг зурсан талууд болон засгийн газрууд, бусад сонирхсон этгээдүүд хориотой жагсаалтын агуулгын талаар ДДЭА-д тайлбар хүргүүлж болно.*

4.3.3. ДДЭА-ийн тодорхойлсон хориотой жагсаалтад орох хориотой бодис болон хориотой аргын тодорхойлолт, хориотой жагсаалтад оруулах бодисуудын ангилаал, цаг үргэлж хориглох буюу зөвхөн тэмцээний үеэр хэрэглэхийг хориглох бодисуудын ангилаал зэрэг нь эцсийн шийдвэр байх тул аль нэг тамирчнаас гаргасан тухайн эм буюу арга нь ямар нэгэн нөлөөлөх бүтээгдэхүүн биш, гүйцэтгэлд нөлөөлдөггүй, эрүүл мэндийн эрсдэл байхгүй буюу спортын уур амьсгалыг зөрчөөгүй гэсэн тайлбаруудын үндсэн дээр өөрчлөгдөх буюу авч хэлэлцэх зүйл биш.

#### 4.4. Эмчилгээний зориулалтаар ашиглах

4.4.1. Эмчилгээний зориулалтаар ашиглах олон улсын стандартад заасны дагуу эмчилгээний зориулалтаар ашиглах журмыг зөрчөөгүй бол аливаа хориотой бодис, түүний метаболитууд буюу маркерууд байсан, хориотой бодис буюу хориотой аргыг ашигласан, ашиглахыг оролдсон, эзэмшсэн буюу хориотой бодис болон хориотой

аргыг удирдсан, удирдахыг завдсан нь допингийн эсрэг хууль зөрчсөнд тооцогдохгүй.

4.4.2. Олон улсын хэмжээний биш тамирчин нь дотоодын сэргээшийн эсрэг байгууллагадаа эмчилгээний зориулалтаар ашиглах бүтээгдэхүүний талаар өргөдөл гаргаж болно. Хэрэв допингийн эсрэг Үндэсний байгууллага нь өргөдлийг эсэргүүцсэн бол тухайн тамирчин нь энэхүү хуулийн 13.2.2 болон 13.2.3 зүйлүүдэд заасан үндэсний хэмжээний давж заалдах байгууллагад өргөдөл гаргаж болно.

4.4.3. Олон улсын хэмжээний тамирчин нь өөрийн Олон Улсын Холбоондоо өргөдөл гаргаж болно.

4.4.3.1. Тамирчин нь асуудалтай байгаа бодисын талаар Допингийн Эсрэг Үндэсний байгууллагаас гаргасан эмчилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрөлтэй бөгөөд эмчилгээний зориулалтаар ашиглах бодис нь эмчилгээний зориулалтаар ашиглах талаар олон улсын стандартад нийцэж байгаа бол Олон улсын холбоо нь үүнийг хүлээн зөвшөөрөх ёстой. Хэрэв тухайн эмчилгээний зориулалтаар ашиглах бодис нь дээрх шаадрлагад нийцэхгүй байна гэж олон улсын холбооноос үзэн хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан бол тамирчин буюу түүний Допингийн Эсрэг Үндэсний Байгууллагад энэ талаар холбогдох шалтгааны хамт нэн даруй мэдэгдэх ёстой.

Тамирчин буюу түүний Допингийн Эсрэг Үндэсний Байгууллага нь тухайн мэдэгдлийг хүлээн авсанаас хойш 21 хоногийн дотор ДДЭА-д хянуулахаар хандах ёстой. Хэрэв ДДЭА нь тухайн хэргийг хянаж үзэх бол Допингийн Эсрэг Үндэсний байгууллагаас олгсон эмчилгээний зориулалтаар ашиглах Зөвшөөрөл нь дотоодын түвшний тэмцээн болон тэмцээний үеийн шинжилгээний хувьд хүчин төгөлдөр хэвээр байна / гэвч олон улсын тэмцээнд хүчин төгөлдөр биш байна/ WADA-н шийдвэрийг хүлээж байна. Хэрэв асуудлыг WADA-с хянахгүй бол 21 хоногийн хянах хүчинтэй хугацаа дуусангут эмчилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрөл нь хүчин төгөлдөр биш болно.

#### **4.4.3.2. Хэрэв тамирчинд допингийн эсрэг үндэсний байгууллагаас урьд олгосон**

Эмчилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрөл байхгүй бол (4.4.3 зүйлд хийх тайлбар: Хэрэв олон улсын холбоо нь Допингийн Эсрэг Үндэсний Байгууллагаас хүлээн зөвшөөрсөн эмчилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрлийг Олон улсын эмчилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрлийн Стандартад заасан шаардлагыг хангахгүй эрүүл мэндийн бичиг болон бусад шаардлагатай мэдээлэл байхгүй гэсэн шалтгаанаар хүлээн авахаас татгалзсан бол тухайн асуудлыг ДДЭА хянаж үзэхгүй. Харин тухайн файлыг дахин бүрдүүлээд Олон Улсын Холбоонд дахин өгч болно.

Хэрэв Олон улсын холбоо нь олон улсын түвшний бус тамирчныг шалгаж үзэхээр сонгосон бол тухайн тамирчинд өөрийнх нь Допингийн Эсрэг үндэсний байгууллагаас олгосон эмчилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрлийг хүлээн зөвшөөрөх ёстой).

**4.4.4. Томоохон үйл явдал зохион байгуулахад тамирчид тухайн үйл явдалтай холбоотойгоор хоритой бодис буюу хориотой арга хэрэглэхийг хүсвэл тухайн тамирчнаас эмчилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрөл хүсэхийг шаардаж болно. Ийм тохиолдолд:**

**4.4.4.1. Томоохон үйл ажиллагаа зохион байгуулагчид нь тамирчинд /хэрэв байхгүй бол/ эмчилгээний зориулалтаар ашиглах звшөөрөл хүсэх боломжийг олгох ёстой. Хэрэв эмчилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрөл өгсөн бол энэ нь зөвхөн тухайн үйл ажиллагааны хувьд л хүчин төгөлдөр байна.**

**4.4.4.2. Хэрэв тамирчинд Допингийн эсрэг үндэсний байгууллагаас нь эмчилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрөл олгосон бол тухайн эмчилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрөл нь эмчилгээний зориулалтаар ашиглах тухай олон улсын стандартад нийцэж байгаа тохиолдолд томоохон үйл ажиллагаа зохион байгуулагчид нь энэ зөвшөөрлийг хүлээн зөвшөөрөх ёстой. Хэрэв томоохон үйл ажиллагаа зохион байгуулагч**

нь тухайн эмчилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрөл нь холбогдох шаардлагыг хангахгүй байна гэж үзэн түүнийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзвал энэ талаар тамирчинд нэн даруй мэдэгдэн холбогдох шалтгааныг нь тайлбарлах ёстой.

4.4.4.3. Тамирчин нь томоохон үйл ажиллагаа зохион байгуулагчдаас эмчилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрөл хүлээн зөвшөөрөхгүй байх буюу олгохгүй байх шийдвэрийг гаргах зорилгоор байгуулсан эсвэл томилсон бие даасан байгууллагаар гаргуулахаар хүсэлт тавьж болно. Хэрэв тамирчин нь хүсэлт гаргаагүй (гаргасан хүсэлт нь амжилтгүй болсон) бол тамирчин нь тухайн үйл ажиллагаатай холбоотой асуудалтай байгаа арга буюу бодисыг ашиглахгүй байж болно. Гэхдээ допингийн эсрэг үндэсний байгууллага болон олон улсын холбооноос олгосон эмчилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрөл нь тухайн үйл ажиллагаанаас гадуур хүчин төгөлдөр байна.

*4.4.4.3 зүйлд хийх тайлбар: жишээ нь: Спортын арбитрын шүүхийн AD, НОС хэсгээс буюу бусад ижил төрлийн байгууллагаас тодорхой үйл ажиллагааны бие даасан гомдол гаргах байгууллага байх бөгөөд ДДЭА нь тухайн уургийг гүйцэтгэхээр тохиролцож болно. Хэрэв Спортын арбитрын шүүх болон ДДЭА-ийн аль нь ч тухайн уургийг гүйцэтгэхгүй байгаа тохиолдолд ДДЭА нь 4.4.6.1 зүйлд заасанчлан аливаа Үйл Ажиллагаатай холбоотойгоор гаргасан Эмчилгээний Зориулалтаар Ашиглах Зөвшөөрлийг хянааж үзэх эрхийг эдлэнэ (гэхдээ заавал хийх албагүй)*

4.4.5. Хэрэв Допингийн Эсрэг Байгууллага нь олон улсын хэмжээний болон үндэсний хэмжээний тамирчин биш бөгөөд хориотой бодис буюу хориотой аргыг эмчилгээний зорилгоор ашиглаж байгаа этгээдээс дээж авахаар сонгосон бол Допингийн Эсрэг Байгууллага нь тухайн этгээдийг ретроактив эмчилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрөл авахаар өргөдөл гаргахыг зөвшөөрч болно.

4.4.6. ДДЭА нь Допингийн Эсрэг Үндэсний Байгууллагаас олгосон аливаа тамирчин буюу тамирчны допингийн эсрэг үндэсний байгууллагатай хамааралтай эмчилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрлийг хүлээн зөвшөөрөхгүй байх тухай Олон улсын холбооны шийдвэрийг хянаж үзэх ёстой. Түүнээс гадна тамирчны допингийн эсрэг үндэсний байгууллагатай хамааралтай эмчилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрлийг олгох талаар олон улсын холбооны шийдвэрийг ДДЭА хянаж үзэх ёстой. ДДЭА нь мөн бусад эмчилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрлийг олгох өөрийн санаачлагаар буюу аль нэг хохирогч талын хүсэлтээр хянаж үзэж болно. Хэрэв хянан үзсэн эмчилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрлийг олгох шийдвэр нь Олон улсын эмчилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрлийн стандартад нийцэж байвал ДДЭА нь үүнд хөндлөнгөөс оролцохгүй. Хэрэв эмчилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрлийг олгох шийдвэр нь дээрх стандартад нийцэхгүй бол ДДЭА нь үүнийг буцаана.

*4.4.6 зүйлд хийх тайлбар: ДДЭА нь 4.4.6 хэсгийн дагуу явуулах шаардлагатай бүх а. хяналтын үйл ажиллагааны болон б. Хянасан шийдвэр нь буцаагдсантай холбогдуулан явуулахаар сонгосон хяналтын үйл ажиллагаатай холбоотой бүх зардлыг гаргуулах эрхтэй.*

4.4.7. Тамирчин буюу Тамирчны Допингийн эсрэг үндэсний байгууллагаас Спортын арбитрын шүүхэд тусгайлан эмчилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрлийг олгохтой холбоотой олон улсын холбооны (эсвэл олон улсын холбооны нэрийн өмнөөс шийдвэр гаргахаар тохиролцсон бол үндэсний холбооны) гаргасан ДДЭА-аар хянуулаагүй буюу хянуулсан ч буцаагдсан аливаа шийдвэрийн талаар гомдол гаргаж болно.

*4.4.7 зүйлд хийх тайлбар: ийм тохиолдолд давж заалдаж байгаа шийдвэр нь Олон улсын холбооны эмчилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрлийн талаарх шийдвэр болохоос ДДЭА-ийн эмчилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрлийг хянах буюу буцаах шийдвэр биш. Гэхдээ*

*эмчилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрлийн тухай гаргасан шийдвэрийн эсрэг давж заалдах хугацаа нь ДДЭА-аас өөрийн шийдвэрийн талаар мэдээлэх өдөр хүртэл эмчилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрлийн талаар давж заалдах хугацаа эхлэхгүй. Ямар ч тохиолдолд ДДЭА-аас шийдвэрийг хянасан эсэхээс ул хамааран ДДЭА-д давж заалдах мэдэгдэл хүргүүлэн хэрэв боломжтой бол оролцуулна.*

**4.4.8.** ДДЭА-аас гаргасан шийдвэр нь эмчилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрлийн талаарх шийдвэрээс эсрэгээр гарсан бол тамирчин, Допингийн эсрэг үндэсний байгууллагаас буюу хохирсон олон улсын холбоноос тусгайлан Спортын арбитрын шүүхэд давж заалдаж болно.

**4.4.9.** Эмчилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрлийг хянах болон эмчилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрлийг хүлээн зөвшөөрөх/олгох талаар өргөдлийг хүлээн авсанаас хойш тодорхой хугацаанд холбогдох арга хэмжээг аваагүйг өргөдөл гаргахаас татгалзсан гэж үзнэ.

#### **4.5. Мониторингийн хөтөлбөр**

ДДЭА-аас гарын үсэг зурсан талууд болон улсуудын засгийн газартай зөвлөсний үндсэн дээр аориотой жагсаалтад ороогүй ч спортын буруу хэрэглээг илрүүлэхийн тулд ДДЭА-аас зохицуулахыг хүссэн бодисуудыг талаар мониторингийн хөтөлбөрийг боловсруулж болно. ДДЭА-аас аливаа шинжилгээг хийхэсээ өмнө зохицуулах бодисуудыг хэвлэх болно. Лабораториуд хэрэглэгдсэн дээжүүд болон эдгээр бодисууд илэрсэн эсэх талаар ДДЭА-д тодорхой хугацаанд спорт бүрээр ялган мэдээлэх ба тухайн дээжийг тэмцээний үеэр буюу тэмцээний бус үеэр авснаа мэдээлнэ. Ийм мэдээнд тусгай дээжүүдийн талаарх нэмэлт мэдээллийг багтаахгүй. ДДЭА-аас Олон улсын холбоод болон Допингийн эсрэг үндэсний байгууллагуудад спортын төрөл бүрээр гаргасан нэмэлт бодисуудын мэдээллийг дор хаяж жилд нэг удаа хүргүүлнэ. ДДЭА-аас тухайн мэдээтэй холбоотой хувь тамирчин бүрийн нэрийг тусгайлан гаргах бүх арга хэмжээг авна. Зохицуулах бодис илэрсэн болон тэдгээрийг байгааг илрүүлсэн тохиолдлууд нь допингийн эсрэг хууль зөрчсөнд тооцогдохгүй.

## **5-р зүйл: Шинжилгээ**

### **5.1. Шинжилгээний зорилго**

Шинжилгээг зөвхөн допингийн эсрэг зорилгоор л явуулна.

5.1.1. Хориотой бодис буюу хориотой арга хэрэглээг хориглох талаар хуулийг тамирчин дагаж мөрдөж байгаа гэсэн баталгааг олж авахын тулд шинжилгээг явуулна.

5.1.2. Шинжилгээг дараах байдлаар явуулна. Үүнд:

- a) Энэхүү хуулийн 7.4 болон 7.5 хэсгүүдэд заасанчлан хэвийн бус баримт болон сөрөг өгөгдөлтэй холбоотойгоор энэхүү хуулийн 2.1 болон 2.2 хэсэгт заасанчлан допингийн эсрэг хууль зөрчсөн эсэхийг тогтоох зорилгоор тандахуйн болон нотлох баримт (ялангуяа аналитик нотлох баримт)-ыг цуглуулна.
- b) Допингийн эсрэг хууль ноцтой зөрчсөнийг заах бусад үзүүлэлттэй холбоотойгоор энэхүү хуулийн 7.6 болон 7.7 хээг заасанчлан 2.2-2.10 зүйлүүдэд заасан допингийн эсрэг хууль зөрчсөн эсэхийг тогтоох зорилгоор тандахуйн болон нотлох баримт (ялангуяа аналитик бус нотлох баримт)-ыг цуглуулна.

### **5.2. Шинжилгээний хамрах хүрээ**

Аливаа тамирчин нь энэхүү хуулийн 5.3 хэсэгт заасанчлан үйл ажиллагаанд зориулан шинжилгээ явуулах өөрт хамааралтай шинжилгээ хийх эрх мэдэл бүхий байгууллагад ямар ч газар, ямар ч тохиолдолд шинжилгээ өгөх зорилгоор дээж өгөх үүрэгтэй. Үүнд:

5.2.1. Допингийн эсрэг үндэсний байгууллага бүр нь тухайн үндэсний, оршин суудаг, лиценз эзэмшдэг, болон тухайн орны спортын байгууллагын гишүүн буюу тухайн оронд одоогоор оршин байгаа бүх тамирчдад тэмцээний үеэр болон тэмцээний бус үед шинжилгээ хийх эрх мэдэлтэй.

5.2.2. Олон улсын холбоо бүр нь Олон улсын үйл ажиллагаа болон тухайн олон улсын холбооны журмаар

явагдаж байгаа аливаа үйл ажиллагаанд оролцож байгаа, Олон улсын холбооны гишүүн буюу лиценз эзэмшигч эсвэл түүний гишүүн үндэсний холбооны гишүүн нийт тамирчдад тэмцээний үеэр болон тэмцээний бус үеэр шинжилгээ хийх эрх мэдэлтэй.

5.2.3. Аливаа томоохон үйл Аажиллагаа зохион байгуулагч, ялангуяа Олон Улсын Олимпийн Хороо, Олон Улсын Паралимпийн Хороо зэрэг нь ирээдүйн үйл ажиллагааны аль нэгэнд оролцох бүх тамирчдын тэмцээний үеэрх шалгалт болон ирээдүйн үйл ажиллагаануудад томоохон үйл ажиллагааг зохион байгуулагчдыг шалгах эрхтэй байна.

5.2.4 ДДЭА нь 20-р зүйлд заасанчлан тэмцээний үеэр болон тэмцээний бус үеэр шинжилгээ хийх эрх мэдэлтэй байна.

5.2.5. Допингийн эсрэг байгууллага нь эрхээ хасуулсан байгаа тамирчид зэрэг зодог тайлаагүй байгаа бүх л тамирчдыг шалгах эрхтэй тул дурын тамирчныг шалгаж болно.

5.2.6. Хэрэв олон улсын холбоо буюу томоохон арга хэмжээ зохион байгуулагч нь дотоодын допингийн эсрэг байгууллагын тестийн үйл ажиллагааны аливаа хэсгийг (шууд буюу үндэсний холбоогоор дамжуулан) төлөөлөх буюу гэрээ зурж байгаа бол тухайн допингийн эсрэг үндэсний байгууллага нь нэмэлт дээж авах буюу лабораторийг нэмэлт шинжилгээг допингийн эсрэг үндэсний байгууллагын зардлаар явуулах зааварчилгааг өгч болно. Хэрэв нэмэлт дээж авсан буюу нэмэлт шинжилгээ хийсэн бол Олон улсын холбоо болон томоохон үйл ажиллагаа зохион байгуулагчдад энэ талаар мэдэгдэнэ.

*5.2 хэсэгт хийх тайлбар: шинжилгээ явуулах нэмэлт эрх мэдлийг талуудын хоорондох хоёр талын буюу олон талын гэрээгээр олгож болно. Дор дурьдсан цагийн хязгаарт 60 минутын шинжилгээ хийхээр эсвэл тухайн хугацаанд өөрөөр зөвшүүлсөн цагийн хязгаарыг тамирчнаас тогтоогоогүй бол 23.00-6.00 цагийн хооронд тамирчинд шинжилгээ хийхээс өмнө*

*Допингийн эсрэг байгууллага нь тамирчин допинг хэрэглэсэн гэсэн тодорхой ноцтой сэжигтэй байх ёстой. Энэ хугацаанд допингийн эсрэг байгууллага нь хангалттай үндэслэлтэй сэжиг байгаа эсэх нь тухайн шинжилгээгээр допингийн эсрэг хууль зөрчигдсөнийг хамгаалах үндэслэл болохгүй.*

### **5.3. Шинжилгээний үйл ажиллагаа**

**5.3.1.** Дор дурьдсанаас бусад тохиолдолд зөвхөн нэг л байгууллага тэмцээний үеэр тэмцээнийг явуулах газар дээр шинжилгээний үйл ажиллагааг санаачлан удирдах үүрэгтэй. Олон улсын тэмцээн уралдааны үеэр дээж цуглуулах үйлдлийг тухайн тэмцээн уралдааныг зохион байгуулж байгаа олон улсын байгууллага (Жишээ нь: Олимпийн тоглолтын хувьд Олон Улсын Олимпийн Хороо, Дэлхийн Аварга Шалгаруулах тэмцээний хувьд Олон Улсын Холбоо, Пан Америкийн тоглолтуудад Пан Америкийн Спортын Холбоо гэх мэт) санаачлан удирдаж явуулна. Үндэсний тэмцээн уралдааны хувьд Допингийн Эсрэг Үндэсний Байгууллага дээж цуглуулах үйлдлийг санаачлан удирдаж явуулна. Тухайн үйл ажиллагааг зохион байгуулж байгаа байгууллагын хүсэлтээр тэмцээний хуваариас гадуур аливаа шинжилгээний үйл ажиллагааг тухайн байгууллага хариуцна.

*5.3.1 зүйлд хийх тайлбар: Олон улсын үйл ажиллагааг удирдаж байгаа зарим байгууллагууд нь үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд зориулсан шинжилгээнээс гадуур өөрсдийн шинжилгээг явуулж болох ба Допингийн Эсрэг Үндэсний Байгууллагын шинжилгээний журмын дагуу тухайн шинжилгээг явуулна.*

**5.3.2.** Хэрэв ямар нэгэн шинжилгээ авах эрхтэй ч аливаа үйл ажиллагаанд зориулсан шинжилгээний үйл ажиллагаа эхлэх болон удирдах үүрэгтэй аль нэгэн Допингийн Эсрэг Байгууллага нь үйл ажиллагааны явцад үйл ажиллагаанд оролцох тамирчдын шинжилгээг явуулах хүсэлтэй бол Допингийн эсрэг байгууллага нь тухайн үйл ажиллагааг удирдаж байгаа талд шинжилгээ авах зохицуулах эрхийг олгоно. Хэрэв Допингийн Эсрэг Байгууллага нь үйл ажиллагааг зохион байгуулж байгаа

байгууллагын хариу үйлдэлд сэтгэл ханамжгүй байвал Допингийн Эсрэг Байгууллага нь ДДЭА-аас гаргасан хуулийн дагуу шинжилгээ явуулах зөвшөөрлийг ДДЭА-аас хүсч шинжилгээг хэрхэн зохицуулахыг тогтоож болно. ДДЭА нь тухайн үйл ажиллагааг зохион байгуулж байгаа байгууллагад мэдэгдэн зөвшөөрөл авалгүйгээр тухайн шинжилгээг баталгаажуулахгүй.

6. ДДЭА-ийн шийдвэр эцсийн бөгөөд давж заалдах боломжгүй шийдвэр байна. шинжилгээг явуулах зөвшөөрөлд өөрөөр заагаагүй бол тухайн шинжилгээнүүдийг тэмцээний бус үеийн шинжилгээнүүд гэж тооцно. Ийм шинжилгээний хариуны талаар баримтлах менежмент нь үйл ажиллагааг зохион байгуулж байгаа байгууллагын журамд өөрөөр заагаагүй бол тухайн шинжилгээг санаачилсан допингийн эсрэг байгууллагын үүрэг байна.

5.3.2 зүйлд хийх тайлбар: Допингийн Эсрэг Үндэсний Байгууллагад олон улсын үйл ажиллагааны үеэр аливаа шинжилгээ санаачлах, хийх зөвшөөрөл өгөхөөс өмнө ДДЭА нь тухайн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах олон улсын холбоотой зөвлөнө. Аливаа шинжилгээ санаачлах, хийх Допингийн Эсрэг Үндэсний Байгууллага нь өөрөө сонговол бусад байгууллагуудтай гэрээ байгуулан дээжс цуглуулах болон бусад допингийн хяналтын үйл ажиллагааны төлөө хүлээх хариуцлагыг өөр дээрээ авна.

#### 5.4. Шинжилгээ тараах төлөвлөлт

5.4.1. ДДЭА нь олон улсын холбоод болон допингийн эсрэг бусад байгууллагатай зөвлөлдсөний үндсэн дээр тодорхой спорт болон спортын төрлүүдийн хувьд дүрэм зөрчигдөн гэж үзэх хориотой арга болон хориотой бодисуудыг үнэлэх замаар Олон улсын шинжилгээний стандартын дагуу техникийн бичиг баримтуудыг батална.

5.4.2. Тухайн эрсдлийн үнэлгээнээс эхлээд шинжилгээ явуулах эрхтэй допингийн эсрэг байгууллага бүр тест шинжилгээ хийх олон улсын стандарт шаардлагын дагуу спортын төрөл, тамирчдын зэрэглэл, шинжилгээний төрөл авсан дээжийн төрөл болон дээжийн шинжилгээний төрөл зэргийг нарийвчлан заасан үр дүнтэй оновчтой шинжилгээ хувиарлах төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлнэ.

Допингийн эсрэг байгууллага бүр нь ДДЭА-д одоогийн төлөвлөгөөний хуулбарыг шаардлагатай үед нь хүргүүлнэ.

5.4.3 Зарим боломжтой тохиолдолд шинжилгээг ДДЭА-аас зөвшөөрөл авсны үндсэн дээр давтан шинжилгээ хийхээс зайлсхийх тестийн үр дүнг сайжруулах зорилгоор ADAMS болон бусад тестийн программуудтай хослуулан хэрэглэж болно.

### 5.5. Шинжилгээнд тавигдах шаардлагууд

Бүх шинжилгээнүүдийг олон улсын шинжилгээнд тавигдах стандарт шаардлагын дагуу явуулна.

### 5.6. Тамирчны байршлын тухай мэдээллүүд

Шинжилгээний мэдээллийн санд олон улсын холбоо болон допингийн эсрэг үндэсний байгууллагаар дамжуулан бүртгүүлсэн тамирчид олон улсын шинжилгээний стандарт шаардлагын дагуу өөрсдийн мэдээллийг оруулна. Олон улсын холбоо болон допингийн эсрэг үндэсний байгууллага нь тухайн тамирчдыг тодорхойлох болон тэдний талаар мэдээлэл цуглуулах ажлыг зохицуулна. Олон улсын холбоо болон допингийн эсрэг үндэсний байгууллагын аль аль нь ADAMS болон ДДЭА-аас баталсан бусад программыг ашиглан мэдээллийн санд бүртгэгдсэн тамирчдыг нэрээр нь буюу бусад үзүүлэлтээр ангилан хайх боломжтой. Тамирчдад мэдээллийн санд өөрсдийнх нь мэдээллийг оруулах буюу устгахаас өмнө урьдчилан мэдэгддэг. Тамирчдын талаарх мэдээлэл нь мэдээллийн санд ADAMS болон ДДЭА-гийн баталсан бусад программыг ашиглан мэдээллийн санд оруулсан мэдээллийг энэхүү хуулийн 5.2-т заасан тамирчныг шалгах эрх бүхий ДДЭА болон бусад допингийн эсрэг байгууллагуудад нэвтрэн шалгах боломжтойгоор оруулсан. Эдгээр мэдээллийг цаг үргэлж өндөр нууцлалын зэрэгтэй байлган зөвхөн допингийн хяналт явуулах, төлөвлөх, зохицуулах, тамирчны биологийн паспорт болон бусад аналитик шинжилгээний үр дүнтэй холбоотой мэдээлэл оруулах, допингийн эсрэг хууль ноцтой зөрчсөн талаар шинжилгээ судалгаа явуулах болон допингийн эсрэг хууль зөрчсөн үйл ажиллагааны талаар мэдээлэл цуглуулахад тусlamж дэмжлэг болох зорилгоор тусгайлан ашиглаж олон улсын хувь хүний

болон хувийн нууцын мэдээллийг хадгалах стандарт шаардлагын дагуу дээрх зорилгоор дахиж ашиглагдахгүй мэдээллүүдийг устгана.

## 5.7. Зодог тайлсан тамирчид тэмцээнд буцан ирэх

5.7.1 Мэдээллийн санд бүртгэлтэй олон улсын болон үндэсний тамирчид эргэн тэмцээнд идэвхитэй оролцох хүсэлтэй бол зургаан сарын өмнөөс бичгээр мэдэгдлийг олон улсын холбоо болон допингийн эсрэг үндэсний байгууллагад хүргүүлэн шинжилгээнд орох боломжийг хангах хүртэл тухайн тамирчныг дотоодын болон олон улсын тэмцээнд оролцуулахгүй. ДДЭА нь олон улсын холбоо болон допингийн эсрэг үндэсний байгууллагуудтай зөвшилцсөний үндсэн дээр дээрх хуууль нь тухайн тамирчны хувьд хэтэрхий хатуу заалт байна гэж үзвэл зургаан сарын өмнөөс бичгээр мэдэгдэл өгөх заалтаас чөлөөлж болно. Ийм шийдвэрийн талаар 13-р зүйлд заасанчилан давж заалдаж болно.

5.7.1.1 Хуулийн 5.7.1-ийг зөрчсөнөөс үүссэн аливаа тэмцээний дүнг хүчингүй болгоно.

5.7.2 Хэрэв тамирчин нь эрх хасуулсан байх хугацаандаа спортоо хаяад дахин тэмцээндээ эргэж идэвхитэй оролцохыг хүсвэл тухайн тамирчин өөрөө зургаан сарын өмнөөс буюу тамирчны зодог тайлсан өдрийн байдлаар үлдсэн эрх хасуулсан хугацаатай тэнцүү хугацааны өмнөөс (Хэрэв энэ хугацаа нь зургаан сараас дээш бол) бичгээр хүсэлт гарган өөрийн харьялагдах олон улсын холбоо болон допингийн эсрэг үндэсний байгууллагад өөрийгөө шинжилгээнд ороход бэлэн байгаа гэдгээ харуулах ёстой.

## 5.8. Шалгалтын мэдээлэл цуглуулах

Допингийн эсрэг байгууллагууд нь олон улсын шинжилгээний стандарт шаардлагын дагуу дараах үйлдлүүдийг хийх боломжтой гэдгээ баталгаажуулах ёстой. Үүнд:

5.8.1 Бүх боломжтой эх сурвалжаас допингийн эсрэг нууц мэдээллүүдийг олж авах, үнэлэх, боловсруулах цаашлаад

тест хуваарилах төлөвлөгөөг зөв үр дүнтэй зохих харьцаагаар боловсруулах, цаашдын допингийн эсрэг хууль зөрчиж болзошгүй үйлдлийг судлах арга хэрэгсэл болгох.

5.8.2 Хэвийн бус үзүүлэлтүүд болон сөрөг үзүүлэлтүүдийг энэхүү хуулийн 7.4 болон 7.5 зүйлүүдэд заасны дагуу судлах

5.8.3 Энэхүү хуулийн 7.6 болон 7.7 зүйлүүдэд заасны дагуу допингийн эсрэг хууль зөрчиж болзошгүй байгаа талаарх тагнуулын мэдээлэл болон аналитик ба анилитик бус бусад мэдээллүүдийг судлан допингийн эсрэг хуулийг зөрчих үйл ажиллагааг санаачилах дэмжиж болзошгүй байгаа талаарх мэдээллийг судлан илрүүлэх.

## 6-р зүйл: Дээжийг шинжлэх

Дээжүүдийг дараах зарчмын дагуу шинжилнэ. Үүнд:

6.1. Магадлан итгэмжлэгдсэн баталгааг лаборатори ашиглах

2.1 зүйлийн зорилгоор дээжүүдийг зөвхөн ДДЭА-гийн магадлан итгэмжлэгдсэн буюу бусад хэлбэрээр хүлээн зөвшөөрсөн лабораторуудад шинжилнэ. Дээжийн шинжилгээг хийх ДДЭА-гийн магадлан итгэмжлэгдсэн буюу бусад хэлбэрээр хүлээн зөвшөөрсөн лабораторуудыг сонгох эрхийг үр дүнгийн менежментийн төлөө хариуцлага хүлээх допингийн эсрэг байгууллага хариуцна.

*6.1 зүйлд хийх тайлбар: зардлын болон газарзүйн байрлалын шалтгаанаар ДДЭА-гаас тухайн төрлийн дээжийг шинжслэх, магадлан итгэмжлэлийг аваагүй лабораторуудыг, жишээлбэл цусны шинжилгээ хийх дээжийг лабораторид заасан хугацаанд хүргэх үүрэг бүхий лабораторийг томилон ажиллуулж болно. Ийм лабораторийг батлахаас өмнө тухайн лаборатори нь ДДЭА-гаас шаардсан аналитик болон үйл ажиллагааны стандарт шаардлагыг хангасан эсэхийг ДДЭА баталгаажуулах ёстой. 2.1 заалтыг зөрчсөн гэдгийг ДДЭА-гийн магадлан итгэмжилсэн буюу бусад хэлбэрээр хүлээн зөвшөөрсөн лабораторид дээжийн шинжилгээг явуулсанаар олж тогтоох боломжтой. Бусад заалтуудыг зөрчсөн эсэхийг дээжийн шинжилгээний хариуны найдвартай байдлыг*

*харгалзсаны үндсэн дээр бусад лабораторуудад явуулж болно.*

## **6.2. Дээжийн шинжилгээ хийх зорилго**

Хориотой жагсаалтад багтсан хориотой арга болон хориотой бодисууд, эсвэл энэхүү хуулийн 4.5 зүйлд заасны дагуу ДДЭА-гаас заасан бусад бодисууд байгаа эсэхийг илрүүлэх эсвэл допингийн эсрэг байгууллагын холбогдох заалтын дагуу тамирчны шээс, цус бусад дээжуудэд **DNA** эсвэл генийн болон бусад үзүүлэлтүүд хуульд тогтоосон хэмжээнд байгаа эсэхийг тогтоох зорилгоор холбогдох үзүүлэлтүүдийг тогтооход допингийн эсрэг байгууллагад туслах зорилгоор шинжилгээг явуулна. Цаашид шинжилгээ хийх зорилгоор дээж цуглуулах буюу хадгалж болно.

*6.2 хэсэгт хийх тайлбар: жишээ нь холбогдох үзүүлэлтүүдэд заасан мэдээллийг шинжилгээ хийх зорилгод чиглүүлэх буюу энэхүү хуулийн 2.2 хэсэгт заасан допингийн эсрэг хууль зөрчсөн үйлдлийг шийдвэрлэхэд ашиглаж болно.*

## **6.3. Дээжийн судалгаа**

Аль ч дээжийг тамирчнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр судалгаа хийх зорилгоор ашиглаж болохгүй. Энэхүү хуулийн 6.2 зүйлд зааснаас бусад зорилгоор ашиглагдаж байгаа дээж нь тодорхой тамирчныг судлах материал болгон ямар нэгэн нууцлалын зорилгоор ашиглагдаж болохгүй.

*6.3 хэсэгт хийх тайлбар: ихэнх эмнэлэгийн практикт чанарын баталгааг хангах, чанарыг сайжруулах зорилгоор тодорхой нэр шошготой дээжуудийг ашиглах буюу мэдээллийн сан бий болгох нь судалгаа хэмээн тооцогдохгүй.*

## **6.4. Дээжийн шинжилгээ хийх болон шинжилгээний хариу өгөх стандарт**

Лабораторууд нь олон улсын лабораторийн шинжилгээ хийх стандартын дагуу дээжийг шинжлэн, шинжилгээний хариуг ирүүлнэ. Дээжийн шинжилгээг үр дүнтэй явуулахын тулд энэхүү хуулийн 5.4.1 хэсэгт заасан техникийн бичиг баримтуудаар тодорхой спорт болон спортын төрлүүдэд нийцсэн дээжийн шинжилгээг эрсдэлийн үнэлгээнд сууринласан дарааллын дагуу явуулж доорхоос бусад тохиолдолд тухайн хуулийн дагуу дээжинд шинжилгээ хийнэ. Үүнд:

6.4.1 Допингийн эсрэг байгууллага нь техникийн бичиг баримтанд зааснаас илүү дэлгэрэнгүй хэлбэрээр дээжинд шинжилгээ хийх хүсэлтийг тухайн лабораторид гаргаж болно.

6.4.2 Тухайн орны нөхцөл байдал буюу спортын төрлөөс хамааран шинжилгээ өгөх төлөвлөгөөний дагуу хураангуй хэлбэрээр дээжийн шинжилгээг хийж болно гэж үзсэнийг ДДЭА-гаас хүлээн зөвшөөрсөн тохиолдолд допингийн эсрэг байгууллага нь илүү хураангуй хэлбэрээр дээжүүдийг шинжлэх хүсэлтийг лабораторуудад гаргаж болно.

6.4.3 Олон улсын стандартанд заасанчлан лабораторууд нь техникийн бичиг баримтанд заасан буюу шинжилгээ хийх эрх мэдэл бүхий байгууллагаас гаргасан дээжийн шинжилгээний цэсэнд багтаагүй хориотой бодис болон хориотой аргуудын шинжилгээг өөрийн санаачлага өөрийн зардлаар явуулж болно. Ийм шинжилгээний хариу нь бусад аналитик шинжилгээний үр дүнтэй ижил хүчин төгөлдөр, ижил үр дагавартай байна.

*6.4 зүйлд хийх тайлбар: Энэхүү зүйлийн гол зорилго нь дээжийн шинжилгээний цэсэнд допингийг хамгийн үр дүнтэй хэлбэрээр шинжслэх зорилгоор Ухаалаг Шинжилгээний цэсийг багтааж өгөх явдал юм. Ингэснээр допингийн эсрэг тэмцэх нөөц нь хязгаарлагдмал бөгөөд дээжийн шинжилгээний цэсийг өргөтгөн нэмэгдүүлсэнээр шинжилгээ хийх дээжний тоог цөөрүүлэх боломжтой гэж хүлээн зөвшөөрсөн.*

## 6.5. Дээжинд дахин шинжилгээ хийх

Допингийн эсрэг байгууллагаар цаашид анализ хийлгэх шаардлагатай аливаа дээжийн хувьд энэхүү хуулийн 2.1 хэсэгт заасан допингийн эсрэг хууль зөрчсөн гэсэн үндэслэлийг бий болгох зорилгоор аливаа тамирчинд хэлэх ёстой А болон В дээжүүдийн талаарх аливаа мэдээлэл (А болон В дээжийн шинжилгээг явуулаагүй буюу хүчингүйд тооцсон) хүчингүй болохоос өмнө аливаа дээжинд допингийн эсрэг байгууллагаас шинжилгээг хийх ёстой. 6.2 зүйлд заасан зорилгоор цаашид шинжилгээ хийх дээжүүдийг ямар ч тохиолдолд тухайн дээжийг

авах үйл ажиллагааг зохион байгуулсан допингийн эсрэг байгууллага болон ДДЭА-гийн санаачлага зааварчилгаагаар дахин шинжилгээг хийж болно.

## 7-р зүйл: Үр дүнгийн менежмент

Үр дүнгийн менежмент явуулж байгаа допингийн эсрэг байгууллага бүр нь дараах зарчмын дагуу допингийн эсрэг хууль ноцтой зөрчсөн асуудлыг хэлэлцэхээс өмнөх үйл ажиллагааны зарчмыг боловсруулна.

*7-р зүйлд хийх тайлбар: Үр дүнгийн менежментийн төрөл бүрийн чиг хандлагыг гарын үсэг зурсан талууд өөр өөрийнхөөрөө тогтоодог. Маш олон чиг хандлагууд байсан ч бүгдээрээ нэгэн загвартай болж үр дүнгийн менежментийн шударга үр дүнтэй хэлбэрийг бий болгож чадаагүй энэхүү хууль нь гарын үсэг зурсан тал бүрийн үр дүнгийн менежментийн системд нэмэлт болж чадаагүй. Гэхдээ энэхүү зүйл нь талуудаас баримтлах ёстой үр дүнгийн менежментийн процессийн үндсэн шударга байдлыг хангах зорилгоор гол гол үзүүлэлтүүдийг зааж өгсөн. Гарын үсэг зурсан тал бүрийн допингийн эсрэг хууль нь энэхүү үндсэн үзүүлэлтүүдэд нийцэж байх ёстой. Аль нэг допингийн эсрэг байгууллагаас эхлүүлсэн допингийн эсрэг хэрэг нь заавал хэлэлцэгдэн шийдвэгдэх ёсгүй энэхүү хууль зөрчсөн болон допингийн эсрэг байгууллагаас шийтгэл оногдуулах ёстой гэсэн шийдвэрийг тамирчин болон бусад этгээдээс хүлээн зөвшөөрсөн тохиолдол байж болно. Ямар ч тохиолдолд тухайн хэлэлцээрийн үндсэн дээр оногдуулсан шийтгэлийг талуудад мэдээлснээр энэхүү хуулийн 14.2.2 болон 14.3.2 зүйлүүдэд заасанчлан талуудад мэдэгдсэнээр 13.2.3 зүйлийн дагуу давж заалдах эрх үүснэ.*

### 7.1. Үр дүнгийн менежментийн төлөө хүлээх хариуцлага

7.1.1 болон 7.1.2 зүйлүүдэд зааснаас бусад тохиолдолд үр дүнгийн менежмент болон шийдвэрлэх хуралдаанууд нь дээж цуглуулах үйл ажиллагааг санаачлан удирдан явуулсан допингийн эсрэг байгууллагын дүрэм журмын дагуу явагдан тухайн допингийн байгууллага (Хэрэв тухайн дээж цуглуулах үйл ажиллагааг энэхүү заалтад хамруулаагүй бол тамирчин буюу бусад этгээдэд

допингийн хууль зөрчсөн талаар мэдэгдэл анх ирүүлсэн допингийн эсрэг байгууллага нь) хариуцлага хүлээх ёстой. Үр дүнгийн менежментийг хэн явуулсанаас үл хамааран энэхүү зүйл болон 8-р зүйлд заасан зарчмуудыг баримтлан 23.2.2 зүйлд заасан хуулийг томоохон өөрчлөлтгүйгээр ашиглахаар дагаж мөрдөх ёстой.

Хэрэв үр дүнгийн менежментийн хариуцлага хүлээж байгаа допингийн эсрэг байгууллагын талаар допингийн эсрэг байгууллагуудын хооронд маргаан үүссэн тохиолдолд ДДЭА нь аль байгууллага тухайн хариуцлага хүлээх талаар шийдвэр гаргана. ДДЭА-гийн энэ шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд энэ маргаанд оролцож байгаа допингийн эсрэг байгууллагууд нь мэдэгдэл өгсөний үндсэн дээр 7 хоногийн дотор Спортын арбитрийн шүүхэд давж заалдаж болно. Спортын арбитрийн шүүх нь энэхүү давж заалдсан өргөдлийг нарийвчлан шалгаж үзсэний үндсэн дээр нэг арбитрын шүүгчтэйгээр шийдвэрлэж болно.

Энэхүү хуулийн 5.2.6 хэсэгт заасны дагуу нэмэлт дээж авахуулахаар допингийн эсрэг үндэсний байгууллагаас шийдвэрлэсэн бол тухайн дээжийг анх авч санаачилсан допингийн эсрэг байгууллагыг сонгоно. Гэхдээ допингийн эсрэг үндэсний байгууллагын зардлаар нэмэлт шинжилгээ хийх лабораторийг зааж өгсөн бол олон улсын холбоо болон томоохон үйл ажиллагаа зохион байгуулагчид нь дээж цуглуулах ажиллагааг санаачилан зохион байгуулсан допингийн эсрэг байгууллагыг сонгоно.

*7.1 зүйлд хийх тайлбар: тухайн дээж цуглуулах ажлыг санаачилан зохион байгуулсан допингийн эсрэг байгууллагын үйл ажиллагааны хуулинд тухайн үйл ажиллагааг тамирчны үндэсний холбоо гэх мэтийн өөр байгууллагаар гүйцэтгүүлнэ. Ийм тохиолдолд тухайн байгууллагын үйл ажиллагааны журам нь энэхүү хуульд нийцэж байгаа гэсэн баталгааг гаргах нь допингийн эсрэг байгууллагын хариуцлага болдог.*

7.1.1 Допингийн эсрэг үндэсний байгууллагын дүрмээр тухайн улсын иргэн үндэстэн оршин суугч, цахим үнэмлэх эзэмшигч биш эсвэл тухайн улсын спортын байгууллагын гишүүн бус тамирчин болон бусад этгээдийн талаар допингийн шинжилгээг авах эрх мэдэл тухайн допингийн

эсрэг байгууллагад байхгүй тохиолдолд эсвэл тухайн допингийн эсрэг үндэсний байгууллага нь ийм эрх эдлэхээс татгалзсан тохиолдолд үр дүнгийн менежментийг холбогдох олон улсын холбоо буюу эсвэл олон улсын холбооны дүрмийн дагуу заасан гуравдагч этгээд хийж гүйцэтгэнэ. Үр дүнгийн менежмент болон ДДЭА-гаас өөрийн санаачлагаар явуулсан тестийн сонсголыг ДДЭА-гаас заасан допингийн эсрэг байгууллага явуулна. Олон Улсын Олимпын Хороо, Олон Улсын Паралимпын хороо бусад томоохон үйл ажиллагаа зохион байгуулагчдаас явуулсан үр дүнгийн менежмент болон шинжилгээний хариуны талаарх сонсголыг эсвэл эдгээр байгууллагуудаас олж илрүүлсэн аливаа допингийн хууль зөрчсөн үйлдлийг холбогдох олон улсын холбоо нь аливаа үйл ажиллагаа тэмцээн уралдаанаас хасах, амжилтыг хүчингүй болгох, тухайн үйл ажиллагаанаас авсан медаль, оноо, шагнал урамшуулалыг хураан авах, допингийн хууль зөрчсөнтэй холбоотой бүх гарсан зардлуудыг нөхөн төлүүлэхтэй холбогдуулан ашиглана.

*7.1.1 зүйлд хийх тайлбар: тамирчин болон бусад этгээдийн холбогдох олон улсын холбоо нь үр дүнгийн менежментийг явуулах эрхийг аль нэгэн допингийн эсрэг байгууллага хэрэгжүүлэхгүй байх эрсдэлээс зайлсхийн үр дүнгийн менежмент явуулах допингийн байгууллагыг зааж өгнө. Олон улсын холбоо нь тамирчин буюу бусад этгээдийн допингийн эсрэг үндэсний байгууллагаас үр дүнгийн менежмент явуулах талаар өөрийн допингийн эсрэг хуулийг чөлөөтэй ирүүлж болно.*

7.1.2 Томоохон зөрчил гаргасантай холбогдуулан үр дүнгийн менежментийн асуудлыг тест шинжилгээ явуулах олон улсын стандартын дагуу олон улсын холбоо буюу тухайн асуудалтай байгаа тамирчины допингийн эсрэг үндэсний байгууллагаас хариуцан шийдвэрлэнэ. Допингийн эсрэг байгууллага нь алдаатай буюу алга болсон шинжилгээнд ADAMS-аар буюу ДДЭА-гаас баталсан бусад системээр дамжуулан ДДЭА-д мэдээлэл хүргэн цаашид бусад допингийн эсрэг байгууллагуудад энэхүү мэдээллийг хүргүүлэх боломжтой болгоно.

## 7.2. Сөрөг аналитик үзүүлэлтийн талаар авч үзэх

Сөрөг аналитик үзүүлэлтийн талаар мэдээлэл авсаны дараа үр дүнгийн менежмент хариуцсан допингийн эсрэг байгууллага нь:

- A. Холбогдох эмчилгээний зориулалтаар ашигласан бодисуудыг олгосон буюу олон улсын стандартын дагуу эмчилгээнд ашиглахыг зөвшөөрсөн эсэх.
- B. Олон улсын тест шинжилгээ явуулах стандарт болон сөрөг аналитик үзүүлэлтийг бий болгосон олон улсын лабораторийн стандарттаас зайлсхийсэн аливаа үйлдэл байсан эсэхийг тогтооно.

## 7.3. Сөрөг аналитик үзүүлэлтийг хянаж үзсэний дараа өгөх мэдэгдэл

Энэхүү хуулийн 7.2 зүйлд заасны дагуу сөрөг аналитик үзүүлэлт байгаа эсэхийг хянаж үзээд холбогдох эмчилгээний зориулалтаар ашиглах бодис холбогдох олон улсын стандартын дагуу илрээгүй буюу сөрөг аналитик үзүүлэлт үүсгэсэн нөхцөл байдал байгаагүй тохиолдолд допингийн эсрэг байгууллагаас энэхүү хуулийн 14.1.1 болон 14.1.3 заалтууд эсвэл өөрийн журамд заасан хэлбэрээр дараах мэдээллүүдийг тамирчинд нэн даруй хүргэнэ.

Үүнд:

- A. Сөрөг аналитик үзүүлэлт
- B. Зөрчсөн допингийн эсрэг хууль
- C. Тамирчнаас болон В дээжийн шинжилгээг хийлгэх хүсэлтийг нэн даруй гаргах эрх буюу тухайн хүсэлтийг гаргаагүй тохиолдолд тухайн В дээжийг хүчингүй гэж тооцох
- D. Хэрэв тамирчин буюу допингийн эсрэг байгууллагаас В дээжийн хариуг нэн даруй гаргуулах талаар хүсэлт гаргах тохиолдолд тухайн В дээжийн шинжилгээг явуулах хуваарь он сар цаг байрлалыг заах

Тамирчин болон тамирчны төлөөлөгчөөс В дээжийг нээх болон олон улсын лабораторийн стандартад заасан тодорхой хугацаанд дээжийг авах

- E. Олон улсын лабораторийн стандартад заасны дагуу мэдээлэлд оруулах ёстой лабораторийн А болон В

дээжүүдийн бичиг баримтын багцын хуулбаруудыг шаардах эрх тамирчинд байдаг зэргийг тамирчинд нэн даруй мэдэгдэх ёстой. Хэрэв допингийн эсрэг байгууллага нь сөрөг аналитик үзүүлэлтийг допингийн хууль зөрчсөн үйлдэл болгох тооцохгүйгээр шийдсэн бол энэхүү журмын 14.1.2 зүйлд заасны дагуу тамирчин болон допингийн эсрэг байгууллагад мэдэгдэнэ. Энэхүү хуулийн 7.9.1 хэсэгт заасны дагуу зайлшгүй хэсэгчлэн хүчингүй болгох хуульд хамаarahгүй гэж үзсэн допингийн эсрэг хууль зөрчсөн үйлдэлд тамирчинд мэдэгдэл ирүүлсэн бол тамирчин асуудлын шийдвэрийг хойшлуулсан хэсэгчлэн хүчингүй болгох заалтыг хүлээн авах боломжтой болно.

#### 7.4. Хэвийн бус шинжилгээний хариуг хянаж үзэх

Олон улсын лабораторийн стандартанд заасны дагуу зарим тохиолдолд лабораторууд нь хориотой бодис байгаа талаар мэдэгдэх шаардлагатай болсноор цаашид судлах хэвийн бус шинжилгээний хариу үүсдэг. Ийм хэвийн бус шинжилгээний хариу хүлээн авсны дараа үр дүнгийн менежмент хариуцсан допингийн эсрэг байгууллага нь тухайн асуудлыг хянан үзэх

- A. Олон улсын эмчилгээний зориулалтаар бодис ашиглах олон улсын стандартад заасны дагуу эмчилгээний зориулалтаар ашиглах бодисын эрх олгогдсон буюу олгогдох болсон олон улсын стандарт болон хэвийн бус шинжилгээний хариу гаргасан олон улсын лабораторийн стандарттаас зайлсхийх шаардлагатай эсэхийг анзааран үзнэ.
- B. Хэрэв тухайн хянаж үзсэн үйлдэл нь эмчилгээний зориулалтаар бодис ашиглах олон улсын стандарт болон хэвийн бус шинжилгээний хариу үүсээгүй гэж үзвэл допингийн эсрэг байгууллагаас шаардлагатай шинжилгээг явуулна. Энэ шинжилгээг явуулж дууссаны дараа тамирчин буюу энэхүү хуулийн 14.1.2-т заасан бусад допингийн эсрэг байгууллагуудад

тухайн хэвийн бус шинжилгээний хариуг тооцох эсэх талаар холбогдох мэдэгдэлийг хүргүүлнэ. Тамирчинд энэхүү хуулийн 7.3-т заасны дагуу мэдэгдэл хүргүүлнэ.

7.4.1 Допингийн эсрэг байгууллага нь хэвийн бус шинжилгээний хариуны талаар мэдэгдэлийг тухайн шинжилгээг хийн допингийн эсрэг хууль зөрчигдсөн талаар тодорхой баримт үүсч дараах нөхцөл байдал үүссэнээс бусад тохиолдолд хэвийн бус шинжилгээний хариуны талаар ямар нэгэн мэдэгдэл хийж болохгүй. Үүнд:

- A. Хэрэв допингийн эсрэг байгууллага нь 7.4 зүйлд заасан шинжилгээний хариуг гаргахаас өмнө В дээжийг шалгаж үзэх ёстой гэж үзвэл тухайн допингийн байгууллага нь тамирчинд мэдэгдэл хүргүүлэн хэвийн бус шинжилгээний хариу болон энэхүү хуулийн 7.3.D-Е хэсгүүдэд заасан мэдээллийг хүргүүлсэний дараа В дээжийн шинжилгээг явуулж болно.
- B. Хэрэв допингийн эсрэг байгууллага нь олон улсын үйл ажиллагаа явсны дараа томоохон үйл ажиллагаа зохион байгуулагчдаас буюу эсвэл олон улсын тэмцээнд багийн гишүүдийг тодорхой хугацааны дотор сонгох үүрэгтэй спортын байгууллагаас олон улсын тэмцээн уралдаанд оролцуулахаас гаргасан тамирчдын жагсаалтад багтсан этгээдийн талаар эсвэл спортын байгууллагаас хараахан шийдэгдээгүй байгаа сөрөг аналитик үзүүлэлтийн талаар мэдээлэл авахаар хүсэлт гаргасан бол тухай допингийн эсрэг байгууллага нь тухайн тамирчны сөрөг аналитик үзүүлэлтийн талаар мэдэгдэл хүргүүлсний дараа допингийн эсрэг байгууллага нь тус тамирчны талаарх тодорхойлолтыг гаргана.

*7.4.1(b) зүйлд өгөх тайлбар: 7.4.1(b) зүйлд заасан нөхцлийн дагуу аливаа үйлдэл хийх сонголт нь энэхүү журамд хамаарах Томоохон Үйл Ажиллагаа Зохион Байгуулагч болон Спортын Байгууллагад үлдэнэ.*

## 7.5. Хэвийн бус шинжилгээний хариу ба сөрөг паспортын өгөгдлүүдийг хянаж үзэх

Хэвийн бус шинжилгээний хариу ба сөрөг паспортын өгөгдлүүдийг хянаж үзэх үйл ажиллагааг Шинжилгээний олон улсын стандарт болон Лабораторийн талаарх олон улсын стандартанд заасны дагуу явуулна. Допингийн Эсрэг Байгууллага нь допингийн эсрэг хууль зөрчигдсөн байна гэж үзэх хангалттай шалтгаан байгаа тохиолдолд хуульд заасны дагуу тухайн тамирчинд допингийн хууль зөрчигдсөн талаар нэн даруй мэдэгдэл өгч тухайн зөрчил гэж тооцсон үндэслэлийг дурьдана. Допингийн эсрэг бусад байгууллагуудад 14.1.2 хэсэгт заасны дагуу мэдэгдэл хүргүүлнэ.

## 7.6. Алдаа гарсан эсэхийг хянан үзэх

Олон улсын тест шинжилгээний стандартад заасны дагуу томоохон файлын алдаа гарсан буюу тест дутсан эсэхийг шалган үзнэ. Допингийн эсрэг хуулийн 2.4 заалт зөрчигдсөн байна гэж үзэх хангалттай шалтгаан байна гэж Олон Улсын Холбоо болон Допингийн Эсрэг Үндэсний Байгууллага үзсэн тохиолдолд хуульд заасны дагуу тухайн тамирчинд допингийн эсрэг хуулийн 2.4 заалт зөрчигдсөн талаар нэн даруй мэдэгдэл өгч тухайн зөрчил гэж тооцсон үндэслэлийг дурьдана. Допингийн эсрэг бусад байгууллагуудад 14.1.2 хэсэгт заасны дагуу мэдэгдэл хүргүүлнэ.

## 7.7. 7.1-7.6 зүйлд допингийн хуульд заагдаагүй зөрчлийг хянан үзэх

Допингийн эсрэг байгууллагаас буюу аливаа допингийн эсрэг хууль зөрчигдсөн эсэх талаар энэхүү хууль болон холбогдох хууль тогтоомжийн дагуу шаардлагатай гэж үзсэн хяналт шинжилгээ эсвэл тухайн допингийн байгууллагаас шаардлагатай гэж үзсэн аливаа тест шинжилгээг явуулан хэрэв допингийн эсрэг хуулийг зөрчсөн байна гэж үзвэл хуульд заасны дагуу тухайн тамирчин буюу бусад этгээдэд допингийн эсрэг хуулийн заалт зөрчигдсөн талаар нэн даруй мэдэгдэл өгч тухайн зөрчил гэж тооцсон үндэслэлийг дурьдана. Допингийн эсрэг бусад байгууллагуудад 14.1.2 хэсэгт заасны дагуу мэдэгдэл хүргүүлнэ.

*7.1 болон 7.6 зүйлүүдэд хийх тайлбар: Олон улсын холбоо нь ихэнхдээ тамирчдад өөрсдийн үндэсний холбоогоор нь дамжуулан мэдэгдэл хүргүүлнэ.*

## **7.8. Өмнө нь допингийн эсрэг хууль зөрчсөн байсныг тогтоох**

Допингийн эсрэг хууль зөрчсөн талаар тамирчинд мэдэгдэл өгөхөөсөө өмнө Допингийн Эсрэг Байгууллага нь ADAMS буюу ДДЭА-аас тогтоосон аливаа системд нэвтрэх буюу ДДЭА болон бусад допингийн эсрэг байгууллагуудад хандан өмнө нь допингийн эсрэг хууль зөрчсөн үйлдэл байсан эсэхийг тогтооно.

## **7.9. Хэсэгчлэн хүчингүй болгох хуульд хамарагдах зарчмууд**

### **7.9.1. Сөрөг аналитик үзүүлэлтийн дараа зайлшгүй хэсэгчлэн хүчингүй болгох**

Дор дурьдсан нөхцлүүдэд гарын үсэг зурсан талууд тусгай бодисоос бусад хориотой бодис болон хориотой аргын талаар сөрөг аналитик хариу ирсэн үед энэхүү хуулийн 7.2,7.3,7.5 хэсгүүдэд заасан мэдэгдэл болон хяналтыг явуулсны дараа хэсэгчлэн хүчингүй болгох шийдвэр гаргана. Үүнд:

- Гарын үсэг зурсан тал нь энэхүү үйл ажиллагааг зохион байгуулагч
- Гарын үсэг зурсан тал нь энэхүү баг сонгох эрхтэй
- Гарын үсэг зурсан тал нь холбогдох олон улсын холбоо
- Гарын үсэг зурсан тал нь допингийн эсрэг хууль зөрчсөн талаар үр дүнгийн менежментийн эрх мэдэлтэй допингийн эсрэг өөр байгууллага байх.

Хэрэв тамирчнаас сонсох зөвлөлд хууль зөрсөн үйлдэл нь халдвартай бүтээгдэхүүнийг хамарсан гэдгийг харуулвал зайлшгүй шаардлагатай хэсэгчлэн хүчингүй болгосон заалтыг хүчингүй болгож болно. Халдвартай бүтээгдэхүүний талаар тамирчны гаргасан мэдэгдлийн дагуу Сонсох зөвлөлийн хэсэгчлэн хүчингүй болгох заалтыг устгахгүй гэж үзсэн шийдвэр хамаarahгүй. Гэхдээ тамирчинд:

- a. хэсэгчлэн сонсох буюу хэсэгчлэн хүчингүй болгох боломж олгоогүй буюу хэсэгчлэн хүчингүй болгосны дараа цаг хугацаанд нь хэрэгжүүлэх боломж олгоогүй

- b. 8-р зүйлд заасанчлан хэсэгчлэн хүчингүй болгох заалтыг хэрэгжүүлсний дараа цаг хугацаанд нь сонсгол хийх боломжийг олгоогүй бол хэсэгчлэн хүчингүй болгох заалт хамаарахгүй.

Хэрэв А дээжинд сөрөг аналитик хариу гарч дагалдах В дээжийн (Тамирчин буюу Допингийн Эсрэг Байгууллагын хүсэлтээр) шинжилгээний хариу нь А дээжийг хариуг баталж чадаагүй бол тамирчин 2.1 зүйлийг зөрчсөнтэй холбогдуулан дахин хэсэгчлэн хүчингүй болох заалтад хамаарахгүй. Тамирчин (эсвэл хуульд зөвшөөрсөнөөр холбогдох томоохон үйл ажиллагаа зохион байгуулагч буюу Олон Улсын Холбооны гишүүн тамирчны баг) 2.1 заалтыг зөрчсөний улмаас тэмцээнээс хасагдсан бөгөөд дагалдах В дээжийн хариу нь А дээжийн хариуг баталж чадаагүй эсвэл өөр ямар нэгэн байдлаар тэмцээнд нөлөөлж тамирчин буюу түүний багийг одоо хир нь тэмцээнд багтааж болохгүй байгаа тохиолдолд тамирчин буюу түүний багийн хувьд дахин шинжилгээ өгөх боломжтой байгаа бол тамирчин буюу түүний баг тэмцээнд үргэлжлүүлэн оролцож болно.

*7.9 зүйлд хийх тайлбар: Допингийн Эсрэг Байгууллагаас хэсэгчлэн хүчингүй болгох шийдвэр гаргахаас өмнө хуульд заасан дотоод хяналтыг эхлээд хийж дуусгах ёстой. Түүнээс гадна хэсэгчлэн хүчингүй болгож байгаа тал нь тухайн тамирчныг энэхүү хэсэгчлэн хүчингүй болгох шийдвэрийг гаргахаас өмнө буюу хойно хэсэгчлэн сонсох эсвэл энэхүү хуулийн 8-р зүйлд заасанчлан хэсэгчлэн хүчингүй болгосны дараа эцсийн сонсгол хийх боломжийг тамирчинд олгодог. Тамирчин нь 13.2.3 зүйлийн дагуу давж заалдах эрхтэй.*

Маш ховорхон тохиолдолд В шинжилгээний хариу А шинжилгээний хариуг батлаагүй тохиолдолд хэсэгчлэн хүчингүй болгосон шийдвэрийг хүлээн авсан тамирчин нь тухайн нөхцөл байдалд зөвшөөрсөн тохиолдолд тэмцээний үлдсэн хэсгүүдэд оролцох боломжтой. Үүний адилaaар багийн спортод олон улсын холбооны холбогдох хуулийн дагуу хэрвээ тухайн баг тэмцээнд оролцож байгаа бол тамирчин нь дараагийн тэмцээнүүдэд оролцох боломжтой болно.

Тамирчин болон бусад этгээд нь энэхүү хуулийн 10.11.3 болон 10.11.4 заалтуудад дурьдсан хэмжээгээр эрх хасуулсан хугацааг хэсэгчлэн хүчингүй болгон кредит авч болно.

## 7.10. Үр дүнгийн менежментийн шийдвэрийн талаар мэдэгдэл хийх

Допингийн эсрэг байгууллага нь допингийн эсрэг хууль зөрчигдсөн талаар дүгнэлт гарган допингийн эсрэг хууль зөрчигдөөгүй гэсэн заалтыг хүчингүй болгон хэсэгчлэн хүчингүй болгох шийдвэр гаргасан, эсвэл хуралдаан хийхгүйгээр шийтгэл оногдуулахаар тамирчин бусад этгээдтэй тохиролцсон бол допингийн эсрэг байгууллага нь энэхүү хуулийн 14.2.1 зүйлд заасан мэдэгдлийг 13.2.3 зүйлийн дагуу давж заалдах эрхтэй Допингийн Эсрэг бусад байгууллагуудад өгнө.

## 7.11. Спортоо орхих

Үр дүнгийн мененжментийн процесс явагдаж байх үед тамирчин буюу бусад этгээд спортоо орхисон бол үр дүнгийн менежмент явуулж байгаа допингийн эсрэг байгууллага нь тухайн үйлдлээ дуусгах эрхтэй. Хэрэв тамирчин буюу бусад этгээд нь үр дүнгийн менежментийн процесс эхлэхээс өмнө спортоо орхисон бол тамирчин буюу бусад этгээдэд допингийн эсрэг хууль зөрчсөнийх нь төлөө үр дүнгийн менежмент тооцох эрхтэй допингийн эсрэг байгууллага нь тухайн үр дүнгийн менежментийг явуулах эрхтэй байна.

*7.11-р зүйлд хийх тайлбар: Аливаа допингийн эсрэг байгууллага нь хууль журамд тамирчин буюу бусад этгээд захирагдахаас өмнө хийсэн аливаа үйлдэл нь допингийн эсрэг хууль зөрчсөн үйлдэл болохгүй ч тухайн тамирчин буюу бусад этгээдийг спортын байгууллагын гишүүнчлэлээс татгалзах үндэслэл байж болно.*

# 8-р зүйл: Шударга гомдол гаргах болон гаргасан шийдвэрийг мэдэгдэх эрх

## 8.1. Шударга гомдол гаргах эрх

Допингийн эсрэг хууль зөрчсөн гэж тооцогдсон аливаа этгээдийн хувьд үр дүнгийн менежмент тооцох үүрэгтэй допингийн эсрэг байгууллага нь тодорхой хугацааны дотор боломжийн зөвлөлтэйгөөр гомдол гаргах үйл ажиллагааг зөв явуулан хуралдана. Эрх хасах хугацааг холбогдох үндэслэлийн хамтаар тодорхой заасан цаг хугацаанд нь гаргасан шийдвэрийг энэхүү хуулийн 14.3-т зааснаар олон нийтэд мэдээлнэ.

*8.1 зүйлд хийх тайлбар: энэхүү зүйлд зааснаар үр дүнгийн менежментийн тодорхой шатанд тамирчин буюу бусад этгээд нь цаг хугацаанд нь шударга үнэн зөв хуралдах эрхтэй. Энэхүү зарчмыг хүний эрх, эрх чөлөөг хамгаалах конвенцийн 6.1 заалт болон олон улсын бусад хууль тогтоомжсуудаас харж болно. Энэхүү зүйл нь допингийн эсрэг байгууллагын хуралдаан хийх дүрэмд ямар нэгэн нэмэлт өөрчлөлт оруулах бус допингийн эсрэг байгууллаг бур дээрх зарчмуудад нийцсэн хуралдааныг явуулах нөхцөлийг хангах зорилготой юм.*

#### **8.2. Спортын тэмцээн хуралдаан, үйл ажиллагаанд зориулсан шийдвэр гаргах**

Тодорхой үйл ажиллагаатай холбогдсон хуралдааныг холбогдох допингийн эсрэг байгууллага болон хяналтын зөвлөлийн дүрэмд зөвшөөрөгдсөн хэлбэрээр явуулна.

*8.2 зүйлд хийх тайлбар: Томоохон үйл ажиллагаа, тэмцээн уралдааны өмнө тухайн тамирчин энэхүү тэмцээн үйл ажиллагаанд оролцох эрхтэй эсэхийг тодорхойлоход шаардлагатай допингийн эсрэг хууль зөрчсөн эсэх талаар шийдвэрийг гаргана. Энэ нь тамирчны тэмцээний үр дүн хүчин төгөлдөр хэвээр байх болон тухайн тэмцээнд тамирчин үргэлжлүүлэн оролцох эрхтэй эсэхийг шийдвэрлэнэ.*

#### **8.3 Хуралдааныг хүчингүй болгох**

Допингийн эсрэг байгууллагын дүрэмд заасан хугацаанд допингийн эсрэг хууль зөрчигдсөн талаар хуульд заасан хугацаанд тамирчин буюу бусад этгээдээс гомдол гаргаж чадаагүй тохиолдолд хуралдаан зарлуулах эрх хүчингүй болно.

#### **8.4. Шийдвэрийн талаар мэдэгдэх**

Үр дүнгийн менежментийн хариуцлага хүлээсэн допингийн эсрэг байгууллага нь хуралдааны шийдвэр эсвэл хуралдааныг хүчингүй болгосон тохиолдолд холбогдох шалтгааныг тайлбарласан мэдээллүүдийг тамирчин болон допингийн эсрэг бусад байгууллагуудад энэхүү хуулийн 14.2.1-д заасны дагуу хүргүүлэх ба тухайн этгээдүүд энэхүү хуулийн 13.2.3 хэсэгт заасны дагуу давж заалдах эрхтэй.

## 8.5. Спортын арбитрийн шүүхийн өмнөх нэг удаагийн шийдвэр

Тамирчин, ДДЭА, бусад анхан шатны шийдвэрийн талаар давж заалдах эрхтэй бусад допингийн эсрэг байгууллага зэргийн зөвшөөрөлтэйгөөр олон улсын хэмжээний тамирчин болон үндэсний хэмжээний тамирчны эсрэг допингийн эсрэг хууль зөрчсөн талаарх асуудал болон үр дүнгийн менежментийн эсрэг хариуцлага хүлээсэн допингийн эсрэг байгууллага зэрэг нь урьдчилан сонсгол хийхгүйгээр шууд Спортын арбитрийн шүүх дээр хэргийг шийдүүлэх эрхтэй.

*8.5 зүйл хийх тайлбар: зарим тохиолдолд олон улсын болон үндэсний түвшинд анхан шатны хуралдааны хэлэлцүүлгийг явуулсан зардлыг дараа нь Спортын арбитрийн шүүхийн өмнөх хуралдсан зардлууд тус тус маш өндөр гардаг. Энэ зүйлд заасан бүх талууд өөрсдийн хууль ёсны эрх ашиг нь анхан шатны хуралдаанаар бүрэн хамгаалагдсан гээж үзвэл тамирчин буюу допингийн эсрэг байгууллага нь хоёр дахь удаагаа хуралдан нэмэлт зардал гаргах шаардлагагүй. Допингийн эсрэг байгууллага нь Спортын арбитрийн шүүхийн хуралдаан ажиглагч буюу оролцогч тал ба олон оролцохыг хүсвэл тухайн эрхийг олгосон анхан шатны шийдвэрийг баталгаажуулах ёстой.*

## **9-р зүйл: Хувь хүний шинжилгээний дүнг автоматаар хүчингүй болгох**

Тэмцээний явц дахь шинжилгээний дүнгээр хувийн спортын төрөлд допингийн эсрэг хууль зөрчсөн болох нь тогтоогдвол тухайн тэмцээнд гаргасан амжилтыг хүчингүй болгон холбогдох медаль, оноо, шагнал зэргийг хураан авна.

*9-р зүйлд хийх тайлбар: багийн спортомд хувь хүний авсан аливаа шагналыг хүчингүй болгоно. Багийн амжилтыг хүчингүй болгох үйлдлийг 11-р зүйлд заасны дагуу явуулна. Багийн бус спорт боловч шагналыг багт нь өгдөг спортын төрлүүдийн хувьд багийн нэг буюу хэд хэдэн гишүүн допингийн эсрэг хууль зөрчсөнтэй холбогдуулан олон улсын холбооны холбогдох дүрэмд заасанчлан эрх хасах болон бусад сахилгын арга хэмжээг нийт багт нь авна.*

## **10-р зүйл: Хувь хүнд оногдуулах шийтгэл**

**10.1. Допингийн эсрэг хууль зөрчигдсөн үйл ажиллагаагаар үр дүнг хүчингүй болгох**

Аливаа үйл ажиллагааны явцад буюу тухайн үйл ажиллагаатай холбоотойгоор допингийн эсрэг хууль зөрчигдсөн бол тухайн үйл ажиллагааг зохион байгуулагчдын шийдвэрээр энэхүү тэмцээнээс авсан тамирчны хувийн амжилтыг хүчингүй болгон энэхүү хуулийн 10.1.1 зүйлд зааснаас бусад бүх медаль оноо шагналуудыг хураан авна. Тэмцээний бусад үр дүнг хүчингүй болгох эсэх шийдвэрийг гаргах хүчинд зүйлсэд тамирчин допингийн эсрэг хуулийг хэр ноцтой зөрчсөн болон тамирчны бусад тэмцээнд өгсөн допингийн шинжилгээ сөрөг байсан эсэх зэрэг багтана.

**10.1.1 Хэрэв тамирчны хууль зөрчсөн үйлдэл нь хувийн алдаа биш бөгөөд санамсаргүй үйлдэл байсныг тамирчин тогтоож чадвал тамирчны допингийн эсрэг хууль зөрчсөн үйлдэлтэй тэмцээнээс бусад тэмцээнд үзүүлсэн амжилт нь хүчингүй болохгүй.**

*10.1 зүйлд хийх тайлбар: 9-р зүйл нь жишээ нь: 100м гүйлт гэх мэт нэг л тэмцээнд тамирчны шинжилгээний хариу эерэг гарснаас эрх хасдаг бол энэхүү заалт нь тухайн үйл ажиллагааны үеэр болсон (Жишээ нь: FINA-н Дэлхийн Аварга г.м) бүх уралдааны дүнг хүчингүй болгож магадгүй.*

**10.2. Хориотой бодис буюу хориотой арга хэрэглэсэн, хэрэглэхийг завдсан буюу эзэмшсэн, олдсоны төлөө эрх хасах**

Энэхүү хуулийн 10.5, 10.5, 10.6 зүйлүүдэд заасан ноцтой бууруулсан буюу хүчингүй болгох заалтын дагуу 2.1, 2.2, 2.6 заалтуудыг зөрчсөнөөс шалтгаалан эрхийг дараах хугацаагаар хасна. Үүнд:

**10.2.1. Дараах тохиолдолд тамирчны эрхийг 4 жилээр хасна. Үүнд:**

**10.2.1.1. Тамирчин буюу бусад этгээд допингийн эсрэг хууль зөрчсөн үйлдэл нь зориудын үйлдэл байгаагүй гэдгийг баталж чадаагүй ба допингийн эсрэг хууль зөрчсөн үйлдэл нь тусгай бодисыг хамраагүй.**

10.2.1.2. Допингийн эсрэг хууль зөрчсөн үйлдэл нь тусгай бодисыг хамарсан бөгөөд Допингийн эсрэг байгууллага нь допингийн эсрэг хууль зөрчсөн үйлдэл нь санаатай үйлдэл байсан гэдгийг тогтоож чадсан.

10.2.2. Хэрэв 10.2.1 зүйл хамаarahгүй бол эрх хасах хугацаа нь 2 жил байна.

10.2.3. 10.2 ба 10.3 зүйлүүдэд заасан санаатай гэсэн нэр томьёо нь хуурамч үйлдэл хийсэн тамирчныг заадаг. Тиймээс энэхүү нэр томьёогоор тамирчин буюу бусад этгээд нь өөрийн хийсэн үйлдэл нь допингийн эсрэг хууль зөрчсөн үйлдэл болно гэдгийг мэдэж байсан буюу өөрийн хийсэн үйлдэл нь допингийн эсрэг хууль зөрчсөн үйлдэл болох магадлалтай гэдгийг мэдэж байсан ч тухайн эрсдэлийг үл тоон үйлдсэн байна. Зөвхөн тэмцээний үеэр хориглодог бодисын сөрөг аналитик үзүүлэлтээр допингийн эсрэг хууль зөрчигдсөн ч энэхүү бодис нь тусгай бодис бөгөөд тамирчин нь тухайн хориотой бодисыг тэмцээнээс гадуур спортын гүйцэтгэлтэй холбоогүй зорилгоор хэрэглэсэн гэдгийг тогтоож чадвал тухайн тамирчны энэхүү үйлдлийг санаатай үйлдэл биш гэж үзнэ.

Зөвхөн тэмцээний үеэр хориглодог бодисын сөрөг аналитик үзүүлэлтээр допингийн эсрэг хууль зөрчигдсөн ч энэхүү бодис нь хориотой бодис бөгөөд тамирчин нь тухайн хориотой бодисыг тэмцээнээс гадуур спортын гүйцэтгэлтэй холбоогүй зорилгоор хэрэглэсэн гэдгийг тогтоож чадвал тухайн тамирчны энэхүү үйлдлийг санаатай үйлдэл биш гэж үзнэ.

10.3. Бусад допингийн эсрэг дүрэм зөрчсөний төлөө хүлээх хариуцлага

Энэхүү хуулийн 10.2 зүйлд зааснаар допингийн эсрэг хууль бусад тохиолдолд 10.5 болон 10.6 заалтууд хамаarahгүй нөхцөлд допингийн эсрэг хууль зөрчсөнтэй холбогдуулан эрх хасах хугацаа нь дараах хэлбэртэй байна. Үүнд:

10.3.1 Энэхүү хуулийн 2.3 болон 2.5 зүйлүүдийг зөрчсөн тамирчнаас дээж цуглуулах үйлдэлд дээжээ өгч чадаагүй үйлдэлд дөрвөн жилийн хугацаатайгаар эрх хасах ба

энэхүү хуулийн 10.2.3 зүйлд заасанчлан допингийн эсрэг хууль зөрчсөн үйлдэл нь санаатай үйлдэл байгаагүй гэдгийг тамирчин баталж чадсан тохиолдолд эрх хасах хугацаа нь хоёр жил байна.

10.3.2 Энэхүү хуулийн 2.4 зүйлийг зөрчсөн тохиолдолд эрх хасах хугацаа нь хоёр жил байх бөгөөд тамирчны алдааны түвшингээс хамааран эрх хасах хугацааг хамгийн багадаа нэг жил хүртэл хугацаагаар бууруулж болно. Энэхүү хуульд заасанчлан 1-2 жилийн хэлбэлзэл нь шинжилгээнээс эцсийн мөч хүртэл зугтаахыг оролдож байсан буюу бусад хэлбэрээр шинжилгээнээс зутаж байсан тамирчинд хамаарахгүй.

10.3.3. Энэхүү хуулийн 2.7 болон 2.8 зүйлүүдийг зөрчсөн тохиолдолд 4 жилээс бүх насаар эрх хасч болно. Насанд хүрээгүй хүүхэд оролцсон үйлдэл энэхүү хуулийн 2.7 болон 2.8 заалтуудыг зөрчсөн тохиолдолд ноцтой зөрчил хэмээн тооцох ба хэрэв тусгай бодист зааснаас бусад дүрмийг тамирчныг дэмжих этгээд зөрчсөн бол тухайн тамирчныг дэмжих этгээдийн эрхийг бүх насаар нь хасч болно. Үүнээс гадна спортын бус хууль дүрмүүдийг зөрчих буюу энэхүү хуулийн 2.7 болон 2.8 зүйлүүдийг ноцтой зөрчсөнийг холбогдох захиргааны, мэргэжлийн болон шүүхийн эрх барих байгууллагуудад мэдэгдэнэ.

*10.3.3 зүйлд хийх тайлбар: Тамирчадад допинг өгөх үйл ажиллагаанд оролцсон буюу нуусан этгээд нь допингийн хариу нь эерэг гарсан тамирчнаас илүү хүнд хариуцлага хүлээнэ. Спортын байгууллагын удирдлагууд ихэнхдээ магадлан итгэмжлэл, гишүүнчлэл, спортын бусад давууталын талаарх мэдээлэл хүлээн авах боломж хязгаарлагдмал байдаг болохоор тамирчныг дэмжих этгээд нь эрх мэдэл бүхий байгууллагуудад мэдээлэл ирүүлэх нь допингийг илрүүлэх чухал алхам байдаг.*

10.3.4. Энэхүү хуулийн 2.9 заалтыг зөрчсөний төлөө эрх хасах хугацаа нь хамгийн багадаа 2 жил байх ба зөрчлийн зэргээс хамаараад 4 жил хүртэл нэмэгдүүлж болно.

10.3.5. Энэхүү хуулийн 2.10 заалтыг зөрчсөний төлөө эрх хасах хугацаа нь 2 жил байх ба тамирчин ба бусад

этгээдийн зөрчлийн зэрэг болон бусад хэргийн нөхцлөөс хамаараад 1 жил хүртэл бууруулж болно.

*10.3.5 зүйлд хийх тайлбар: 2.10 зүйлд заасан бусад этгээд гэдэгт хувь хүн бус байгууллагыг ойлгох ба тухайн байгууллага нь 12-р зүйлд зааснаар ойлгогдоно.*

**10.4. Алдаа гаргаагүй буюу санаандгүй үйлдэл байсан тохиолдолд эрх хасах хугацааг хүчингүй болгох**

Хэрэв тамирчин буюу бусад этгээд нь алдаа гаргаагүй буюу санаандгүй үйлдэл байсан гэсэн хувь хүний кейс ҮҮСГЭСЭН тохиолдолд эрх хасах хугацаа хүчингүй болно.

*10.4 зүйлд хийх тайлбар: Энэхүү зүйл болон 10.5.2 зүйлүүд нь зөвхөн шийтгэл оногдуулахад хамаарах тул допингийн эсрэг дүрэм зөрчигдсөн эсэхийг тодорхойлоход ашиглагдахгүй. Энэхүү заалт нь өрсөлдөгчөөс саад болох үйл ажиллагаа явуулсан гэдгийг баталж чадсан тусгай нөхцөл байдалд л хамаарна. Эсрэгээрээ ноцтой алдаа гаргаагүй буюу санаандгүй үйлдлийн нөхцөл байдал нь дараах тохиолдолуудад хамаарахгүй. Үнд:*

- A. Буруу шошготой буюу халдвартасан аминдэм болон тэжээлийн нэмэлтүүд (тамирчид өөрсдийн идсэн уусан зүйлийн төлөө хариуцлага хүлээнэ. 2.1.1 зүйл)-ээс шалтгаалан нэмэлт тэжээл халдвартасан аюултайг анхааруулсан.
- B. Тамирчны эмч буюу дасгалжуулагчаас тамирчинд мэдэгдэхгүйгээр (Тамирчид нь өөрсдийн эрүүл мэндийн ажилтнуудыг хүлээн авах болон хориотой бодисыг хэрэглэж болохгүй гэдгийг эрүүл мэндийн ажилтанд мэдэгдэх үүрэгтэй) хориотой бодисыг захиран зарцуулсан.
- C. Тамирчны хамаатан садны хүрээнд байдаг гэр бүлийн хүн, дасгалжуулагч болон бусад этгээдээс тамирчны хоол унданд хориотой зүйл хийсэн (Тамирчин нь өөрийн идэж уусан зүйл болон тухайн хоол ундны зүйлсийг зохицуулж байдаг хүмүүсийн үйлдлийн төлөө хариуцлага хүлээдэг). Гэхдээ тодорхой хэргийн дахин давтагдашгүй баримтанд

тулгуурлан дээр тодорхойлсон тайлбарууд нь ноцтой алдаа гараагүй буюу санаандгүй үйлдэлд тулгуурлан энэхүү хуулийн 10.5 хэсэгт заасанчлан шийтгэлийг бууруулж болно.

## 10.5. Ноцтой алдаа гараагүй буюу санаандгүй үйлдэл байсан тохиолдолд эрх хасах хугацааг багасгах

10.5.1. Энэхүү дүрмийн 2.1, 2.2, болон 2.6 зүйлүүдийг зөрчсөн тусгай бодис олон халдвартай бүтээгдэхүүнүүдэд оногдуулах шийтгэлийг бууруулах

### 10.5.1.1. Тусгай бодисууд

Допингийн эсрэг хууль зөрчсөн үйлдэл нь тусгай бодисыг хамаарч байгаа ба тамирчин болон бусад этгээд нь ноцтой алдаа гаргаагүй буюу санаандгүй үйлдэл байсан гэдгийг тогтоон эрх хасах хугацааг тамирчин буюу бусад этгээдийн алдааны түвшингээс хамааран хамгийн багадаа эрх хасах хугацаа тогтоохгүйгээр, хамгийн ихдээ хоёр жилд хүртэлх хугацаагаар тогтооно.

### 10.5.1.2. Халдвартай бүтээгдэхүүнүүд

Тамирчин болон бусад этгээд нь ноцтой алдаа гаргаагүй буюу санаандгүй үйлдэл байсан гэдгийг тогтоон хориотой бүтээгдэхүүн нь халдвартай бүтээгдэхүүнээс халварласан гэдгийг тогтоож чадвал эрх хасах хугацааг тамирчин буюу бусад этгээдийн алдааны түвшингээс хамааран хамгийн багадаа эрх хасах хугацаа тогтоохгүйгээр, хамгийн ихдээ хоёр жилд хүртэлх хугацаагаар тогтооно.

*10.5.1.2 зүйлд хийх тайлбар: Тамирчины алдааны түвшинг үнэлэхдээ тухайн тамирчин өөрийн допингийн хяналтад халдвартай гээж тодорхойлсон бүтээгдэхүүний талаар өөрөө мэдэгдсэн бол энэ нь шийдвэр гаргахад эергээр нөлөөлнө.*

10.5.2 Энэхүү хуулийн 10.5.1 зүйлд хамаarahгүй ноцтой алдаа гараагүй буюу санаандгүй үйлдэл байсан талаарх өргөдөл

Хэрэв тамирчин болон бусад этгээдийн үүсгэсэн хувь хүний хэрэгт 10.5.1 заалт хамаarahгүй байгаа ба ноцтой алдаа гараагүй буюу санаандгүй үйлдэл үүссэн тохиолдолд энэхүү хуулийн 10.6 хэсэгт заасанчлан алдаа гаргаснаас бусад тохиолдолд эрх хасах хугацааг арилгах, багасгах буюу хүчингүй болгох нөхцөл үүсэхгүй бол тамирчны алдааны хэмжээнд үндэслэн эрх хасах хугацааг тогтоох боловч энэхүү хугацаа нь холбогдох хугацааны талаас багагүй байх ёстой. Хэрэв бусад шалтгаанаар бүх насаар нь эрх хассан бол бууруулсан хугацаа нь энэхүү хуулийн дагуу найман жилээс багагүй байх ёстой.

*10.5.2 зүйлд хийх тайлбар: Энэхүү заалт нь допингийн эсрэг хууль зөрчсөн элемент нь (жишиээ нь: 2.5, 2.7, 2.8 2.9 заалтууд) допингийн эсрэг хууль зөрчигдсөн буюу тодорхой санкү зөрчсөн (10.2.1 заалт) байгаа эсвэл эрх хасах хүрээг тамирчин буюу бусад этгээдийн алдааны хэмжээнээс хамааран тогтоосон тохиолдолд тус тус үйлчилнэ.*

**10.6. Алдаа гаргаснаас бусад тохиолдолд эрх хасах хугацааг арилгах, багасгах буюу хүчингүй болгох**

**10.6.1. Допингийн эсрэг хууль зөрчсөнийг тогтоох буюу илрүүлэхэд томоохон туслалцаа үзүүлэх.**

**10.6.1.1 Допингийн эсрэг хууль зөрчсөний төлөө үр дүнгийн менежментийн хариуцлага хүлээсэн допингийн эсрэг байгууллага нь энэхүү хуулийн 13-р зүйлд заасан эцсийн давж заалдах шийдвэр гаргах болон давж заалдах хугацаа дуусахаас өмнө тамирчин болон бусад этгээд нь допингийн эсрэг байгууллага, эрүүгийн гэмт хэргийн болон мэргэжлийн сахилгын байгууллагуудад томоохон туслалцаа үзүүлсэнээр**

- A. допингийн эсрэг байгууллага буюу бусад этгээд допингийн дүрэм зөрчсөн үйлдлийг илрүүлэх буюу мэдүүлсэн,
- B. Бусад этгээдийн мэргэжлийн журам зөрчсөн буюу эрүүгийн зөрчил гаргасныг эрүүгийн болон сахилгын байгууллагууд илрүүлсэн эсвэл тухайн этгээдийн ирүүлсэн мэдээлэл нь үр дүнгийн менежментийн

хариуцлага хүлээсэн допингийн эсрэг байгууллагад томоохон туслалцаа үзүүлсэн. Энэхүү хуулийн 13-р зүйлд заасан эцсийн давж заалдах шийдвэр гаргах болон давж заалдах хугацаа дуусахаас өмнө допингийн эсрэг байгууллага нь ДДЭА болон холбогдох олон улсын холбооны зөвшөөрөлтэйгөөр эрх хасах хугацааны тодорхой хэсгийг хүчингүй болгож болно. Энэ болон бусад шалтгаанаар эрх хасах хугацааны тодорхой хэсгийг хасах үйлдэл нь тамирчин буюу бусад этгээдээс допингийн эсрэг хуулийг хэр ноцтой зөрчсөн болон спорт дахь допингийн асуудлыг устгахад хэр зэрэг тусlamж дэмжлэг үзүүлсэнээс бас хамаарна. Нийт эрх хасах хугацааны  $\frac{3}{4}$  хүртэлх хугацааг бууруулж болно. Хэрэв ямар нэгэн шалтгаанаар бүх насаар эрх хассан бол бууруулан үлдсэн хугацаа нь найман жилээс багагүй байх ёстой. Хэрэв тамирчин болон бусад этгээд нь эрх хассан хугацааг хүчингүй болгоход голчлон анхаардаг томоохон туслалцаа үзүүлэх буюу хамтран ажиллах үүргээ биелүүлээгүй бол эрх хасах хугацааг шийдвэрлэх допингийн эсрэг байгууллагаас анхны хэмжээнд нь буцаан оруулж болно. Хэрэв допингийн эсрэг байгууллагаас эрх хасах хугацааг хуучин хэмжээнд нь буцаах буюу эрх хассан хугацааг багасгах шийдвэрийг гаргасан бол энэхүү шийдвэрийн талаар 13-р зүйлд заасны дагуу аль нэг этгээд давж заалдаж болно.

10.6.1.2 Допингийн эсрэг байгууллагад томоохон туслалцаа үзүүлэх тамирчин болон бусад этгээдүүдийг цаашид дэмжих зорилгоор үр дүнгийн менежментийн үйл ажиллагаа явуулж байгаа допингийн эсрэг байгууллага буюу допингийн эсрэг хууль зөрчсөн тамирчин буюу бусад этгээдийн хүсэлтээр ДДЭА нь үр дүнгийн менежментийн үйл ажиллагааны дурын үе шатанд ялангуяа 13-р зүйлд заасан эцсийн давж заалдах шийдвэр гарсны дараа эрх хасах хугацааг ямар байдлаар бууруулах болон бусад үр дүнгийн талаар дахин судлаж

үзэхийг зөвшөөрч болно. Өвөрмөц нөхцөл байдалд ДДЭА нь энэхүү хуульд зааснаас илүү хэмжээний туслалцаа үзүүлсэн, энэхүү туслалцааг мөнгө, шагнал, торгууль, зардал зэрэг бусад хэлбэрээр эргүүлэн төлөх боломжгүй тохиолдолд ДДЭА-гаас эрх хасах хугацааг багасгахаар тохиролцож болно. 13-р зүйлд хамаарахгүй нөхцөл байдалд ДДЭА-гаас гаргасан ийм шийдвэрийг аль нэгэн допингийн эсрэг байгууллагаас давж заалдаж болохгүй.

10.6.1.3 Хэрвээ допингийн эсрэг байгууллага нь томоохон туслалцаа үзүүлсэнтэй холбогдуулан холбогдох шийтгэлийн аль нэг хэсгийг хүчингүй болгож энэхүү шийдвэрийнхээ талаар 13.2.3 зүйлд заасны дагуу давж заалдах эрхтэй бусад допингийн эсрэг байгууллагуудад 14.2 хэсэгт заасанчлан мэдэгдэл хүргүүлнэ. Өвөрмөц нөхцөл байдалд ДДЭА нь допингийн эсрэг байгууллагын ашиг сонирхолд нийцнэ гэж үзвэл ДДЭА нь допингийн эсрэг байгууллагад тодорхой нууцлалын гэрээ байгуулан томоохон туслалцаа үзүүлэх гэрээ байгуулах болон томоохон туслалцааны нөхцөл байдлыг тодорхойлохыг зөвшөөрч болно.

*10.6.1 зүйлд хийх тайлбар: тамирчин, тамирчиныг дэмжих этгээд, бусад этгээдүүд өөрсдийн алдаагаа ойлгон өөрийн допингийн эсрэг дүрэм зөрчсөн үйдлээ олон нийтэд илчлэх хүсэлтээ байгаа бол эдгээр хүмүүстэй хамтран ажиллах нь спортыг цэвэрлэх чухал алхам байдал. Энэхүү дүрмийн дагуу холбогдох эрх хасах хугацааг багасгах үорын ганцхан нөхцөл нь энэ байдал.*

10.6.2 Бусад нотлох баримт байхгүй үед допингийн дүрэм зөрчсөнийг хүлээн зөвшөөрөх

Тамирчин буюу бусад этгээд нь допингийн эсрэг хууль зөрчсөн (эсвэл энэхүү дүрмийн 7-р зүйлд заасны дагуу зөрчил гаргаснаа хүлээн зөвшөөрсөн анхны мэдэгдлээ хүлээн авахаас өмнө хуулийн 2.1 хэсэгт заасан допингийн эсрэг хууль зөрчсөн тохиолдолд)-ийг тогтоох дээжийн талаар мэдэгдэл хүлээн авахаас өмнө допингийн эсрэг

хууль зөрчсөнөө сайн дураар хүлээн зөвшөөрвөл хүлээн зөвшөөрсөн үйлдэл нь хууль зөрчсөнийг батлах хамгийн найдвартай нотолгоо болж байвал эрх хасах хугацааг багасгаж болох ч нийт хугацааны талаас ихгүй байх ёстой.

10.6.3. Энэхүү хуулийн 10.2.1 болон 10.3.1 зүйлийн дагуу хариуцлага хүлээлгэх зөрчил үүссэний дараа допингийн эсрэг хууль зөрчсөнийг нэн даруй хүлээн зөвшөөрөх нь тамирчин болон бусад этгээд энэхүү хуулийн 10.2.1 болон 13.1 хэсэгт заасан дээж цуглуулахаас татгалзсан буюу зайлсхийсэн эсвэл дээж цуглуулах ажилд нөлөөлсөн заалтын дагуу дөрвөн жилийн эрх хасуулах шийтгэлтэй байхад допингийн эсрэг хууль зөрчсөнөө допингийн эсрэг байгууллагад нэн даруй хүлээн зөвшөөрснийг ДДЭА болон үр дүнгийн менежментийн хариуцлага хүлээсэн допингийн эсрэг байгууллагын сонголт болон баталгаажуулалтаар эрх хасах хугацааг тухайн тамирчны гаргасан зөвшөөрлөөр ноцтой байдлаас шалтгаалан хоёр хүртэлх жилээр багасгаж болно.

#### 10.6.4 Шийтгэл бууруулах хэд хэдэн үндэслэл байх

Тамирчин болон бусад этгээд 10.4, 10.5, 10.6 зэрэг нэгээс дээш тооны нөхцөлөөр шийтгэл бууруулах үндэслэлийг ашиглах боломжтой байхад эрх хасах хугацааг 10.6 зүйлийн дагуу бууруулахаар өргөдөл гаргахаас өмнө 10.2, 10.3, 10.4, 10.5 заалтуудын дагуу эрх хасах хугацааг бууруулах буюу хүчингүй болгох өргөдлийг гаргаж болно. Энэ тохиолдолд эрх хасах хугацааг бууруулж болох ч энэ нь нийт хугацааны  $\frac{1}{4}$ -ээс багагүй байна.

*10.6.4 зүйлд хийх тайлбар: Холбогдох шийтгэлийг 4 үе шаттайгаар тогтооно. Нэгдүгээрт хуралдааны зөвлөлөөс тухайн допингийн эсрэг хууль зөрчсөн нөхцөл байдалд аль заалт хамаарахыг тогтооно. (10.2, 10.3, 10.4, 10.5 заалтууд). Хоёрдугаарт хэрэв үндсэн шийтгэл нь хэд хэдэн зүйл заалтыг хамаарч байвал хуралдааны зөвлөлөөс холбогдох хариуцлагын хэмжээг тухайн тамирчин болон бусад этгээдийн алдааны нөхцөлөөс шалтгаалан тогтоож болно. (10.6 зүйл).*

Эцэст нь энэхүү хуулийн 10.11 зүйлд заасан эрх хасуулах хугацаа хэзээ эхлэхийг шүүхийн зөвлөл тогтооно.

10-р зүйлийг хэрхэн ашиглах хэд хэдэн жишээг хавсралт 2-оос үзээрэй.

#### 10.7. Хэд хэдэн зөрчил гаргах

10.7.1 Тамирчин буюу бусад этгээд допингийн эсрэг хууль хоёр дахь удаагаа зөрчвэл эрх хасах хугацаа нь дараах хэмжээнээс их байна. Үүнд:

- a) 6 сар
- b) 10.6 зүйлд зааснаар хугацааг бууруулсныг үл анзааран анхны допингийн эсрэг хууль зөрчсөний төлөө эрх хассан хугацааны  $\frac{1}{2}$ -с хэтрэхгүй хугацаа
- c) 10.6 зүйлд зааснаар хугацааг бууруулсаныг үл анзааран анхны допингийн эсрэг хууль зөрчсөний төлөө эрх хассаныг үл тооцон хоёрдахь удаагаа допингийн эсрэг хууль зөрчсөнийг анх удаагийн зөрчил мэтээр тооцон эрх хасах хугацааг хоёр дахин нэмэгдүүлэх

Эрх хасах хугацааг энэхүү хуулийн 10.6 зүйлд заасны дагуу бууруулж болно.

10.7.2. Гуравдахь удаагаа допингийн эсрэг хууль зөрчсөн нь хэрвээ энэхүү хуулийн 10.4 ба 10.5 зүйлийн дагуу эрх хасах хугацааг бууруулах буюу хүчингүй болгох нөхцөл болсон эсвэл 2.4 зүйл зөрчсөн үйлдэл болсон бол ихэнхдээ бүх насаар эрх хасах үндэслэл болно. Ийм тохиолдолд эрх хасах хугацаа нь 8 жилээс бүх насаар байна.

10.7.3. Тамирчин буюу бусад этгээд нь санаандгүй байдлаар буюу өөрийн алдаагүйгээр допингийн эсрэг хууль зөрчсөнийг энэхүү зүйлийн зорилгоор допингийн эсрэг хууль өмнө нь зөрчсөн гэж тооцохгүй.

10.7.4. Хэд хэдэн удаа ноцтой зөрчил гаргасан тохиолдолд баримтлах нэмэлт журам

10.7.4.1. Энэхүү хуулийн 10.7 зүйлийн заалтын дагуу хариуцлага хүлээлгэх зорилгоор хуулийн 7-р зүйлд заасны дагуу мэдэгдэл хүлээн авсан тамирчин буюу бусад этгээд нь допингийн эсрэг

хуулийг зөрчсөн буюу анхны удаа допингийн эсрэг хууль зөрчсөн талаар мэдэгдэл өгөх хангалттай оролдлогыг допингийн эсрэг байгууллага хийсний дараа тамирчин буюу бусад этгээд хоёрдахь удаа допингийн эсрэг хууль зөрчсөн бол энэхүү үйлдлийг хоёрдахь удаагийн үйлдэл гэж тооцно. Хэрэв допингийн эсрэг байгууллага нь үүнийг тогтоож чадахгүй байгаа бол эдгээр зөрчлүүдийг нийтэд нь нэг удаагийн үйлдэл хэмээн тооцон оногдуулах шийтгэл нь хэд хэдэн зөрчил гаргасан илүү хүнд шийтгэл байна.

**10.7.4.2. Анхны удаа допингийн эсрэг хууль зөрчсөнтэй холбогдуулан допингийн эсрэг байгууллага анхны зөрчлийн талаар мэдэгдэл өгөхөөс өмнө тамирчин буюу бусад этгээд допингийн эсрэг хууль зөрчсөн талаар баримтыг илрүүлсэн бол Допингийн эсрэг байгууллага нь өмнө оногдуулсан шийтгэл дээр үндэслэн хоёр дах шийтгэлийг оногдуулан эдгээр хоёр шийтгэлийг нийлүүлэн зэрэг шийдвэрлэж болно. Өмнөх допингийн эсрэг хууль зөрчсөний төлөө хүлээх хариуцлагатай холбогдуулан бүх тэмцээний дүнг энэхүү журмын 10.8 зүйлд заасны дагуу хүчингүй болгоно.**

**10.7.5. Сүүлийн 10 жилийн хугацаанд хэд хэдэн допингийн эсрэг хууль зөрчих**

Энэхүү хуулийн 10.7 зүйлд заасан зорилгоор допингийн эсрэг хууль зөрчсөн үйлдэл бүрийг хэд хэдэн удаагийн үйлдэл гэж тооцохын тулд 10 жилийн дотор үйлдэгдсэн байх ёстой.

**10.8. Допингийн эсрэг хууль зөрчсөн талаарх комиссийн шийдвэр гаргасан буюу дээж авсаны дараах тэмцээнүүдийн дүнг хүчингүй болгох**

Энэхүү хуулийн 9-р зүйлд заасны дагуу эерэг хариу гарсан тэмцээний дүнг автоматаар хүчингүй болгохоос гадна эерэг дээжийн хариу гарах буюу бусад допингийн эсрэг хууль зөрчигдсөнөөс хүчингүй болгох буюу хэсэгчлэн хүчингүй болгох өдөр эхлэх хүртэл (тэмцээний болон тэмцээний бус үеэр)

цуглуулсан бүх оноо болон холбогдох үр дүнгүүд хүчингүй болж бүх медаль, оноо, шагналуудыг хураан авна.

*10.8 зүйлд хийх тайлбар: Аль нэг этгээдийн допингийн эсрэг хууль зөрчсөн үйлдлээс болж хохирсон аливаа тамирчин буюу бусад этгээдийн нэрийг цэвэрлэх, хохирлыг нөхөн төлүүлэх талаар энэхүү хуульд заагаагүй.*

10.9. Спортын арбитрийн шүүхээс олгосон шагнал болон хуурамч шагналын мөнгийг байршуулах

**Спортын арбитрийн шүүхээс олгосон шагнал болон хуурамч шагналын мөнгийг эргүүлэн төлөх** дараалал нь дараах байдалтай байна. Үүнд: эхлээд Спортын арбитрийн шүүхээс олгосон зардлыг төлөөд, хоёрдугаарт холбогдох олон улсын холбооны дүрэмд ингэж заасан бол бусад тамирчдын хуурамч шагналын мөнгийг эргүүлэн олгох, гуравдугаарт тухайн хэрэгтэй холбоотойгоор үр дүнгийн менежментийн ажиллагаа явуулсан Допингийн Эсрэг Байгууллагын зардлыг нөхөн төлөх гэсэн дараалалтай байна.

10.10. Санхүүгийн үр дагавар

Допингийн эсрэг байгууллага нь өөрийн дүрэмдаа зардлыг холбогдох дүрмийн дагуу нөхөн төлөх болон допингийн эсрэг хууль зөрчсөн дансанд санхүүгийн хориг тавих талаар зааж болно. Гэхдээ допингийн эсрэг байгууллагууд нь зөвхөн холбогдох эрх хасах хугацааг хамгийн дээд хэмжээгээр аль хэдийн оногдуулчихсан хэргүүдэд санхүүгийн хориг тавьж болно. Санхүүгийн хоригийг тэгш хэмийн зарчим хангагдаж байгаа газруудад л тавина. Ямар нэгэн зардал нөхөн төлөх буюу санхүүгийн хоригийг энэхүү хуулийн дагуу эрх хасах буюу бусад хоригийн хугацааг бууруулах нөхцөл хэмээн тооцохгүй.

10.11. Эрх хассан хугацаа эхлэх

Дор зааснаас бусад тохиолдолд эрх хасах хугацаа нь тухайн эрх хасах шийдвэрийг сонсгосон өдрөөс эхлэх ба хэрэв шийдвэрийг хойшлуулсан буюу ямар нэгэн хуралдан явуулаагүй бол эрх хасахыг хүлээн зөвшөөрсөн буюу бусад ямар нэгэн хэлбэрээр оногдуулсан өдрөөс эхлэн тооцно.

### **10.11.1. Тамирчин буюу бусад этгээдээс хамааралгүйгээр хойшлуулах**

Хурал болон допингийн хяналтын бусад үйл ажиллагааг нилээд хугацаагаар хойшлуулсан тохиолдолд тухайн шийтгэлийг оногдуулж байгаа этгээд нь тухайн эрх хассан хугацааг дээж авсан өдөр буюу допингийн эсрэг хууль зөрчсөн үйлдэл тохиосон өдрөөс эхлэн тооцно. Энэ эрх хассан хугацаанд тэр дундаа ретроактив эрх хасагдсан хугацаанд олсон аливаа тэмцээний амжилт үр дүнг хүчингүй болгоно.

*10.11.1 зүйлд хийх тайлбар: Энэхүү дүрмийн 2.1 хэсэгт зааснаас бусад хэлбэрээр допингийн эсрэг хууль зөрчигдсөн тохиолдолд допингийн эсрэг байгууллагад допингийн эсрэг хууль зөрчигдсөнийг тогтоох хангалттай баримт илрүүлэн боловсруулахад урт хугацаа шаардагдааж болно. Ялангуяа тамирчин буюу бусад этгээд баригдахаас зайлсхийн баталгаажуулах арга хэмжээ авсан байж болно. Ийм тохиолдолд энэхүү зүйлд заасан шийтгэл эрт эхлэх уян хатан байдал ашиглагдахгүй.*

### **10.11.2. Цаг хугацаанд нь хүлээн зөвшөөрөх**

Тамирчин буюу бусад этгээд допингийн эсрэг байгууллагаа допингийн эсрэг хууль зөрчсөн талаар мэдэгдэнгүүт допингийн эсрэг хууль зөрчсөнөө хүлээн зөвшөөрсөн тохиолдолд эрх хасах хугацаа нь дээж авсан өдөр буюу допингийн эсрэг хуулийн хамгийн сүүлд зөрчигдсөн өдрөөс эхлэн тоологдоно. Энэхүү заалт нь 10.6.3 зүйлийн дагуу эрх хасах хугацааг багасгасан нөхцөлд үйлчлэхгүй.

### **10.11.3. Хэсэгчлэн хүчингүй болгох хугацааг эрх хасуулсан хугацаанаас зээлдэх**

**10.11.3.1. Хэрэв хэсэгчлэн хүчингүй болгох шийдвэрийг тамирчин буюу бусад этгээдэд оногдуулсан бол тухайн тамирчин буюу бусад этгээд нь хэсэгчлэн хүчингүй болгох хугацааг эрх хасуулсан хугацаанаас зээлдэн тооцно. Хэрэв эрх хасуулах хугацааг холбогдох шийдвэрийн дагуу нэн даруй тооцох ёстой бол давж заалдах шатнаас оногдуулж болох эрх хасах хугацаанаас зээлдэн тооцно.**

10.11.3.2. Хэрэв тамирчин буюу бусад этгээд хэсэгчлэн хүчингүй болгох шийдвэрийг сайн дураар хүлээн авч үр дүнгийн менежментийн хариуцлага хүлээсэн Допингийн эсрэг байгууллагад бичгээр мэдэгдэн, дараа нь хэсэгчлэн хүчингүй болгох шийдвэрийг гаргасан бол тухайн тамирчин буюу бусад этгээд нь хэсэгчлэн хүчингүй болгох хугацааг эрх хасуулсан хугацаанаас зээлдэн тооцно. Тамирчин буюу бусад этгээдийн хэсэгчлэн хүчингүй болгох шийдвэрийг сайн дураар хүлээн авсан албан бичгийн хуулбарыг энэхүү журмын 14.1 зүйлийн дагуу допингийн дүрэм зөрчсөн талаар мэдэгдэл хүлээн авах эрхтэй талуудад нэн даруй хүргүүлнэ.

*10.11.3.2 зүйлд хийх тайлбар: Хэсэгчлэн хүчингүй болгосон шийдвэрийг тамирчин сайн дураар хүлээн авах нь тамирчин хүлээн зөвшөөрсөн үйлдэл болохгүй бөгөөд тамирчны талаар сөрөг тайлбар хийх үндэслэл болохгүй.*

10.11.3.3. Хэсэгчлэн хүчингүй болгох буюу сайн дураар хэсэгчлэн хүчингүй болгох хүчинтэй хугацаа эхлэхээс өмнө тухайн тамирчныг тэмцээнд оруулахаар сонгон авсан буюу багаас хассан эсэхээс үл хамааран эрх хассан хугацаанд зээлдэх эрх идэвхижихгүй.

10.11.3.4. Багийн спортом багт нь эрх хасах хугацааг зааж өгсөн бол эрх хасах хугацааг эрх хасах талаар эцсийн шийдвэр гарсан өдрөөс эхлэн тооцно. Хэрэв хуралдааныг хүчингүй болгосон бол эрх хассан шийдвэр оногдуулсан буюу хүлээн авсан өдрөөс эхлэн тооцно.

*10.11 зүйлд хийх тайлбар: Энэхүү зүйл нь тамирчны хувьд хугацаа хоцрох зүйл байхгүй бөгөөд цаг хугацаанд нь үйлдлээ хүлээн зөвшөөрөх болон хэсэгчлэн хүчингүй болгох нь эцсийн шийдвэр гарахаас өмнө эрх хасах хугацааг эхлүүлэх үорын ганц арга зам гэдгийг ойлгуулдаг.*

## 10.12. Эрх хассан хугацаан дах статус

### 10.12.1. Эрх хассан хугацаанд тэмцээнд оролцохыг хориглох

Эрх хассан хэмээн зарласан аливаа тамирчин буюу этгээд эрх хассан хугацаанд аливаа тэмцээн уралдаан болон (допингийн эсрэг боловсрол олгох буюу сэргээх хөтөлбөрөөс бусад) гарын үсэг зурсан талуудаас зохион байгуулж байгаа буюу хүлээн зөвшөөрсөн үйл ажиллагаанд ямар нэгэн байдлаар оролцож болохгүй. Гарын үсэг зурсан талын гишүүн байгууллагууд, клуб буюу гарын үсэг зурсан талын гишүүн байгууллагуудын бусад гишүүн байгууллага эсвэл мэргэжлийн аливаа лигээс эсвэл үндэсний болон олон улсын үйл ажиллагаа зохион байгуулагчид, аливаа элит болон үндэсний түвшний төрийн байгууллагаас хүлээн зөвшөөрч санхүүжүүлсэн спортын үйл ажиллагаанууд зэргээс зохион байгуулсан аливаа тэмцээн уралдаанууд оролцож болохгүй.

Тамирчин буюу бусад этгээд 4 жилээс дээш хугацаанд эрх хасуулсан үед энэхүү эрх хасагдсан 4 жилийн хугацаа дуусангүйт гарны үсэг зурсан талууд болон гишүүн орнуудаас хориглоогүй аливаа дотоодын тэмцээн уралдаанд тамирчин байдлаар оролцож болно. Гэхдээ орон нутгийн спортын тэмцээн уралдаан нь тухайн тэмцээнд шууд болон шууд бусаар тухайн тамирчин буюу этгээдийг дүгнэх боломжгүй учраас үндэсний тэмцээн болон олон улсын үйл ажиллагаанд оролцож байгаа этгээд болон насанд хүрээгүй хүүхдүүдтэй ажиллаж байгаа ямар нэгэн тамирчин болон бусад этгээдийг хамрахгүй.

*10.12.1 зүйлд хийх тайлбар: 10.12.2 зүйлд заасанчлан эрхээ хасуулсан тамирчин нь дасгал хийж байгаа хэсэг болон өөрийн үндэсний холбооноос зохион байгуулж байгаа дадлага үзүүлбэрийн ажлууд эсвэл үндэсний холбооны гишүүнчлэлтэй эсвэл засгийн газрын байгууллагаас санхүүжүүлдэг аливаа үйл ажиллагаанд оролцох боломжгүй. Түүнээс гадна эрх хасуулсан тамирчин нь гишүүн бус орнуудын мэргэжлийн лиг, Америкийн Үндэсний Сагсан Бөмбөгийн Холбоо, Үндэсний Хоккейн Лиг гэх мэтийн мэргэжлийн лигийн үйл ажиллагаа, гишүүнчлэлгүй орнуудын үндэсний тэмцээн уралдаан энэхүү дүрмийг 10.12.3 зүйлд заасан үр дагаврыг бий болгохгүйгээр оролцох боломжгүй. Үйл ажиллагаа гэдэгт энэхүү дүрэмд заасан байгууллагад ажилтан захирал, албан хаагч эсвэл сайн*

*дурын ажилтнаар ажиллах гэх мэтийн захиргааны ажлуудыг бас багтаан үзнэ. Нэг спортод тэмцээн уралдаанд орох эрхээ хасуулах нь бусад спортуудад бас эрхээ хасуулна гэсэн үг юм. (15.1 зүйл. Харилцан хулээн зөвшөөрөх)*

### 10.12.2 Бэлтгэлд ирэх эрх

Энэхүү хуулийн 10.12.1 зүйлд зааснаас бусад тохиолдолд тамирчин нь багтайгаа дасгал сургууль хийх буюу гишүүн байгууллагуудын клуб болон бусад хэсгүүдийн тоног төхөөрөмжүүдийг ашиглаж болно. Үүнд:

1. Тамирчин эрхээ хасуулсан сүүлийн 2 сард
2. Эрх хасах хугацааны сүүлийн 1/3-т гэх мэт

*10.12.2 зүйлд хийх тайлбар: ихэнх багийн спорт болон зарим хувийн спортууд тамирчины эрх хасах хугацаа дууссангуут тэмцээнд оролцоход бэлэн байхаар нөхцөл байдалд байгаа тамирчныг идэвхитэйгээр дасгалжуулж болох ба энэхүү зүйлд заасан эрх хасуулсан тамирчин нь сургалтаас өөр 10.12.1 зүйлд заасан аливаа тэмцээн уралдаанд оролцохгүй.*

### 10.12.3 Эрх хасуулсан хугацаанд тэмцээнд оролцохыг хориглосон дүрмийг зөрчих

Эрхээ хасуулсан хэмээн зарлагдсан тамирчин буюу бусад этгээд нь энэхүү дүрмийн 10.12.1 зүйлд заасан эрх хасуулсан хугацаанд аливаа тэмцээн уралдаанд оролцохыг хориглосон заалтыг зөрчсөн бол оролцсон тэмцээн уралдааны үр дүнг хүчингүй болгон тэмцээнд оролцох үеийн хугацааг нэмж эрх хасах хугацааг шинээр тооцно. Шинэ эрх хассан хугацааг хэргийн нөхцөл байдал болон тамирчин ба бусад этгээдийн алдааны түвшинээс хамааран тогтооно. Тамирчин нь тэмцээнд оролцохгүй байх дүрмийг зөрчсөн эсэх болон ийм үйлдэл хийсэн нь үнэн зөв байсан эсэх талаар холбогдох шийдвэрийг эрх хассан анхны хугацааг тооцон үр дүнгийн менежмент явуулдаг допингийн эсрэг байгууллага явуулна. Энэхүү шийдвэрийн талаар 13-р зүйлд заасан дүрмийн дагуу давж заалдаж болно.

Эрх хасуулсан хугацаанд тамирчиныг дэмжих этгээд буюу бусад этгээд допингийн эсрэг дүрэм зөрчсөн аливаа этгээдийг дэмжсэн тохиолдолд допингийн эсрэг байгууллагаас энэхүү дүрмийн 2.9 зүйлийг зөрчсөн хэмээн үзэж холбогдох шийтгэлийг оногдуулна.

10.12.4 эрх хасуулсан хугацаанд санхүүгийн туслалцаа үзүүлэхээс татгалзах энэхүү дүрмийн 10.4 болон 10.5 зүйлүүдэд заасан шийтгэлүүдийг багтаагаагүй тохиолдолд спорттой холбоотой санхүүгийн туслалцаа болон бусад спорттой холбоотой давуу талуудыг олгох эрхийг гарын үсэг зурсан орнууд, түүний гишүүн байгууллагууд засгийн газраас хориглоно.

### 10.13. Шийтгэлийн талаар автоматаар нийтлэх

Энэхүү хуулийн 14.3 зүйлд зааснаар оногдуулах шийтгэлийн зайлшгүй хэсэг нь автоматаар олон нийтэд шийтгэлийн талаар хэвлэх явдал юм.

*10-р зүйлд хийх тайлбар: шийтгэлийг тохируулан өгөх гэдэг нь допингийн хамгийн маргаантай хамгийн их яригддаг асуудлуудын нэг юм. Тохируулах гэдэг нь хэрэг бүртгэх ижилхэн шалгуур дүрмийг баримтлана гэсэн уг. Тохируулахтай холбоотой маргаанууд нь ихэнхдээ аль нэг спортын төрөл хоорондын зөрчилдөөнтэй заалтуудыг хамардаг. Жишээ нь зарим спортын төрлүүдэд тамирчид нь өөрийн спортын уйл ажиллагаанаас их хэмжээний ашиг олдог мэргэжлийн тамирчид байхад зарим спортын хувьд жинхэнэ сонирхогчид байдаг. Тамирчины карьерын нас богино байдаг спортын төрлүүдийн хувьд эрх хасах стандарт хугацаа нь тамирчинд илүү чухал ач холбогдолтой байхад зарим спортын хувьд хичээллэх нас нь харьцангуй урт байдаг. Тохируулахтай холбоотой үндсэн маргаан нь нэг улсаас ирсэн ижил нөхцөл байдалд ижил допингийн шинжилгээ өгч ижил хариу авсан хоёр тамирчины хувьд оролцож байгаа спортоосоо шалтгаалан өөр өөр шийтгэл оногдуулдаг. Түүнээс гадна шийтгэлийн уян хатан байдал гэдгийг зарим спортын байгууллагууд байж боломжгүй зүйл хэмээн үзэж допингийн төрлийн бодис хэрэглэгчидтэй илүү хатуу ханддаг. Ингэж шийтгэл харилцан адилгүй байх нь олон улсын холбоод болон допингийн эсрэг үндэсний байгууллагуудын хооронд эрх зүйн зөрчлийг үүсгэх гол эх үүсвэр болдог.*

## **11-р зүйл: Багт гарах үр нөлөө**

### **11.1. Багийн спортоод шалгалт хийх**

Үйл ажиллагаатай холбогдуулан багийн тамирчдын нэгээс дээш хүн 7-р зүйлд заасан допингийн эсрэг хууль зөрчсөн талаар мэдэгдэл хүлээн авсан бол тухайн үйл ажиллагааг зохион байгуулж байгаа тал нь үйл ажиллагааны явцад холбогдох зорилтот шалгалтыг тухайн багт явуулна.

### **11.2. Багийн спортоод гарах үр нөлөө**

Үйл ажиллагаатай холбогдуулан багийн тамирчдын хоёроос дээш хүн допингийн эсрэг хууль зөрчсөн талаар мэдэгдэл хүлээн авсан бол тухайн үйл ажиллагааг зохион байгуулж байгаа тал нь үйл ажиллагааны явцад допингийн эсрэг хууль зөрчсөний төлөө тамирчинд оногдуулсанаас гадна бусад холбогдох шийтгэлийг (оноо алдах, тэмцээн буюу үйл ажиллагаанаас хасах, бусад шийтгэлүүд) тухайн багт оногдуулна.

11.3 Үйл ажиллагааг зохион байгуулж байгаа этгээдүүд багт илүү шийтгэл оногдуулж болно.

Үйл ажиллагааг зохион байгуулагч нь тухайн үйл ажиллагааны зорилгоор энэхүү дүрмийн 11.2 зүйлд зааснаас өөр илүү хүнд шийтгэлийг багийн спортын гэмт үйлдэлд оногдуулна.

*11.3 зүйлд хийх тайлбар: Жишээ нь Олон Улсын Олимпийн Хороо нь олимпийн тогтолтын явцад илүү цөөн тооны хүн допингийн дүрэм зөрчдөг хэмээн тооцож багийг хасах дүрмийг оруулдаг.*

## **12-р зүйл: Спортын байгууллагад ноогдуулах шийтгэл**

Энэхүү хуулийн ямар ч заалт нь гарын үсэг зурсан аль нэг тал буюу засгийн газрыг энэхүү хуулийг хүлээн зөвшөөрөх, эсвэл гарын үсэг зурсан тал болон түүний гишүүн, засгийн газрын удирддаг аль нэг спортын байгууллагад шийтгэл оногдуулах зорилгоор өөрийн дүрэм дүрмийг хэрэгжүүлэхэд саад болох ёсгүй.

*12-р зүйлд хийх тайлбар: Энэхүү зүйлд зааснаар байгууллага хоорондын сахилгын эрх өөр өөр байж болно гэдгийг энэ хуульд хязгаарлахгүй.*

## **13-р зүйл: давж заалдах**

### **13.1. Давж заалдах шийдвэрүүд**

Энэхүү хуулийн дагуу гаргасан аливаа шийдвэр буюу баталсан дүрэм журмын талаар энэхүү хуулийн 13.2-4 заалтанд заасны дагуу буюу бусад заалт, олон улсын стандартад заасны дагуу давж заалдаж болно. Давж заалдах шатны байгууллагаас өөрөөр заагаагүй бол тухайн шийдвэрийг давж заалдах хүртэл тухайн шийдвэр хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ. Давж заалдах үйл ажиллагаа эхлэхээс өмнө шийдвэрийн дараах хяналтын талаар допингийн эсрэг байгууллагын журамд заасан заалтууд хүчин төгөлдөх хэвээр дор дурьдсан 13.2.2 заалтын дагуу хянаж үзнэ. (Энэхүү хуулийн 13.1.3-т зааснаас бусад тохиолдолд)

**13.1.1 Хяналтын хүрээ хязгааргүй байх:** Давж заалдах хяналтын хүрээ нь тухайн асуудалтай холбоотой бүх зүйлсийг багтааж анхны шийдвэр гаргагчаас өмнө хянаж үзсэн асуудлаар хязгаарлагдахгүй.

**13.1.2 Спортын арбитрийн шүүх нь давж заалдаж байгаа баримтуудыг шийдвэр гаргахдаа ирүүлсэн баримтуудыг задлан үзэхгүй бөгөөд эдгээр баримтуудын талаар нууцлалын хариуцлага хүлээх шаардлагагүй.**

**13.1.2 зүйлд хийх тайлбар:** Спортын арбитрийн шүүхийн журам нь шинэ зүйл биш. Өмнөх журмаар нотлох баримтыг хязгаарлах буюу Спортын арбитрийн шүүхийн өмнө сонсгол хийх үйлдэлд хориг тавьдаггүй байсан.

**13.1.3 ДДЭА нь дотоод засварын аргуудыг хэрэглэх шаардлагагүй.**

ДДЭА нь энэхүү хуулийн 13-р зүйлд заасны дагуу давж заалдах эрхтэй байгаа үед бусад аль нэг тал нь допингийн эсрэг байгууллагын хуулийн хүрээнд эцсийн шийдвэрийн талаар давж заалдаагүй бол ДДЭА нь допингийн эсрэг байгууллагын хуулийн дагуу бусад арга хэмжээг авалгүйгээр тухайн шийдвэрийн талаар шууд Спортын арбитрийн шүүхэд гомдол гаргаж болно.

**13.1.3 зүйлд хийх тайлбар:** Допингийн эсрэг байгууллагын хуулийн эцсийн шатанд шийдвэр гаргахаас өмнө ямар нэгэн шийдвэр гарсан буюу эсвэл аль нэг тал нь тухайн шийдвэрийн

*талаар допингийн эсрэг байгууллагын дараагийн шатанд (Жишээ нь удирдах зөвлөлд) гомдол гаргахаар сонгоогүй бол ДДЭА нь допингийн эсрэг байгууллагын дотоод журмын үлдсэн үе шатуудыг алгасан шууд Спортын арбитрийн шүүхэд давж заалдаж болно.*

**13.2** Допингийн эсрэг хууль зөрчсөн, түүний үр дагавар, хэсэгчлэн хүчингүй болгох, шийдвэр хууль тогтоомжийг хүлээн зөвшөөрөх зэрэг асуудлаар гаргасан шийдвэрийн эсрэг давж заалдах

Допингийн эсрэг хууль зөрчигдөөгүй талаарх шийдвэр, үр дүн үүссэн буюу үүсээгүй талаарх шийдвэр, ямар нэгэн допингийн эсрэг хууль зөрчсөн үйлдэл хийгээгүй талаарх шийдвэр, дүрмийн дагуу допингийн эсрэг хууль зөрчсөн талаар мөрдөлтийг үргэлжлүүлэх боломжгүй тухай шийдвэр, энэхүү хуулийн 5.7.1 зүйлийн дагуу зодог тайлсан тамирчинд тэмцээнд эргэн оролцох талаар 6 сарын өмнөөс мэдэгдэл өгөх шаардлагаас чөлөөлөхгүй байх тухай ДДЭА-гийн шийдвэр, энэхүү хуулийн 7.1 зүйлд зааснаар үр дүнгийн менежмент тооцох тухай ДДЭА-гийн шийдвэр, Сөрөг аналитик үзүүлэлт болон хэвийн бус үзүүлэлтүүдийг допингийн эсрэг хууль зөрчсөн үйлдэл болгон оруулахгүй байх тухай допингийн эсрэг байгууллагын шийдвэр, эсвэл энэхүү хуулийн 7.7 зүйлд заасан шинжилгээ явуулсаны дараа допингийн эсрэг хууль зөрчсөн үйлдэл явуулахгүй байх, хэсэгчилсэн сонсголын үндсэн дээр хэсэгчлэн хүчингүй болгох шийдвэр гаргах, допингийн эсрэг байгууллага нь энэхүү хуулийн 7.9 заалтыг зөрчсөн талаарх шийдвэр, допингийн эсрэг хууль зөрчсөн болон түүний үр дагавартай холбоотой үйлдэлд хуйвалдан оролцсон тохиолдолд зохицуулах хууль, дүрэм допингийн эсрэг байгууллагад байдаггүй талаарх шийдвэрүүд, 10.6.1 заалтын дагуу эрх хасах хугацааг цуцлах буюу цуцлахгүй байх эсвэл эрх хасах хугацааг багасгасан шинэ хугацааг дурьдах буюу дурьдахгүй байх талаар гаргасан шийдвэрүүд, 10.12.3 зүйлийн дагуу гаргасан шийдвэр энэхүү хуулийн 15-р зүйлд заасан өөр допингийн эсрэг байгууллагын гаргасан шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй байх тухай допингийн эсрэг байгууллагын шийдвэрийг тус тус энэхүү хуулийн 13.2-т заасны дагуу давж заалдаж болно.

**13.2.1** Олон улсын хэмжээний тамирчин болон олон улсын тэмцээн уралдаантай холбоотой давж заалдах өргөдлүүд.

Олон улсын тэмцээнд оролцсонтой холбоотой болон олон улсын хэмжээний тамирчидтай холбоотой асуудлаар гаргасан шийдвэрийн талаар зөвхөн Спортын арбитрийн шүүхэд давж заалдаж болно.

*13.2.1 зүйлд хийх тайлбар: Арбитрийн шүүхээс хүчин төгөлдөр болох буюу цуцлахыг хуулиар шаарддаг хэргүүдээс бусад тохиолдолд Спортын арбитрийн шүүхийн шийдвэр нь эцсийн бөгөөд заавал биелүүлэх шийдвэр байна.*

13.2.2 Бусад тамирчин болон бусад этгээдтэй холбоотой давж заалдах өргөдлүүд энэхүү хуулийн 13.2.1 заалттай хамааралгүй хэргүүдийн хувьд бие даасан этгээдүүд допингийн эсрэг үндэсний байгууллагаас баталсан дүрмийн дагуу давж заалдаж болно. Ингэж давж заалдах дүрэм нь дараах зарчмуудыг баримтална. Үүнд:

- Цаг хугацаанд нь сонсгол хийх
- Шударга салшгүй зөвлөлтэй байх
- Тухайн этгээдийн өөрийн зардлаар төлөөлөгчөөр төлөөлүүлэх эрх
- Цаг хугацаанд нь бичгээр үндэслэлтэй шийдвэр гаргах

13.2.3 Давж заалдах эрхтэй этгээдүүд

13.2.1 зүйлд заасан хэргүүдэд дараах этгээдүүд Спортын арбитрийн шүүхэд давж заалдах эрхтэй байна. Үүнд:

- A. Давж заалдаж байгаа шийдвэртэй холбоотой тамирчин буюу бусад этгээд
- B. Шийдвэр хамааралтай бусад этгээд
- C. Холбогдох олон улсын холбоо
- D. Тухайн этгээдийн оршин сууж байгаа буюу иргэний үнэмлэх эзэмшдэг орны допингийн эсрэг үндэсний байгууллага
- E. Тухайн хэрэг нь олимпын тоглолт буюу параолимпын тоглолттай хамааралтай байгаа тохиолдолд Олон Улсын Олимпын Хороо буюу Олон Улсын Паралимпын хороо
- E. ДДЭА

13.2.2 зүйлд хамаарах хэргийн хувьд үндэсний давж заалдах байгууллагад давж заалдах эрхтэй талууд нь допингийн үндэсний эсрэг байгууллагын дүрэмд заасан байгууллагууд байх бөгөөд дор хаяж дараах талуудыг багтаасан байх ёстой. Үүнд:

- A. Давж заалдаж байгаа шийдвэртэй холбоотой тамирчин буюу бусад этгээд
- B. Шийдвэр хамааралтай бусад этгээд
- C. Холбогдох олон улсын холбоо
- D. Тухайн этгээдийн оршин сууж байгаа буюу иргэний үнэмлэх эзэмшдэг орны допингийн эсрэг үндэсний байгууллага
- E. Тухайн хэрэг нь олимпын тоглолт буюу параолимпын тоглолттой хамааралтай байгаа тохиолдолд Олон Улсын Олимпын Хороо буюу Олон Улсын Паралимпын хороо
- F. ДДЭА

13.2.2 зүйлд хамааралтай хэргүүдийн хувьд ДДЭА, Олон Улсын Олимпын Хороо, Олон Улсын Паралимпын Хороо болон холбогдох олсон улсын холбоонууд тус тус үндэсний түвшиний давж заалдах шатны байгууллагаас гаргасан шийдвэрийн талаар Спортын арбитрийн шүүхэд давж заалдах эрхтэй. Давж заалдах материал бүрдүүлж байгаа тал нь шийдвэрийг нь давж заалдаж байгаа допингийн эсрэг байгууллагаас холбогдох бүх мэдээллийг авахад Спортын арбитрийн шүүхээс туслалцаа авах эрхтэй.

ДДЭА-гаас давж заалдах гэж байгаа хэргийн материал бүрдүүлэх эцсийн хугацаа нь:

- A. Хэргийн нөгөө талаас давж заалдах боломжтой байсан сүүлийн өдрөөс хойш 21 хоног
- B. ДДЭА-гаас шийдвэртэй холбоотой бүх бичиг баримтуудыг хүлээн авсанаас хойш 21 хоног байна.

Энэхүү заалтад хамаарахгүйгээр хэсэгчлэн хүчингүй болгосон шийдвэрийн талаар давж заалдаж байгаа этгээд нь тухайн

хэсэгчлэн хүчингүй болгосон заалтыг хүлээн авсан тамирчин буюу бусад этгээд байна.

#### 13.2.4 Харилцан давж заалдах болон бусад дараалан давж заалдах нөхцлүүд

Энэхүү хуулийн дагуу Спортын арбитрийн шүүхэд ирүүлсэн хэргүүд дэх хариуцагчаас харилцан давж заалдах болон бусад дараалан давж заалдахыг тусгайлан зөвшөөрдөг. 13-р зүйлийн дагуу давж заалдах эрхтэй аль нэг тал нь нөгөө талын хамгийн сүүлийн хариутай холбоотойгоор харилцан давж заалдах болон дараалан давж заалдах баримт бүрдүүлэх ёстой.

*13.2.4 зүйлд хийх тайлбар: 2011 оноос хойши Спортын арбитрийн шүүхийн журмаар тамирчны давж заалдах хугацаа дууссанаас хойши допингийн эсрэг байгууллага нь гарсан шийдвэрийн талаар давж заалдах үед тамирчин харилцан давж заалдах эрхгүй болсон. Энэхүү заалт бүх талуудын дуу хоолойг сонсох боломжтой болгосон.*

#### 13.3. Допингийн эсрэг байгууллагаас цаг хугацаанд нь шийдвэр гаргаж чадаагүй байх

Тодорхой нөхцөлүүдэд допингийн эсрэг хууль зөрчсөн үйлдэл нь ДДЭА-аас тогтоосон тодорхой хугацааны дотор болсон эсэх талаар Допингийн Эсрэг Байгууллага нь шийдвэр гаргаж чадаагүй үед допингийн эсрэг байгууллага нь допингийн эсрэг хууль зөрчөөгүй гэсэн шийдвэр гаргачихсан юм шиг ДДЭА нь шууд Спортын арбитрийн шүүхэд хандах сонголт хийж болно. Хэрэв Спортын арбитрийн шүүхийн шийдвэр гаргах зөвлөл нь допингийн эсрэг хууль зөрчигдсөн ба ДДЭА нь шууд Спортын арбитрийн шүүхэд хандах сонголт хийсэн хэмээн ДДЭА нь тодорхойлвол ДДЭА-ийн давж заалдах үйл ажиллагааны болон өмгөөллийн зардлыг Допингийн Эсрэг Байгууллагаас ДДЭА-д нөхөн төлнө.

*13.3 зүйлд хийх тайлбар: допингийн эсрэг хууль зөрчсөн үйлдэл мөрдөн судлах болон үр дүнгийн менежментийн төрөл бүрийн нөхцөл байдалд ДДЭА нь шууд Спортын арбитрийн шүүхэд хандахаас өмнө допингийн эсрэг байгууллагад шийдвэр гаргах тодорхой хугацаа өгөх хэрэгтэй. Гэхдээ ийм үйлдэл хийхээс өмнө ДДЭА нь допингийн эсрэг байгууллагатай*

*зөвлөн түүнд яагаад хараахан шийдвэр гаргаагүй байгаагаа тайлбарлах боломж олгоно. Энэ зүйлийн ямар ч заалт нь олон улсын холбоог үндэсний холбоодын аль нэгнийх нь явуулсан үр дүнгийн менежмент зүй бусаар хойшлогдсон хэргийн талаар хуульзүйн тайлбар гаргах боломж олгосон дүрэм журамтай байхаас сэргийлэх ёсгүй.*

#### 13.4. Эмчилгээний зориулалтаар ашиглах бодистой холбоотой давж заалдах

Эмчилгээний зориулалтаар ашиглах бодистой холбоотой шийдвэрийг зөвхөн 4.4 зүйлд заасан нөхцлөөр л давж заалдаж болно.

#### 13.5. Давж заалдах шийдвэрийн талаарх мэдэгдэл

Давж заалдаж байгаа аливаа допингийн эсрэг байгууллага нь энэхүү хуулийн 14.2 зүйлд заасанчлан 13.2.3 зүйлийн дагуу давж заалдах эрхтэй тамирчин буюу бусад этгээд, мөн бусад допингийн эсрэг байгууллагад давж заалдах шийдвэрээ нэн даруй хүргүүлнэ.

#### 13.6. Хуулийн гурав болон дөрөвдүгээр бүлгийн шийдвэртэй холбогдуулан давж заалдах

Энэхүү хуулийн 23.5.4 зүйлд заасны дагуу тохиоогүй талаарх ДДЭА-ийн мэдээлэлтэй болон хуулийн гуравдугаар бүлэг (Үүрэг Хариуцлага)-ийн дагуу үүсэх үр дагавартай холбогдуулан хуулийн гуравдугаар бүлэг (Үүрэг Хариуцлага)-ийн дагуу үүсэх үр дагаварын нөлөөг амсах байгууллага нь холбогдох заалтын дагуу шүүхээс өмнө шууд Спортын арбитрийн шүүхэд хандаж болно.

#### 13.7. Лабораторийн магадлан итгэмжлэлийг цуцлах буюу татгалзах шийдвэрийн талаар давж заалдах

ДДЭА-аас гаргасан Лабораторийн магадлан итгэмжлэлийг цуцлах буюу татгалзах шийдвэрийн талаар давж заалдах үйлдлийг зөвхөн тухайн лаборатори нь Спортын арбитрийн шүүхэд шууд гаргаж болно.

***13-р зүйлд хийх тайлбар:** Энэхүү хуулийн зорилго нь допингтэй холбоотой асуудлыг шударга ил тод байдлаар шийдвэрлэн эцэст нь давж заалдах боломж олгох явдал юм.*

*Допингийн эсрэг байгууллагаас гаргасан допингийн талаарх шийдвэр нь 14-р зүйлд заасанчлан ил тод гарсан. ДДЭА зэрэг тусгай байгууллага, хүмүүс эдгээр шийдвэрийн талаар давж заалдах эрхтэй. Гэхдээ 13-р зүйлд заасан давж заалдах эрхтэй сонирхсон этгээдүүд болон байгууллага гэсэн тодорхойлолтод хэн нэгэн тамирчны эрх хасуулснаас давуу талыг олж болох тамирчин болон тэдний холбоо ордоггүй гэдгийг санаарай.*

## **14-р зүйл: Нууцлал ба мэдээлэл**

Допингийг зохицуулах, олон нийтэд ил байх, тооцоотой байх зарчмууд болон бүх тамирчид ба бусад этгээдүүдийн хувийн нууцыг хадгалах зарчмууд нь дараах байдалтай байна. Үүнд:

14.1. Сөрөг аналитик үзүүлэлт, энгийн бус үзүүлэлт, бусад допингийн эсрэг хууль зөрчсөн үйлдлийн талаарх мэдээлэл

14.1.1. Допингийн эсрэг хууль зөрчсөн үйлдлийн талаар тамирчин болон бусад этгээдэд мэдэгдэх

Допингийн эсрэг хууль зөрчсөн үйлдлийн талаар мэдээлэх хэлбэр болон арга нь үр дүнгийн менежментийн хариуцлагатай Допингийн эсрэг байгууллагын дүрэмд заасан шиг байна.

14.1.2. Допингийн эсрэг хууль зөрчсөн үйлдлийн талаар Допингийн Эсрэг Үндэсний Байгууллага, Олон Улсын Холбоо болон ДДЭА-д мэдээлэх

Үр дүнгийн менежментийн хариуцлагатай допингийн эсрэг байгууллага нь бас Тамирчны Допингийн Эсрэг Үндэсний Байгууллага, Олон улсын Холбоо болон ДДЭА-д допингийн эсрэг хууль зөрчсөн үйлдлийн талаарх мэдээллийг Тамирчин болон бусад этгээдэд хүргүүлэх мэдэгдэлтэй зэрэг хүргүүлнэ.

14.1.3. Допингийн эсрэг хууль зөрчсөн үйлдлийн талаарх мэдээллийн агуулга

Мэдэгдэлд дараах зүйлсийг багтаана.

Үүнд: тамирчны нэр, улс, спорт, спорт доторх төрөл, тамирчны өрсөлдөх зэрэг, тестийг тэмцээний үеэр буюу тэмцээний бус үеэр авсан, дээж авсан огноо, лабораториос авсан анализ хариу, олон улсын тест шинжилгээний стандартад шаардсан бусад

мэдээлэл буюу 2.1 зүйлээс бусад допингийн эсрэг хууль зөрчсөн тохиолдолд зөрчил гарсан үндэслэл.

#### 14.1.4. Одоогийн байдлын талаарх мэдээлэл

Энэхүү хуулийн 14.1.1 хэсэгт заасан допингийн эсрэг хууль зөрчсөн талаарх мэдэгдэл гаргахад хүргэсэн судлан мөрдөх ажлаас бусад тохиолдолд 14.1.2 хэсэгт заасан допингийн эсрэг байгууллагууд нь энэхүү хуулийн 7, 8, 13 дугаар зүйлүүдэд заасан өөрийн статус болон хянаж үзэх мэдээллээ бичгэн хэлбэрээр гаргасан тайлбар болон шийдвэрийг тайлбарласан үндэслэлийн хамтаар ирүүлнэ.

#### 14.1.5. Нууцлал

Энэхүү хуулийн 14.3 зүйлд заасанчлан үр дүнгийн менежментийн хариуцлага хүлээсэн Допингийн эсрэг байгууллага олон нийтэд мэдээлэл тараасан буюу тарааж чадаагүй хүртэл шинжилгээний хариуг хүлээн авсан байгууллага нь тухайн мэдээллийг зайлшгүй олж мэдэх шаардлагатай (Үндэсний Олимпийн Хороо, Үндэсний Холбоо, багийн спортын хувьд баг зэрэг) этгээдүүдээс бусад хэн нэгэн этгээдэд дээрх мэдээллийг задруулахгүй.

*14.1.5 зүйлд хийх тайлбар: Допингийн эсрэг байгууллага бүр нь өөрийн допингийн эсрэг хуулийн дагуу мэдээллийн нууцлалыг хадгалах дүрэм болон допингийн байгууллагын ажилтан болон төлөөлөгчдөөс мэдээллийн нууцыг хууль бусаар задруулсантай холбоотой мөрдөх сахилгын хариуцлага хүлээлгэх дүрмийг тус тус гаргана.*

### 14.2. допингийн эсрэг хууль зөрчсөн шийдвэрийн талаар мэдэгдэх ба хаваст хэрэгт оруулах материал хүсэх

14.2.1. Энэхүү хуулийн 7.10, 8.4, 10.4, 10.5, 10.6, 10.12.3, 13.5 зүйлүүдэд заасан допингийн эсрэг хууль зөрчсөн талаарх шийдвэр нь тухайн шийдвэрийг гаргах болсон шалтгаан, тэр дундаа хамгийн өндөр хэмжээний шийтгэлийг яагаад оногдуулаагүй талаарх тайлбарыг багтаана. Хэрвээ тухайн шийдвэр англи буюу франц хэл дээр байхгүй бол тухайн шийдвэр болон холбогдох тайлбарыг англи буюу франц хэлээр оруулна.

14.2.2. Энэхүү хуулийн 14.2.1 зүйлд заасны дагуу

шийдвэрийн талаар давж заалдах эрхтэй допингийн эсрэг байгууллага нь шийдвэр хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэргийн бүтэн хавтаст хэргийн хуулбарыг хүсч болно.

#### 4.3 Олон нийтэд зарлах

14.3.1 Үр дүнгийн менежментийн хариуцлага хүлээсэн допингийн эсрэг байгууллагаас энэхүү хуулийн 7.3, 7.4, 7.5, 7.6 7.7 зүйлүүдэд заасан тамирчин болон бусад этгээд, 14.1.2 зүйлд заасан допингийн эсрэг байгууллагуудад мэдэгдэл өгсөний дараа допингийн эсрэг хууль зөрчсөн гэж үзсэн тамирчин буюу бусад этгээдийн талаарх мэдээллийг олон нийтэд зарлаж болно.

14.3.2 Энэхүү хууль нь 13.2.1 болон 13.2.2 зүйлүүдэд заасан эцсийн давж заалдах шийдвэр гарсан буюу 8-р зүйлд заасанчлан тухайн давж заалдах үйлдлийг хүчингүй болгосон эсвэл допингийн эсрэг хууль зөрчсөн үйлдлийг ямар нэгэн байдлаар өөрчлөхгүй үлдээснээс хойш 20 хоногийн дотор үр дүнгийн менежментийн хариуцлага хүлээсэн допингийн эсрэг байгууллага допингийн асуудалтай холбоотой спорт, зөрчсөн дүрэм, зөрчил гаргасан тамирчин буюу бусад этгээдийн нэр ашигласан хориотой бодис буюу арга, оногдуулсан торгууль зэрэг мэдээллийг олон нийтэд зарлах ёстой. Энэхүү допингийн эсрэг байгууллага нь давж заалдах шатны эцсийн шийдвэр гарсанаас хойш 20 хоногийн дотор дээр дурьдсан мэдээллүүд болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн талаар бас олон нийтэд зарлах ёстой.

14.3.3 Гомдол гаргах буюу давж заалдсаны дараа тамирчин буюу бусад этгээд допингийн эсрэг хууль зөрчөөгүй гэж үзвэл тухайн тамирчин болон бусад этгээдээс зөвшөөрөл авсаны үндсэн дээр тухайн шийдвэрийн талаар олон нийтэд мэдээлж болно. Үр дүнгийн менежментийн хариуцлага хүлээсэн допингийн эсрэг байгууллага нь ийм зөвшөөрөл авах шаардлагатай арга хэмжээг авах бөгөөд хэрэв тухайн шийдвэрийг авч чадсан тохиолдолд тамирчин буюу бусад этгээдээс

зөвшөөрсөн хэлбэрээр шийдвэрийг бүхлээр нь буюу товчилсон хэлбэрээр олон нийтэд мэдээлнэ.

14.3.4 Ийм мэдээлэл гаргахын тулд допингийн эсрэг байгууллагын веб сайт дээр шаардлагатай мэдээллийг оруулан нэг сараас дээш хугацаагаар буюу эрх хасуулсан хугацаагаар тухайн мэдээллийг байршуулна.

14.3.5 Тамирчин бусад этгээд эсвэл тэдний албан ёсны төлөөлөгчид олон нийтэд тайлбар өгч мэдээлэл гаргаснаас бусад тохиолдолд допингийн эсрэг байгууллага буюу ДДЭА-гийн магадлан итгэмжлэгдсэн лаборатори эсвэл тэдгээрийн ажилтнууд нь хэргийн талаарх баримтуудыг олон нийтэд тарааж болохгүй.

14.3.6 Энэхүү хуулийн 14.3.2-т заасанчлан допингийн эсрэг хууль зөрчсөн тамирчин буюу бусад этгээд нь насанд хүрээгүй хүүхэд байвал энэхүү хэргийн талаар заавал олон нийтэд мэдээлэх албагүй. Насанд хүрээгүй хүүхэдтэй холбоотой хэргийн талаар олон нийтэд мэдээлэх үйлдэл нь тухайн хэргийн баримт нөхцөл байдлаас хамааран ялгавартай байна.

#### 14.4 Статистик тоо баримт

Допингийн эсрэг байгууллага нь жилдээ дор хаяж нэг удаа өөрсдийн допингийн хяналтын үйл ажиллагааны талаар статистик тоо баримтыг олон нийтэд зориулан хэвлэж нэг хувийг ДДЭА-д хүргүүлнэ. Допингийн эсрэг байгууллагууд нь шалгасан тамирчны нэр болон шалгалт хийсэн огноог заасан мэдээллийг хэвлүүлнэ. ДДЭА нь жилдээ нэг удаа допингийн эсрэг байгууллага болон лабораториудаас авсан мэдээллүүдийг нэгтгэн тайлан гаргана.

**14.5 Допингийн хяналтын мэдээллийн клирингийн газар ДДЭА нь допингийн хяналт шалгалтын өгөгдөл болон шинжилгээний хариуг ялангуяа үндэсний болон олон улсын хэмжээний тамирчидын биологийн өгөгдөл, тамирчидын мэдээлэл тэр дундаа бүртгэлтэй шинжилгээний сан зэргийг хадгалах төв клирингийн газрын үргийг гүйцэтгэнэ.**

Шинжилгээний хуваарь төлөвлөлтийг сайжруулах, төрөл

бүрийн допингийн байгууллагуудын шаардлагагүй давхар шинжилгээнээс зайлсхийх зорилгоор сэргээшийн байгууллага бүр тамирчдын тэмцээний үеэр болон тэмцээнээс гадуур явуулсан шинжилгээний хариуг ДДЭА-гаас баталсан ADAMS болон бусад системээр дамжуулан ДДЭА-гийн клирингийн газарт шинжилгээг авч дуусангут хүргүүлнэ. Энэхүү мэдээллийг холбогдох дүрмийн дагуу шаардлагатай үед тамирчин тамирчины допингийн эсрэг үндэсний байгууллага, олон улсын холбоо болон тамирчиныг шалгах эрх мэдэл бүхий бусад допингийн эсрэг байгууллагуудад харах боломжтой байлгана.

Допингийн хяналтын тестийн өгөгдөл болон үр дүнгийн менежментийн шийдвэрийн клирингийн газар болгон ашиглах зорилгоор ДДЭА-гаас өгөгдлийн нууцлалын зарчмыг багтаасан ADAMS хэмээх өгөгдлийн менежментийн цэсийг боловсруулсан. ДДЭА нь өгөгдлийн нууцлалыг хадгалах дүрэм болон хэм хэмжээ нь ашиглаж байгаа ДДЭА болон бусад байгууллагуудад тогтмол байх зорилгоор ADAMS-ыг боловсруулсан. Тамирчин, тамирчныг дэмжих этгээд болон допингийн эсрэг үйл ажиллагаанд оролцсон бусад этгээдүүдийн талаарх хувийн нууцлалын мэдээ нь ДДЭА-д хүртээмжтэй байх зорилгоор Канадын нууцлалын журмын дагуу маш нууцлалын зэрэгт байж хувийн нууц болон хувь хүний мэдээллийг хамгаалах олон улсын стандартын дагуу хийгдсэн.

#### 14.6. Өгөгдлийн нууцлал

Допингийн эсрэг байгууллагууд нь энэхүү хууль, олон улсын стандартууд (ялангуяа Хувийн Нууц болон Хувийн Мэдээлэл хадгалах талаарх Олон Улсын Стандартууд) болон холбогдох хууль тогтоомжийн дагуу допингийн эсрэг үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай болон холбогдох тамирчин болон бусад этгээдтэй холбоотой хувийн мэдээллийг хадгалж, цуглуулж, боловсруулж, бас задалж болно.

*14.6 зүйлд хийх тайлбар: Энэхүү хуулийн 22.2 зүйлд “Допингийн эсрэг байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл хуваалцах болон хуульд заасны дагуу допингийн эсрэг байгууллагуудын хооронд мэдээлэл хуваалцах талаар хууль тогтоомжс, бодлого, захиргааны туршилагатай байна” гэж заасан байдгийг анхаарах хэрэгтэй.*

## **15-р зүйл: Өргөдөл гаргах ба шийдвэрийг хүлээн зөвшөөрөх**

15.1. Энэхүү хуулийн 13-р зүйлд заасан давж заалдах эрхийн дагуу энэхүү хуульд хамарагдах гарын үсэг зурсан талуудын шалгах, хэрэг хэлэлцэх болон бусад эцсийн шийдвэр гаргах болон гарын үсэг зурсан талын эрх мэдэлд хамаарах зүйлс нь дэлхий дахинд хамаарах ба бүх талууд хүлээн зөвшөөрч дагаж мөрдөнө.

*15.1 зүйлд хийх тайлбар: Допингийн эсрэг бусад байгууллагын гаргасан эмчилгээний зорилгоор ашиглах шийдвэрийг хүлээн зөвшөөрөх асуудлыг энэхүү хуулийн 4.4. зүйл болон эмчилгээний зорилгоор ашиглах олон улсын стандарттаар тодорхойлно.*

**15.2. Гарын үсэг зурсан талууд бусад байгууллагуудын хууль нь энэхүү хуультай нийцэж байгаа бол энэхүү хуулийг хүлээн зөвшөөрөөгүй аливаа байгууллагаас авсан арга хэмжээг хүлээн зөвшөөрнө.**

*15.2 зүйлд хийх тайлбар: Хуульд нийцээгүй аль нэг байгууллагын дүрэм нь зарим талаараа хуульд нийцсэн, зарим талаараа хуульд нийцээгүй бол гарын үсэг зурсан талууд нь тухайн шийдвэрийг хуулийн зарчмуудтай зохицуулах бүх боломжит арга хэмжээг авна. Жишээ нь: хэрэв явц нь хуульд нийцэж байгаа бол гарын үсэг зураагүй тал нь аль нэг тамирчинг өөрийн биед хориотой бодис байлган допингийн эсрэг хууль зөрчсөн гэж үзсэн ч эрх хасах хугацаа нь хуульд зааснаас богино байвал бүх гарын үсэг зурсан талууд допингийн эсрэг хууль зөрчсөн хэмээн үзэж тамирчныг допингийн эсрэг үндэсний байгууллагаас 8-р зүйлд заасанчлан хэлэлцүүлгийг явуулж энэхүү хуульд заасан эрх хасах хугацааг оногдуулах эсэхийг шийднэ.*

## **16-р зүйл: Спортод өрсөлдөж байгаа амьтадын допингийн хяналт**

16.1. Тэмцээндээ амьтан оруулдаг спортын төрлүүдэд тухайн олон улсын холбоо нь тухайн спортомд өрсөлддөг амьтдад допингийн дүрэм тогтоон хэрэгжүүлнэ. Эдгээр допингийн эсрэг хуулиудад хориотой бодисын жагсаалт, холбогдох тест болон

дээжний шинжилгээ хийх баталгаат лабораториудын жагсаалтыг тус тус багтаана.

16.2. Допингийн эсрэг хууль зөрчсөн, үр дүнгийн менежмент, шударга сонсгол, үр дүн, спортод оролцсон амьтадтай холбоотой давж заалдах өргөдөл зэргийн талаар тухайн спорттой холбоотой олон улсын холбоо нь энэхүү хуулийн 1, 2, 3, 9, 10, 11, 13 болон 17 зүйлүүдэд заасны дагуу дүрэм боловсруулан хэрэгжүүлнэ.

## **17-р зүйл: Хязгаарлалт хийх дүрэм**

Энэхүү хуулийн 7-р зүйлд заасанчлан тамирчин буюу бусад этгээдэд допингийн эсрэг хууль зөрчсөн талаар мэдэгдэл хүргүүлэгүй буюу тухайн хууль зөрчсөн үйл явдал болсоноос хойш 10 жилийн хугацаанд тухайн мэдэгдлийн хүргүүлэх хангалттай оролдлого хийсэн хүргүүлж чадаагүй тохиолдолд тухайн этгээдийн эсрэг допингийн эсрэг хууль зөрчсөн талаар хэрэг үүсгэж болохгүй.

## **ХОЁРДУГААР ХЭСЭГ: БОЛОВСРОЛ БА СУДАЛГАА**

### **18-р зүйл: Боловсрол**

#### **18.1. Үндсэн зарчим ба гол зорилго**

Допингоос ангид спортын талаар мэдээлэл боловсрол олгох хөтөлбөрийг үндсэн зарчим нь энэхүү хуулийн оршил хэсэгт өгүүлснээр спортын уур амьсгалыг ямар нэгэн допингийн халдвараас хамгаалах, хадгалан үлдэх явдал юм. Ийм хөтөлбөрийн гол зорилго нь допингоос урьдчилан сэргийлэх явдал юм. Энэхүү хөтөлбөр нь тамирчинг хориотой бодис болон хориотой аргыг санаатай буюу санамсаргүйгээр хэрэглэхээс урьдчилан сэргийлэх зорилготой.

Мэдээллийн хөтөлбөр нь энэхүү хуулийн 18.2-д заасанчлан тамирчинд үндсэн мэдээллийг өгөх зорилготой. Боловсролын хөтөлбөр нь урьдчилан сэргийлэх зорилготой. Урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүд нь тамирчин буюу тамирчныг дэмжих этгээдэд суурилан чиглэсэн сургуулиудын хичээлийн хөтөлбөрөөр дамжуулан бага насын хүүхдүүдэд чиглэсэн тодорхой үнэт зүйлс байна.

Бүх гарын үсэг зурсан талууд өөрсдийн арга үүрэг хариуцлагын хүрээнд бусад гарын үсэг зурсан талуудтай хамтран допинггүй спортыг хэрэгжүүлэх мэдээлэл боловсролын болон урьдчилан сэргийлэх ажлуудыг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, болон удирдан зохицуулна.

#### **18.2. Хөтөлбөр үйл ажиллагаа**

Эдгээр хөтөлбөрүүд нь тамирчин болон бусад этгээдүүдэд дараах болон бусад асуудлаар шинэчилсэн үнэн зөв мэдээлэл өгнө. Үүнд:

- Хориотой жагсаалтад байгаа бодис болон аргууд
- Допингийн эсрэг хуулийн зөрчил
- Допингийн үр дагавар, торгууль, шийтгэл, эрүүл мэндийн болон нийгмийн үр дагавар,
- Допингийн хяналтын дүрэм
- Тамирчид болон тамирчныг дэмжих этгээдийн эрх ҮҮРГҮҮД

- Эмчилгээний зорилгоор ашиглах бодисууд
- Хүнсний нэмэлт бодисуудын эрсдлийн удирдлага
- Спортын уур амьсгалд допингийн учруулах хохирол
- Холбогдох нэмэлт шаардлагууд

Эдгээр хөтөлбөрүүд нь допингоос хамгаалагдсан хүчтэй орчныг бий болгох болон тамирчид, бусад этгээдийн хийх сонголтод урт хугацааны эерэг нөлөө үзүүлэх спортын уур амьсгалыг бий болгоно.

Урьдчилан сэргийлэх хөтөлбөр нь залуу хүмүүсийн хөгжил, нас биений онцлогт тохирсон, сургууль болон спортын хөтөлбөрт зориулсан, эцэг эхчүүд, насанд хүрсэн тамирчдад зориулсан, спортын ажилтнууд, шүүгч нар, эмнэлгийн ажилтнууд, хэвлэл мэдээллийнхэнд зориулсан гэх мэтийн хэлбэртэй байна.

Тамирчныг дэмжих этгээд нь энэхүү хуулийн дагуу боловсруулан баталсан допингийн эсрэг бодлого хуулийн талаар тамирчдад зөвлөх, боловсрол олгох зорилготой. Гарын үсэг зурсан бүх талууд нь тамирчин болон тамирчныг дэмжих этгээдүүдийг допингоос хамгаалагдсан спортын талаарх боловсролын хөтөлбөрт идэвхитэй оролцоход дэмжих, сурталчлах болно.

*18.2 зүйлд хийх тайлбар: Допингийн эсрэг мэдээлэл болон боловсролын хөтөлбөрүүд нь үндэсний болон олон улсын түвшний тамирчдаар хязгаарлагдахгүй, харин ч гарын үсэг зурсан талууд, засгийн газар болон журмыг хүлээн зөвшөөрсөн спортын байгууллагуудын удирдлага дор спортын үйл ажиллагаанд оролцдог залуучууд болон бусад бүх этгээдүүдийг багтаах ёстой. (Тамирчин гэсэн тодорхойлолтыг үз) Эдгээр хөтөлбөрүүд нь бас тамирчныг дэмжих этгээдүүдийг бас оролцуулах нь зүйтэй. Эдгээр зарчмуудыг боловсрол сургалтын талаарх ЮНЕСКО-гийн конвенцэд нийцүүлсэн.*

### 18.3. Үйл ажиллагаа явуулах мэргэжлийн журам

Гарын үсэг зурсан бүх талууд өөр хоорондоо болон улс орнуудын засгийн газартай хамтран ажиллаж спорттой холбоотой ёс зүйн журам, допингийн эсрэг хуультай холбоотой санкц, ёс зүйн дүрэм журам зэргийг боловсруулан хэрэгжүүлэх мэргэжлийн байгууллагатай байлгахад шаардлагатай туслалцааг үзүүлэн хамтран ажиллана.

## 18.4. Зохицуулалт болон хамтын ажиллагаа

ДДЭА нь өөрийн болон допингийн эсрэг байгууллагуудаас боловсруулсан мэдээлэл болон боловсролын эх сурвалжууд хөтөлбөрүүдийн төв, клирингийн газрын үүргийг гүйцэтгэнэ. Гарын үсэг зурсан бүх талууд болон тамирчид бусад этгээдүүд өөр хоорондоо болон улс орнуудын засгийн газартай допингийн эсрэг мэдээлэл боловсруулах хөтөлбөрийн чиглэлээр хамтран ажиллаж туршлага солилцох, спортын допингоос урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэх баталгааг хангана.

## 19-р зүйл: Судалгаа

### 19.1 Допингийн судалгааны зорилго, зорилт

Допингийн судалгаа нь допингийн хяналтын чиглэлээр үр дүнтэй хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, допингоос хамгаалагдсан спортын талаар боловсрол мэдээлэл олгоход хувь нэмэр оруулна.

Гарын үсэг зурсан бүх талууд нь өөр хоорондоо болон улс орнуудын засгийн газартай хамтран эдгээр судалгааны ажлыг дэмжих хөгжүүлэх, эдгээр судалгааны ажлын үр дүнг энэхүү журмын зарчмын дагуу зорилгоор хэрэгжүүлэх чиглэлээр ашиглах бүх шаардлагатай арга хэмжээнүүдийг авна.

### 19.2 Судалгааны төрлүүд

Анагаах ухаан анализ болон сэтгэл зүйн судалгаанаас гадна допингийн судалгаанд социологийн зан төлөвийн, хууль зүйн болон ёс зүйн судалгаанууд багтаж болно. Тоног төхөөрөмжийн талаарх судалгаа болон шинжлэх ухаанд үндэслэлсэн физиологийн үр ашгийн судалгаа болон сэтгэл зүйн сургалтын хөтөлбөрүүд нь энэхүү хуулийн зарчмуудад үндэслэн хүний цогц байдал шинжлэх ухаанд суурилсан яаралтай бодис, аргуудыг ашиглах талаарх судалгаа шинжилгээний ажлуудад үндэслэгдэн явах ёстой.

### 19.3 Судалгаа болон шинжилгээний хариуг зохицуулах

ДДЭА-гаар дамжуулан допингийн эсрэг судалгааг зохицуулах нь маш чухал, оюуны өмчийн хуулийн дагуу допингийн судалгааны хариуг ДДЭА-д хүргүүлэх боломжтой тохиолдолд гарын үсэг зурсан талууд болон тамирчид хувьцаа эзэмшигчдэд хүргүүлнэ.

#### 19.4 Судалгааны практик

Допингийн судалгаа нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө.

#### 19.5 Хориотой бодис болон хориотой аргуудыг хэрэглэх талаар судлах

Судалгааны ажил нь тамирчдад хориотой бодис болон хориотой аргуудыг хэрэглэхийг зааварчлахаас зайлсхийх ёстой.

#### 19.6 Судалгааны үр дүнг буруугаар ашиглах

Допингийн эсрэг судалгааны үр дүн буруугаар ашиглах допингийн зорилгоор хэрэглэхээс зайлсхийх бүх шаардлагатай урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах ёстой.

## **ГУРАВДУГААР ХЭСЭГ: ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА**

Гарын үсэг зурсан бүх талууд энэхүү хуультай холбогдуулан спорт дахь допингтэй тэнцэх ажлыг амжилттай болгох үүднээс хамтран ажиллана.

*Тайлбар: Гарын үсэг зурсан талууд, тамирчид болон бусад этгээдүүд өөрсдийн үүрэг хариуцлагаас гадна энэхүү хуулийн холбогдох зүйлүүдэд заасан үргийг хүлээнэ.*

### **20-р зүйл: Гарын үсэг зурсан талуудын нэмэлт үүрэг хариуцлага**

#### **20.1 Олон Улсын Олимпийн Хорооны үүрэг хариуцлага**

20.1.1 Энэхүү хуульд нийцсэн олимпийн тоглолтын допингийн эсрэг бодлого болон хуулиудыг хэрэгжүүлэх

20.1.2 Олон улсын олимпийн хороогоор хүлээн зөвшөөрөгдөх нөхцөл болгон олон улсын холбоодыг олимпийн хөдөлгөөнд зохих журмын дагуу оролцохыг шаардах

20.1.3 Энэхүү хуулинд нийцээгүй олимпийн спортын аль нэг байгууллагын үйл ажиллагааны санхүүжилтиг хэсэгчлэн буюу бүхлээр нь хүчингүй болгох

20.1.4 Энэхүү хуулийн 23.5 зүйлд заасанчлан энэхүү хуулийг зөрчсөн аливаа үйлдлийг зогсоох холбогдох арга хэмжээг авах

20.1.5 Бие даасан ажиглалтын хөтөлбөрийг зөвшөөрөн хэрэгжүүлэх

20.1.6 Олимпийн тоглолтонд шүүгч, дасгалжуулагч, менежер, багийн ажилтан, албан хаагч, эмнэлэгийн ажилтан зэрэг үүргээр оролцож байгаа бүх тамирчин болон тамирчныг дэмжих этгээдүүдээс энэхүү хуулийн дагуу допингийн эсрэг хуулийг тэмцээнд оролцох үндсэн нөхцөл болгон хүлээн зөвшөөрөх, дагаж мөрдөхийг шаардах

20.1.7 Допингийн хэрэг бүрт оролцсон байж болох тамирчныг дэмжих этгээд болон бусад этгээдүүдэд

холбогдох хууль журмын дагуу допингийн хуулийг ноцтой зөрчсөн эсэхийг нарийвчлан шалгах

20.1.8 Юнескогийн конвенцыг хүлээн зөвшөөрсөн, Үндэсний Олимпийн Хороо, Үндэсний Паралимпын Хороо, Допингийн Эсрэг Үндэсний Байгууллага нь энэхүү хуульд нийцсэн үйл ажиллагаа явуулж байгаа улс орнуудыг олимпийн тоглолт зохион байгуулах тендерт хүлээн авах

20.1.9 Допингийн эсрэг боловсрол олгох

20.1.10 Холбогдох дотоодын байгууллага агентлаг, допингийн эсрэг бусад байгууллагуудтай хамтран ажиллах

## 20.2 Олон Улсын Паралимпийн Хорооны үүрэг хариуцлага

20.2.1 Энэхүү хуулийн дагуу Паралимпийн тоглолтуудын допингийн эсрэг бодлого хуулиудыг батлан хэрэгжүүлэх

20.2.2 Олон улсын Паралимпын хороонд хүлээн зөвшөөрөгдөхийн тулд Паралимпын хөдөлгөөний хүрээнд энэхүү хуулийг дагаж мөрдөхийг Үндэсний Паралимпын Хорооноос шаардах

20.2.3 Энэхүү хуулийг дагаж мөрдөөгүй бүх спортын байгууллагуудын Паралимпийн тоглолтын зардлыг олгохгүй байх

20.2.4 Энэхүү хуулийн 23.5 зүйлд заасанчлан хуулийг дагаж мөрдөөгүй аливаа үйлдлийг таслан зогсоох холбогдох арга хэмжээг авах

20.2.5 Бие даасан ажиглагчийн хөтөлбөрийг зөвшөөрөн хэрэгжүүлэх

20.2.6 Паралимпийн тоглолтод дасгалжуулагч, шүүгч, менежер, багийн ажилтан, албан хаагч, эрүүл мэндийн болон Пара эрүүл мэндийн ажилтнаар оролцож байгаа бүх тамирчид болон тамирчдыг дэмжих этгээдүүдээс энэхүү хуулийн дагуу допингийн эсрэг хуулийг тэмцээнд оролцох үндсэн нөхцөл болгон дагаж мөрдөхийг шаардах

20.2.7 Допингийн тохиолдол бүрт тамирчиныг дэмжих

этгээд болон бусад этгээдүүд оролцсон эсэхийг тогтоох зорилгоор явуулж байгаа судалгаа болон холбогдох хууль журмын дагуу допингийн хуулийг ноцтой зөрчсөн тохиолдол бүрийг нарийвчлан шалгах

20.2.8 Допингийн эсрэг боловсрол олгох

20.2.9 Холбогдох дотоодын байгууллага агентлаг дипингийн эсрэг бусад байгууллагуудтай хамтран ажиллах

## 20.3 Олон улсын холбоодын үүрэг хариуцлага

20.3.1 Энэхүү хуулийн дагуу дипингийн эсрэг бодлого хуулиудыг батлан хэрэгжүүлэх

20.3.2 Гишүүнчлэлээр хүлээн зөвшөөрөгдөхийн тулд өөрийн үндсэн хорооны бодлого журам хөтөлбөрүүд болон бусад гишүүд нь энэхүү хуулийг дагаж мөрдөхийг үндэсний хорооноос шаардах

20.3.3 Тоглолтод дасгалжуулагч, шүүгч, менежер, багийн ажилтан, албан хаагч, эрүүл мэндийн болон Пара эрүүл мэндийн ажилтнаар оролцож байгаа бүх тамирчид болон тамирчдыг дэмжих этгээдүүдээс энэхүү хуулийн дагуу дипингийн эсрэг хуулийг тэмцээнд оролцох үндсэн нөхцөл болгон дагаж мөрдөхийг шаардах

20.3.4 Олон улсын холбоо болон түүний харьяа үндэсний холбоодын байнгын гишүүн бус аль нэг тамирчиныг дээж өгүүлэх, олон улсын холбоо болон томоохон үйл ажиллагаа зохион байгуулагчдаас тэмцээнд оролцох эрхийн нөхцөл болсон Олон Улсын Холбооны Бүртгэлтэй Шинжилгээний Санд хувийн мэдээллээ үнэн зөв оруулахыг тамирчдаас шаардах

*20.3.4 зүйлд хийх тайлбар: Энэхүү заалтад мэргэжлийн лигийн тамирчид хамаарна.*

20.3.5 Тоглолтод дасгалжуулагч, шүүгч, менежер, багийн ажилтан, албан хаагч, эрүүл мэндийн болон Пара эрүүл мэндийн ажилтнаар оролцож байгаа бүх тамирчид болон тамирчдыг дэмжих этгээдүүдээс энэхүү хуулийн дагуу дипингийн эсрэг хуулийг тэмцээнд оролцох үндсэн

нөхцөл болгон дагаж мөрдөхийг шаардсан дүрэм журмыг боловсруулахыг үндэсний холбоодоос шаардах

20.3.6 Судалгаа явуулах эрх мэдэл бүхий допингийн эсрэг байгууллагаас явуулсан судалгаанд хамтран ажиллаж, допингийн эсрэг үндэсний байгууллага болон олон улсын холбоонд аливаа допингийн эсрэг хууль зөрчсөн үйлдлийг илрүүлэхтэй холбоотой тайлан мэдээллээр хангахыг үндэсний холбоодоос шаардах

20.3.7 Энэхүү хуулийн 23.5 зүйл заасанчлан хуулийг дагаж мөрдөөгүй аливаа үйлдлийг таслан зогсоох холбогдох арга хэмжээг авах

20.3.8 Олон улсын үйл ажиллагаанд бие даасан ажиглагчийн хөтөлбөрийг зөвшөөрөн хэрэгжүүлэх

20.3.9 Энэхүү хуулийг зөрчсөн гишүүн холбоодод үзүүлдэг санхүүжилтийг бүхлээр буюу хэсэгчлэн зогсоох

20.3.10 Допингийн аливаа тохиолдолд тамирчныг дэмжих этгээд буюу бусад этгээд оролцсон эсэх талаар холбогдох хууль журмын хүрээнд судалгаа явуулахад бүх шаардлагатай допингийн эсрэг зөрчлүүдийг илрүүлэх, тамирчныг дэмжих этгээд насанд хүрээгүй буюу тамирчныг дэмжих этгээдийг хамруулсан допингийн эсрэг хууль зөрчсөн хэрэг бүрт тамирчныг дэмжих этгээд оролцсон эсэхийг тогтоох судалгааг автоматаар явуулах

20.3.11 Юнескогийн конвенцыг хүлээн зөвшөөрсөн, Үндэсний Олимпийн Хороо, Үндэсний Паралимпийн Хороо, Допингийн Эсрэг Үндэсний Байгууллага нь энэхүү хуульд нийцсэн үйл ажиллагаа явуулж байгаа улс орнуудыг дэлхийн аваргын тэмцээнд оролцох эрхийг олгох

20.3.12 Холбогдох Допингийн Эсрэг Үндэсний Байгууллагын зохицуулалтын дагуу допингийн эсрэг боловсрол олгохыг үндэсний зөвлөл, үндэсний холбоодоос шаардах допингийн эсрэг байгууллагуудын допингийн эсрэг бодлогыг дэмжин ажиллах

20.3.13 Холбогдох үндэсний байгууллагууд агентлагууд, допингийн эсрэг бусад байгуулагуудтай хамтран ажиллах

20.3.14 Энэхүү хуулийн 20.7.10-т заасны дагуу ДДЭА-гаас явуулсан судалгаатай холбоотойгоор холбогдох үндэсний байгууллага агентлагуудтай хамтран ажиллах

20.3.15 Олон улсын холбооны болон үндэсний холбооны эрх мэдлийн хүрээнд тамирчдад дэмжлэг үзүүлэх ажлыг зөвтгөхгүйгээр хориотой бодис болон аргыг ашиглаж байгаа тамирчныг дэмжих этгээдийг олон улсын холбоо болон үндэсний холбооны эрх мэдлийн хүрээнд тамирчдад тусlamж үзүүлэхээс сэргийлэх сахилгын журамтай байх эсвэл ийм журамтай болохыг үндэсний холбоодоос шаардах

## 20.4 Үндэсний Олимпийн хороо болон Үндэсний Паралимпийн хороодын үүрэг хариуцлага

20.4.1 Өөрсдийн допингийн бодлого журмыг энэхүү хуультай нийцүүлэх

20.4.2 Үндэсний холбоодын допингийн эсрэг бодлого журам нь энэхүү хуулийн холбогдох заалттай нийцэж байх нь гишүүнээр элсэх болон хүлээн зөвшөөрөгдөх үндсэн нөхцөл болно гэдгийг ойлгуулан дагаж мөрдөхийг шаардах

20.4.3 Допингийн эсрэг үндэсний байгууллагын өөрийн улс орны хэмжээнд бие даасан байдлыг хүндэтгэн үйл ажиллагаа болон шийдвэр гаргалтанд нь нөлөөлөхгүй байх.

20.4.4 Үндэсний холбоодыг допингийн эсрэг хууль зөрчигдсөнтэй холбоотой аливаа мэдээллийг допингийн эсрэг үндэсний байгууллага болон олон улсын холбоонд мэдэгдэж шинжилгээ явуулах эрх мэдэл бүхий допингийн эсрэг байгууллагаас явуулах аливаа шинжилгээ судалгаанд шаардлагатай тусlamж дэмжлэг үзүүлэх

20.4.5 Олимпийн тоглолт болон Паралимпийн тоглолтуудад оролцохоор жагсаалтанд орсон тамирчдад дээрх тоглолтонд оролцох нөхцөл болгон үндэсний

холбооны гишүүн бус тамирчдыг дээж өгөх Олон Улсын Шинжилгээний стандартанд шаардсаны дагуу дээж өгөхийг шаардах

20.4.6 Допингийн эсрэг үндэсний байгууллагатай хамтран ажиллаж допингийн эсрэг үндэсний байгууллага байгуулахад өөрийн засгийн газартай хамтран ажиллах хэрэв ийм байгууллага аль хэдийн байгаа бол Үндэсний Олимпийн Хороо болон бусад томилогдсон этгээдүүд нь өөрсдийн үүргийг биелүүлнэ.

20.4.6.1 Бүс нутгийн допингийн эсрэг байгууллагын гишүүн улс орнуудын хувьд Үндэсний Олимпийн Хороо нь өөрийн засгийн газартай хамтран холбогдох бүс нутгийн допингийн эсрэг байгууллагуудад идэвхитэй туслалцаа үзүүлэх чиглэлээр хамтран ажиллана.

20.4.7 Үндэсний холбоо бүр нь аливаа тэмцээн уралдаанд шүүгч, дасгалжуулагч, менежер, багийн гишүүн, ажилтан, эмч болон Пара эмнэлэгийн ажилтны үүргийг гүйцэтгэж байгаа тамирчныг дэмжих этгээдүүдээс допингийн эсрэг хуулийг баримтлахыг шаардаж энэхүү хуулийн дагуу допингийн эсрэг байгууллагын үр дүнгийн менежментийн эрх болон допингийн эсрэг хуулийг дагаж мөрдөх нь тухайн тэмцээнд оролцох үндсэн нөхцөл болно гэдгийг ойлгуулах

20.4.8 Эрх хасуулсан хугацаанд допингийн эсрэг хууль зөрчсөн аливаа тамирчин буюу тамирчныг дэмжих этгээдийн санхүүжилтийг бүхлээр буюу хэсэгчлэн хүчингүй болгох

20.4.9 Хуулийг мөрдөөгүй гэж үндэсний холбооноос үзсэн аливаа гишүүний санхүүжилтыг хэсгээр нь буюу бүтнээр нь хүчингүй болгох

20.4.10 Допингийн аливаа тохиолдолд тамирчныг дэмжих этгээд буюу бусад хүмүүс оролцсон эсэхийг тогтоох ажлын хүрээнд допингийн эсрэг хуулийг ноцтойгоор зөрчсөнийг олж илрүүлэх

20.4.11 Допингийн эсрэг боловсрол олгох ажлыг дэмжин үндэсний холбоодыг холбогдох Допингийн Эсрэг Үндэсний Байгууллагын зохицуулалтын дагуу допингийн талаар боловсрол олгох үйл ажиллагаа явуулахыг шаардах

20.4.12 Холбогдох үндэсний байгууллага агентлагууд болон допингийн эсрэг бусад байгууллагуудтай хамtran ажиллах

20.4.13 Олон улсын холбооны болон үндэсний холбооны эрх мэдлийн хүрээнд тамирчдад дэмжлэг үзүүлэх ажлыг зөвтгөхгүйгээр хориотой бодис болон аргыг ашиглаж байгаа тамирчныг дэмжих этгээдийг олон улсын холбоо болон үндэсний холбооны эрх мэдлийн хүрээнд тамирчдад тусламж үзүүлэхээс сэргийлэх сахилгын журамтай байх эсвэл ийм журамтай болохыг үндэсний холбоодоос шаардах

## 20.5. Допингийн Эсрэг Үндэсний Байгууллагын үүрэг хариуцлага

20.5.1. Өөрсдийн үйл ажиллагаа болон шийдвэрийн талаар бие даасан байх

20.5.2 Энэхүү хуульд нийцсэн допингийн эсрэг бодлого журам боловсруулан хэрэгжүүлэх

20.5.3 Бусад үндэсний холбогдох байгууллага агентлаг болон бусад допингийн эсрэг байгууллагуудтай хамtran ажиллах

20.5.4 Допингийн эсрэг үндэсний байгууллага хоорондын харилцан шинжилгээ хийх ажлыг дэмжих

20.5.5 Допингийн эсрэг судалгаа хийх

20.5.6 допингийн эсрэг хууль зөрчсөн тамирчин буюу тамирчин дэмжих этгээдийн эрх хасуулсан хугацаан дахь санхүүжилтийг бүхлээр нь буюу хэсэгчлэн хүчингүй болгох

20.5.7 Допингийн аливаа тохиолдолд тамирчиныг дэмжих этгээд буюу бусад этгээд оролцсон эсэх талаар холбогдох хууль журмын хүрээнд судалгаа явуулахад бүх

шаардлагатай допингийн эсрэг зөрчлүүдийг илрүүлэх, холбогдох шийтгэлийг оногдуулах

#### 20.5.8 Допингийн эсрэг боловсрол олгох

20.5.9 Допингийн аливаа тохиолдолд тамирчныг дэмжих этгээд буюу бусад этгээд оролцсон эсэх талаар холбогдох хууль журмын хүрээнд судалгаа явуулахад бүх шаардлагатай допингийн эсрэг зөрчлүүдийг илрүүлэх, тамирчныг дэмжих этгээд насанд хүрээгүй буюу тамирчныг дэмжих этгээдийг хамруулсан допингийн эсрэг хууль зөрчсөн хэрэг бүрт тамирчныг дэмжих этгээд оролцсон эсэхийг тогтоох судалгааг автоматаар явуулах

20.5.10 Энэхүү хуулийн 20.7.10-т заасны дагуу ДДЭА-гаас явуулсан судалгаатай холбоотойгоор ДДЭА-тай бүрэн хамтран ажиллах

*20.5 зүйлд хийх тайлбар: Зарим жижиг орнуудад энэхүү зүйлд заасан зарим үүргийг допингийн эсрэг үндэсний байгууллага нь бүс нутгийн допингийн эсрэг байгууллагын өмнө төлөөлөн хулээдэг.*

20.6 Томоохон үйл ажиллагаа зохион байгуулагчдын хүлээх үүрэг хариуцлага

20.6.1 Энэхүү хуулийн дагуу өөрсдийн үйл ажиллагаанд холбогдох допингийн эсрэг бодлого хуулийг боловсруулан хэрэгжүүлэх

20.6.2 Энэхүү хуулийн 23.5 зүйл заасанчлан хуулийг дагаж мөрдөөгүй аливаа үйлдлийг таслан зогсоох, холбогдох арга хэмжээг авах

20.6.3 Бие даасан ажиглагчийн хөтөлбөрийг зөвшөөрөн хэрэгжүүлэх

20.6.4 Үйл ажиллагаанд дасгалжуулагч, шүүгч, менежер, багийн ажилтан, албан хаагч, эрүүл мэндийн болон Пара эрүүл мэндийн ажилтнаар оролцож байгаа бүх тамирчиid болон тамирчдыг дэмжих этгээдүүдээс энэхүү хуулийн дагуу допингийн хууль журмыг тэмцээнд оролцох үндсэн нөхцөл болгон дагаж мөрдөхийг шаардах

20.6.5 Допингийн тохиолдол бүрт тамирчныг дэмжих этгээд болон бусад этгээдүүд оролцсон эсэхийг тогтоох зорилгоор явуулж байгаа судалгаа болон холбогдох хууль журмын дагуу допингийн хуулийг ноцтой зөрчсөн тохиолдол бүрийг нарийвчлан шалгах

20.6.6 Юнескогийн конвенцыг хүлээн зөвшөөрсөн, Үндэсний Олимпийн Хороо, Үндэсний Параолимпийн Хороо, Допингийн Эсрэг Үндэсний Байгууллага нь энэхүү хуульд нийцсэн үйл ажиллагаа явуулж байгаа улс орнуудыг энэхүү тэмцээнд оролцох эрхийг олгох

20.6.7 Допингийн эсрэг боловсрол олгох

20.6.8 Холбогдох дотоодын байгууллага агентлаг дипингийн эсрэг бусад байгууллагуудтай хамтран ажиллах

## 20.7 ДДЭА-гийн хүлээх үүрэг хариуцлага

20.7.1 Хуульд нийцсэн бодлого журмыг боловсруулан хэрэгжүүлэх

20.7.2 Гарын үсэг зурсан талууд энэхүү хуулийг дагаж мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих

20.7.3 Энэхүү хуулийн хэрэгжилттэй холбоотой олон улсын стандарт батлах

20.7.4 Дээжийн шалгалт хийх лабораториудыг магадлан итгэмжлэх, дахин магадлах буюу дээжийн шинжилгээ явуулах бусад байгууллагуудыг батлах

20.7.5 Шилдэг үйл ажиллагааны загварчлал зааварчилгааг боловсруулан хэрэгжүүлэх

20.7.6 Допингийн эсрэг судалгааг санаачлах, явуулах, хянах, санхүүжүүлэх, зохицуулах болон допингийн талаар боловсрол олгох

20.7.7 Бие даасан ажиглагчийн хөтөлбөр болон бусад тэмцээний зөвлөх хөтөлбөрүүдийг үр дүнтэй боловсруулан хэрэгжүүлэх

20.7.8 ДДЭА-гийн ерөнхий захирлын зааварчилгаа

болон өвөрмөц нөхцөл байдалд өөрийн санаачлагаар буюу допингийн эсрэг бусад байгууллагуудын хүсэлтээр допингийн хяналт хийх, холбогдох үндэсний болон олон улсын байгууллага агентлагуудтай хамтран ажиллаж судалгаа шинжилгээний ажилд тоног төхөөрөмж бусад зүйлсээр туслах

*20.7.8 зүйлд хийх тайлбар: ДДЭА нь шинжилгээ явуулах байгууллага биш боловч холбогдох допингийн байгууллагуудын шинжилгээ асуудалтай байх буюу холбогдох байгууллагуудын анхаарлыг татааж байгаа тохиолдолд өөрийн шинжилгээг явуулах эрхтэй*

20.7.9 Допингийн эсрэг хууль журам зөрчсөн талаар өөрийн шинжилгээ явуулах буюу допингийн үйл ажиллагаанд тусалж болохуйц бусад үйл ажиллагааг санаачлах

## **21-р зүйл: тамирчид болон бусад этгээдүүдийн нэмэлт үүрэг хариуцлага**

### 21.1 Тамирчдын үүрэг хариуцлага

21.1.1 Энэхүү хуулийн дагуу баталсан холбогдох допингийн эсрэг бодлого журмын талаар мэдлэгтэй байж дагаж мөрдөх

21.1.2 Дээж өгөхөд байнга бэлэн байх

*21.1.2 зүйлд хийх тайлбар: Тамирчны хүний эрх болон хувийн нууцтай холбогдуулан зарим хууль ёсны журмаар дээжийг шөнө орой буюу өглөө эрт авахыг заримдаа шаардаж болно. Жишээ нь: энэ цагаар тамирчид маш бага тунгийн хориотой бодис хэрэглэсэн нь өглөө илэрдэггүй тохиолдол бий*

21.1.3 Идэж уусан болон хэрэглэсэн зүйлсийн талаар допингийн хариуцлага хүлээх

21.1.4 Өөрийн хариуцсан эрүүл мэндийн ажилтнуудад хориотой бодис болон хориотой арга хэрэглэхгүй байх талаар үүргээ мэдэгдэж аливаа хэрэглэсэн эмчилгээ нь энэхүү хуулийн дагуу баталсан бодлого журмыг зөрчөөгүй гэдэгт итгэлтэй байж холбогдох хариуцлагыг хүлээх

21.1.5 Аль нэгэн гарын үсэг зураагүй талын шийдвэрээр сүүлийн 10 жилд тамирчин нь допингийн ямар нэгэн дүрэм зөрчсөн талаарх мэдээлэл байгааг өөрийн допингийн эсрэг байгууллага болон олон улсын холбооноос нуухгүй байх

21.1.6 Допингийн эсрэг хууль зөрчсөн үйлдлийг судлах талаар допингийн эсрэг байгууллагуудтай хамтран ажиллах

*21.1.6 зүйлд хийх тайлбар: допингийн эсрэг байгууллагуудтай хамтран ажиллаагүй нь энэхүү хуулийн дагуу допингийн эсрэг хууль зөрчсөнд тооцогдохгүй ч эрх баригчдын журмаар энэ нь сахилгын хариуцлага хүлээлгэх үндэслэл болж болно.*

## 21.2. Тамирчныг дэмжих этгээдийн үүрэг хариуцлага

21.2.1. Энэхүү хуулийн дагуу баталсан холбогдох допингийн эсрэг бодлого хуулийн талаар мэдлэгтэй байж өөрийн дэмжиж байгаа тамирчинд дагаж мөрдүүлэх

21.2.2. Тамирчны шинжилгээний үйл ажиллагаанд хамтран ажиллах

21.2.3. Тамирчинд допингийн эсрэг хуулийг дагаж мөрдөх үнэт зүйлс, зан төлөв бий болгоход нөлөөлөх

21.2.4. Аль нэгэн гарын үсэг зураагүй талын шийдвэрээр сүүлийн 10 жилд тамирчин нь допингийн ямар нэгэн дүрэм зөрчсөн талаарх мэдээлэл байгааг өөрийн допингийн эсрэг байгууллага болон олон улсын холбооноос нуухгүй байх

21.2.5. Допингийн эсрэг хууль зөрчсөн үйлдлийг судлах талаар допингийн эсрэг байгууллагуудтай хамтран ажиллах

*21.2.5 зүйлд хийх тайлбар: допингийн эсрэг байгууллагуудтай хамтран ажиллаагүй нь энэхүү хуулийн дагуу допингийн эсрэг хууль зөрчсөнд тооцогдохгүй ч эрх баригчдын журмаар энэ нь сахилгын хариуцлага хүлээлгэх үндэслэл болж болно.*

21.2.6. Тамирчныг дэмжих этгээд нь хүндэтгэх шалтгаангүйгээр хориотой бодис, хориотой аргыг ашиглах буюу эзэмшихгүй байх

*21.2.6 зүйлд хийх тайлбар: Тамирчныг дэмжих этгээд нь хүндэтгэх шалтгаангүйгээр хориотой бодис, хориотой аргыг ашиглах буюу эзэмших нь энэхүү хуулийн дагуу допингийн эсрэг хууль зөрчсөн үйлдэл болохгүй ч энэ нь бусад сахилгын журам зөрчсөн үйлдэл болж магадгүй. Дасгалжууллагч болон бусад тамирчныг дэмжих этгээд нь ихэнхдээ тамирчны үлгэр жишээ авах загвар хүн нь байдаг. Тэд тамирчныг допинг хэрэглэх сэдэл үүсгэхгүй байх үүрэгтэйгээ зөрчилдсөн аливаа хувийн үйлдэл хийхгүй байх ёстой.*

**21.3. Бүс нутгийн допингийн эсрэг байгууллагын үүрэг хариуцлага**

**21.3.1. Гишүүн орнуудыг энэхүү журамд нийцсэн журам, бодлого болон хөтөлбөрийг боловсруулах хэрэгжүүлэх боломжоор хангах**

**21.3.2. Допингийн Эсрэг Бүс Нутгийн Байгууллагад допингийн үүрэг хариуцлагын төлөөллийг нарийвчлан заасан Допингийн Эсрэг Бүс Нутгийн Байгууллагын албан ёсны гишүүнчлэлийн анкетад гишүүн орнууд гарын үсэг зурахыг гишүүнчлэлийн нөхцөл болгон шаардах**

**21.3.3. Бусад хамааралтай үндэсний болон бүс нутгийн байгууллагууд, агентлагууд болон бусад допингийн эсрэг байгууллагуудтай хамтран ажиллах**

**21.3.4. Допинг эсрэг үндэсний байгууллага болон Допингийн эсрэг бүс нутгийн байгууллага хоорондын харилцан шинжилгээ хийх ажлыг дэмжих**

**21.3.5. Допингийн эсрэг судалгаа хийх**

**21.3.6. Допингийн эсрэг боловсрол олгох**

**22-р зүйл: Улс орны засгийн газруудыг татан оролцуулах**

Улс орнуудын засгийн газар бүр нь энэхүү хуулинд захирагдахаа баталгаажуулан ЮНЕСКО-ын Конвенцийг үнэлэх, хүлээн авах, батлах замаар Копенхагены 2003 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн Споргод Допингийн Эсрэг Тунхаг Бичигт гарын үсэг

зурсанаар энэхүү хуульд татагдан орсныг гэрчилнэ. Гарын үсэг зурсан талуудын хувьд энэхүү заалт хүчин төгөлдөр байна.

22.1. Засгийн газар бүр ЮНЕСКО-ын конвенцийг дагаж мөрдөхөд шаардлагатай бүх арга хэмжээг авна.

22.2. Засгийн газар бүр допингийн эсрэг байгууллагын мэдээг хуваалцах хамтран ажиллах чиглэлээр хууль дүрэм, бодлого болон захиргааны практикийг тогтоон журамд зааснаар допингийн эсрэг байгууллага хооронд мэдээлэл дамжуулна.

22.3. Засгийн газар бүр өөрийн төрийн байгууллага, агентлагууд болон допингийн эсрэг байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааг дэмжин допингийн эсрэг дэмжих чухал хөшүүрэг болсон мэдээлэл цаг хугацаанд нь шуурхай солилцох болон хуулиар хориглоогүй үед мэдээлэл солилцох боломжтой болгосон.

22.4. Засгийн газар бүр арбитрын шүүхийг хүний болон үндсэн хуулиар заасан эрх, үндэсний холбогдох хууль тогтоомжийн дагуу допингтэй холбоотой маргааныг шийдвэрлэх хамгийн зөв арга хэмээн хүндэтгэж үзнэ.

22.5. Өөрийн орондоо допингийн үндэсний байгууллагагүй засгийн газар бүр өөрийн допингийн байгууллагатай болох чиглэлээр Үндэсний Олимпийн Хороотой хамтран ажиллана.

22.6. Засгийн газар бүр өөрийн орны Допингийн Эсрэг Байгууллагын бие даасан байдлыг ханган үйл ажиллагаа болон шийдвэр гаргалтад нөлөөлөхгүй.

22.7. Засгийн газар нь 22.2 зүйлийн хэрэгжилтийг 2016 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэнэ хэмээн найдаж байна. Энэ зүйлийн бусад заалт нь аль хэдийн эхэлчихсэн.

22.8. Засгийн Газар нь ЮНЕСКО-ын конвенцийг үнэлж, батлах, хүлээн авах үйлдлийг хийж чадаагүй буюу ЮНЕСКО-ын конвенийг дагж мөрдөөгүй нь энэхүү хуулийн 20.1.8, 20.3.11, 20.6.6 зүйлүүдэд заасанчлан аливаа үйл ажиллагааны тендерт оролцох эрхгүй болгож болохын зэрэгцээ ДДЭА-д эзлэх байр сууриа болон албан тушаалаа алдах, улс орондоо аливаа олон улсын тэмцээн уралдаан арга хэмжээг зохион байгуулах тендерт

оролцох эрхгүй болох, олон улсын үйл ажиллагаанууд хүчингүй болох, Олимпийн хартийн дагуу билэг тэмдгийн болон бусад үр дагаврууд үүсч болно.

*22-р зүйлд хийх тайлбар: Ихэнх засгийн газрууд хуулиар хувийн, засгийн газрын бус арга хэрэгслүүдээр хязгаарлагдах буюу ийм үйл ажиллагаанд элсээс болохгүй. Ийм шалтгаанаар засгийн газруудыг ийм журамд нэгдэн орох боломжийг хязгаарлах боловч Копенхагены тунхагт гарын үсэг зуран ЮНЕСКО-ийн конвенцийг үнэлжс, батлах, хүлээн авч болно. Энэхүү механизмыг хулээн авах байдал нь өөр өөр ч, хуульд дурьдагдсан тодорхой зохицуулалттай зохицсон кодыг ашиглах нь спортын хөдөлгөөн болон засгийн газрын хоорондын хамтарсан чухал оролдлого болно.*

Энэхүү зүйл нь гарын үсэг зурсан талуудыг засгийн газраас юу хүлээж найдахыг зааж өгдөг. Гэхдээ улс орны засгийн газрууд нь ЮНЕСКО-ын конвенцийн шаардлагад нийцэх үүрэгтэй болохоор эдгээр нь зүгээр л “найдвар” юм.

## **ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ: ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ, ДАГАЖ МӨРДӨХ, ЗАСВАР БОЛОН ТАЙЛБАР ХИЙХ**

### **23-р зүйл: Хүлээн зөвшөөрөх, дагаж мөрдөх, засвар хийх**

#### **23.1. Хуулийг хүлээн зөвшөөрөх**

23.1.1. Дараах байгууллагууд энэхүү хуулийг хүлээн авч гарын үсэг зурсан талууд болно. Үүнд: ДДЭА, Олон Улсын Олимпийн Хороо, Олон улсын холбоод, Олон Улсын Параолимпийн хороо, томоохон үйл ажиллагаа зохион байгууллагчид, Допингийн Эсрэг Үндэсний Байгууллагууд. Эдгээр байгууллагууд нь бас холбогдох удирдах байгууллагуудын баталсанаар тунхагийг хүлээн авч гарын үсэг зурсанаар энэхүү хуулийг хүлээн зөвшөөрсөн тал болно.

*23.1.1 зүйлд хийх тайлбар: Хүлээн Зөвшөөрсөн Тал бүр нь хүлээн зөвшөөрсөн тунхаг бичгийн энгийн хувилбарын стандарт хуулбарт гарын үсэг зуран ДДЭА-д хүргүүлнэ. Хүлээн зөвшөөрөх үйлдэл нь байгууллага бурийн үндсэн бичиг баримтаар хүлээн зөвшөөрөгдөнө гэсэн үг юм. Жишээ нь: Олон улсын Холбоо нь өөрийн конгрессоор харин ДДЭА нь өөрийн сангийн зөвлөлөөр тус тус хүлээн зөвшөөрөгдөнө гэсэн үг юм.*

23.1.2. Гарын үсэг зурсан талуудын удирдлаган дор байдаггүй бусад спортын байгууллагууд нь ДДЭА-ийн удирдлагаар энэхүү хуулийн нөхцлийг хүлээн авч гарын үсэг зурсан тал болж болно.

*23.1.2 зүйлд хийх тайлбар: Аль нэг засгийн газар буюу олон улсын холбооны хууль журамд захирагдахгүй байгаа холбоодыг энэхүү хуулийг дагаж мөрдүүлэхээр санал болгоно.*

23.1.3. ДДЭА-аас бүх хүлээн авсан зүйлсийн жагсаалтыг олон нийтэд үзүүлнэ.

#### **23.2. Хуулийг хэрэгжүүлэх**

23.2.1. Гарын үсэг зурсан талууд нь хуулийн холбогдох заалтуудыг өөрсдийн эрх мэдлийн дагуу үүрэг хариуцлагын холбогдох хүрээнд бодлого, дүрэм, журам, заалтаар дамжуулан хэрэгжүүлнэ.

23.2.2. Допингийн эсрэг байгууллагаас явуулж байгаа допингийн эсрэг үйл ажиллагаатай холбоотой дараах заалтуудыг гарын үсэг зурсан талууд ямар нэгэн томоохон өөрчлөлтгүйгээр (жижиг өөрчлөлт буюу байгууллагын нэр, спорт, хэсгийн дугаар зэргийг заахын тулд хэл солих зэрэг) өөрчлөхийг зөвшөөрнө. Үүнд:

- 1-р зүйл. Допингийн тодорхойлолт
- 2-р зүйл. Допингийн эсрэг хууль зөрчих
- 3-р зүйл. Допингийг батлах
- 4.2.2 зүйл. Тусгай бодисууд
- 4.3.3 зүйл. ДДЭА-ын тодорхойлсон хориотой жагсаалт
- 7.11 зүйл. Спортоос зодог тайлах
- 9-р зүйл. Хувь хүний амжилтыг автоматаар хүчингүй болгох
- 10-р зүйл. Хувь хүнд оногдуулах шийдвэр
- 11-р зүйл. Багт үзүүлэх нөлөө
- 13-р зүйл Давж заалдах /13.2.2, 13.6 болон 13.7 заалтаас бусад/
- 15.1 зүйл. Шийдвэрийг хүлээн зөвшөөрөх
- 17-р зүйл. Хязгаарлалт хийх дүрэм
- 24-р зүйл. Хуулийн тайлбар
- Хавсралт 1: Тодорхойлолт

Энэхүү зүйлд заасан зүйлүүдийг үйлчлэлд нөлөөлөхүйц ямар нэгэн нэмэлт арын үсэг зурсан талуудын журамд оруулахгүй. Гарын үсэг зурсан талуудын журам нь энэхүү хуулийн тайлбар хэлбэртэй байх бөгөөд бүх тайлбар заалтууд нь энэхүү хуульд заасан утгыг илэрхийлнэ.

*23.2.2 зүйлд хийх тайлбар:* Энэхүү хуулийн ямар ч заалт нь допингийн эсрэг байгууллагыг допингтой холбоотойгоор тамирчныг дэмжсих этгээдийг биеэ авч явах байдалд тавигдах өөрийн тусгай сахилгын журмыг батлан хэрэгжүүлэхээс чөлөөлөх. Гэвч энэхүү хуулийн дагуу дээрх үйлдэл нь допингийн эсрэг хууль зөрчсөн үйлдэл болохгүй. Жишээ нь: Үндэсний буюу Олон улсын холбооны хэд хэдэн тамирчин нь допингийн эсрэг хууль зөрчсөн дасгалжуулагчийн лицензийг шинэчлэхээс татгалзаж болно.

23.2.3 Энэ хуулийг хэрэгжүүлэхдээ гарын үсэг зурсан талууд нь ДДЭА-аас санал болгосон хамгийн шилдэг загварыг ашиглана.

### 23.3 Допингийн эсрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх

Энэхүү хууль болон олон улсын стандартад нийцсэн бүх салбаруудын допингийн эсрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхийн тулд гарын үсэг зурсан талууд хангалттай нөөцийг зориулна.

### 23.4 Хуулинд нийцэх

Гарын үсэг зурсан талууд нь энэхүү хуулийн 23.1, 23.2, 23.3 зүйлүүдэд заасны дагуу хуулийг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх хүртэл хуулинд нийцсэн гэж тооцохгүй. Хуулийг хүлээн зөвшөөрөх үйлдлийг хүчингүй болгосон бол энэхүү хуулинд нийцсэн гэж тооцохгүй.

### 23.5 Энэхүү хууль болон ЮНЕСКО-ийн конвенцийг дагаж мөрдөж байгаа эсэхийг хянах

23.5.1 Энэхүү хуулийг дагаж мөрдөж байгаа эсэхийг ДДЭА буюу ДДЭА-гаас хүлээн зөвшөөрсөн бусад хэлбэрээр хянана.

23.3 зүйлд шаардсаны дагуу допингийн эсрэг хөтөлбөрийг дагаж мөрдөж байгаа эсэхийг ДДЭА-ийн гүйцэтгэх хорооноос гаргасан шалгуурт үндэслэн хянана.

ЮНЕСКО-ийн конвенцид заасан тайлбарыг дагаж мөрдөж байгаа эсэхийг тус конвенцийн гишүүн орнуудын хуралдаанаас ДДЭА болон гишүүн орнуудтай зөвлөлдсөний үндсэн дээр гаргасан зөвлөмжийн дагуу хянаж үзнэ. ДДЭА нь гишүүн орнууд энэхүү хуулийг хэрэгжүүлэх талаар зөвлөмж өгч ЮНЕСКО-ийн конвенцид нэгдэж дагаж мөрдөж байгаа эсэхийг үнэлэх талаар гарын үсэг зурсан талуудад зөвлөмж өгнө.

23.5.2 Хяналт явуулахын тулд гарын үсэг зурсан тал бүр нь ДДЭА-ийн зөвлөлөөс тайлбарласны дагуу хуулийг дагаж мөрдөж байгаа талаар тайланг ирүүлэн, дагаж мөрдөөгүй тохиолдолд холбогдох шалтгааныг тайлбарлана.

23.5.3 Гарын үсэг зурсан тал нь 23.5.2 зүйлд заасан зорилгоор ДДЭА-гаас шаардсан мэдээллийг өгөөгүй буюу энэхүү хуулийн бусад зүйлүүдэд заасны дагуу ДДЭА-д ирүүлэх мэдээллийг ирүүлээгүй тохиолдолд энэхүү хуулийг дагаж мөрдөөгүй гэж тооцож болно.

23.5.4 ДДЭА-ийн зөвлөлөөс ДДЭА-ийн бүх дүрэм журмыг дагаж мөрдөж байгаа эсэхийг батлана. ДДЭА нь гарын үсэг зурсан талуудтай харилцан тохиролцож аливаа дүрэм зөрчөөгүй байгаа үйлдлийн талаарх мэдээллийг өгнө. ДДЭА-ийн зөвлөлөөс гаргасан аль нэг дүрмийг зөрчөөгүй талаарх тайлан баримтыг ДДЭА-ийн зөвлөлөөс тухайн талтай хийсэн хурлын үеэр баталж, энэ талаар бичгээр хийсэн тайлбарыг зөвлөлд ирүүлнэ. ДДЭА-ийн зөвлөлөөс тухайн талыг дүрэм журмыг мөрдөөгүй талаар гаргасан шийдвэрийн талаар энэхүү хуулийн 13.6 зүйлд заасанчлан давж заалдаж болно.

23.5.5 ДДЭА нь Олон Улсын Олимпийн Хороо, Олон Улсын Паралимпийн Хороо, Олон Улсын холбоод болон томоохон үйл ажиллагаа зохион байгуулагчдад дүрэм журам мөрдөж байгаа эсэх талаар тайлбарыг хүргүүлнэ. Эдгээр тайлангуудыг мөн олон нийтэд харуулна.

23.5.6 ДДЭА нь дүрэм журмыг зөрчөөгүй талаар, мөн өвөрмөц нөхцөл байдлууудын талаар хийсэн тайлбараудыг авч үзэх ба Олон Улсын Олимпийн Хороо, Олон Улсын Паралимпийн Хороо, Олон Улсын Холбоод болон томоохон үйл ажиллагаа зохион байгуулагчдад энэхүү дүрэм зөрчсөн үйлдлийг өршөөн хэлтрүүлэх талаар тайлбарыг ирүүлж болно.

### 23.6 Энэхүү хуулийг дагаж мөрдөөгүйгээс шалтгаалан үүсч болох нэмэлт нөхцөл байдлууд

Аль нэг гарын үсэг зурсан тал нь энэхүү хуулийг дагаж мөрдөөгүй нь түүнийг энэхүү хуулийн 20.1.8 Олон Улсын Олимпийн Хороо 20.3.11 Олон Улсын Холбоод болон 20.6.6 томоохон үйл ажиллагаа зохион байгуулагчид гэсэн хэсгүүдэд заасан үйл ажиллагаа зохион байгуулах тендерт оролцох эрхийг хасахаас гадна ДДЭА-ийн зөвлөл буюу албан тушаалаас огцрох,

олон улсын үйл ажиллагаанд улс орноо төлөөлөн оролцох гэж байгаа аливаа нэр дэвшигчийг хүлээн авахгүй байх, олон улсын үйл ажиллагаануудыг хүчингүй болгох түүнчлэн олимпийн хартийн дагуу бэлэг тэмдэг болон бусад үр дагавруудыг үүсгэж болно. Ийм үр дүнгүүд оногдуулсан талаар энэхүү хуулийн 13.6-д заасны дагуу хохирогч болсон талууд нь CAS-д давж заалдах буюу гомдол гаргаж болно.

*23.5.6 зүйлд хийх тайлбар: ДДЭА нь гарын үсэг зурсан талууд болон засгийн газруудын дунд допингийн эсрэг туршлага, нөөц эсвэл тухайн допингийн эсрэг үйл ажиллагааг явуулж байгаа эрх зүйн орчин ялгаатай байгаа эсэхийг хүлээн зөвшөөрөх ёстай. Тухайн байгууллага хуулийг дагаж мөрдөж байгаа эсэхийг тогтоохын тулд ДДЭА нь дээрх ялгаануудыг хянан үзнэ.*

## 23.7 Хуулинд оруулах өөрчлөлтүүд

23.7.1 ДДЭА нь энэхүү хуулийг сайжруулах өөрчлөх талаар хариуцлага хүлээн, тамирчин болон бусад этгээдүүд засгийн газрууд нь энэ процессд оролцож болно.

23.7.2 ДДЭА нь энэхүү хуулинд нэмэлт өөрчлөлт оруулахаар санаачлага гаргагч буюу тамирчин болон бусад этгээдүүд засгийн газруудтай тухайн санал болгосон нэмэлт өөрчлөлтийг хянан үзэх, хариу өгөх талаар хамтран ажиллаж тухайн байгууллагуудад тодорхой зааварчилгаа өгөх буюу хариу хүлээж авах зэргээр харилцан зөвлөлдөх үйл ажиллагааг явуулна.

23.7.3 Энэхүү хуулинд оруулсан нэмэлт өөрчлөлт нь тодорхой хэмжээнд зөвлөлдөн ярилцсаны дараа ДДЭА-ийн зөвлөлийн нийт гишүүдийн 2/3-ын олонхын саналаар батлагдах бөгөөд энэхүү олонход олон нийтийн байгууллага, олимпийн хөдөлгөөний гишүүд зэрэг хүмүүс оролцно. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь тухайн батламжийг гаргасанаас хойш 3 сарын дотор хүчин төгөлдөр болно.

23.7.4 Гэрээнд гарын үсэг зурсан талууд нь өөрсдийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж 2015 оны 1 дүгээр сарын 1-ээс өмнө буюу 2015 оны хуулийг батлахад зориулан өөрсдийн дүрэм журмыг өөрчлөх ба энэхүү дүрэм журам нь 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр

болно. Гарын үсэг зурсан талууд нь энэхүү хуулинд оруулах холбогдох нэмэлт өөрчлөлтийг ДДЭА-ийн зөвлөлөөс баталсанаас хойш 1 жилийн дотор хэрэгжүүлнэ.

### 23.8 Хуулийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзах

Гарын үсэг зурсан талууд WADA-д энэхүү хуулийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзах талаар бичгээр 6 сарын өмнөөс мэдэгдэл өгсөний үндсэн дээр энэхүү хуулийг дагаж мөрдөхөөс татгалзаж болно.

## **24-р зүйл: Хуулинд хийх тайлбар**

24.1 Энэхүү хуулийн албан ёсны текстийг ДДЭА-аас хариуцан Англи, Франц хэлээр хэвлүүлэх болно. Англи, Франц хувилбаруудын хооронд ямар нэгэн үл ойлголцол зөрчил гарсан тохиолдолд Англи эхийг баримтална.

24.2 Энэхүү хуулийн төрөл бүрийн заалтуудын талаар хийх тайлбарыг энэхүү хуулийн үндсэн тайлбар болгон ашиглана.

24.3 Энэхүү хуулийг бие даасан текст болгон тайлбарлах ба аль нэгэн гарын үсэг зурсан тал болон засгийн газрын холбогдох дүрэм журмын дагуу тайлбарлахгүй.

24.4 Энэхүү хуулийн төрөл бүрийн хэсгүүд болон заалтуудад ашиглагдсан гарчигууд нь зөвхөн ойлгомжтой болгох үүднээс хийгдсэн учраас энэ хуулийн ямар нэгэн бүрэлдэхүүн хэсэг гэж тооцогдохгүй бөгөөд энэхүү заалтад хийсэн аливаа тайлбарт сөргөөр нөлөөлөхгүй.

24.5 Энэхүү хууль нь батлагдах өдрөөс өмнө аль нэг гарын үсэг зурсан талын хүлээн зөвшөөрсөн буюу өөрийн хуулиндаа ашиглагдсан асуудлуудад хамаарахгүй. Гэхдээ энэхүү хууль гарахаас өмнө үүссэн допингийн эсрэг хуулийг зөрчсөн аливаа үйлдэл нь анхны зөрчил буюу хоёрдахь зөрчил гэх мэтчилэн тоологдож энэхүү хуулийн 10-р зүйлд заасны дагуу холбогдох хууль батлагдсаны дараах зөрчлийн тоонд оруулах эсэхийг тодорхойлох зорилгоор ашиглагдана.

24.6 Дэлхийн Допингийн Эсрэг хөтөлбөрүүд болон энэхүү хуулийн зорилго, хүрээ зохион байгуулалт болон хавсралт:

- ✓ Тодорхойлолт хавсралт
- ✓ 10-р зүйлийг ашиглах жишээнүүд нь энэхүү хуулийн салшгүй хэсэг гэж тооцогдоно.

## **25-р зүйл: Шилжилтийн заалтууд**

**25.1 2015 оны хуулийн ерөнхий хамрах хүрээ**

2015 оны хууль нь 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Цаашид хүчин төгөлдөр болох өдөр гэх.

**25.2 Лекс Митёор зарчим үйлчлэхгүй тохиолдол буюу энэхүү хуулийн 10.7.5 болон 17-р зүйлд зааснаас бусад Petro актив бус заалтууд. Энэхүү хуулийн 10.7.5 зүйлд заасанчлан хэд хэдэн удаагийн зөрчлийг тодорхойлох зорилгоор өмнө нь зөрчил гаргаж байсан ретроспектив хугацааг тооцон үзнэ. Түүнчлэн энэхүү хуулийн 17-р зүйлд заасан хязгаарлалтын дүрэм зэрэг нь үйл ажиллагааны гол хууль болох бөгөөд ретроактив хэлбэрээр ашиглагдах болно.**

Гэхдээ энэхүү хуулийн 17-р зүйл нь зөвхөн хүчин төгөлдөр хугацаа дууссанаас хойш үүссэн хязгаарлалтын хугацааны талаарх дүрэм журамд хамааралтай болно. Үүнээс гадна хүчин төгөлдөр болох хугацааны үед хараахан шийдэгдээгүй байсан аливаа допингийн эсрэг хууль зөрчсөн талаарх хэрэгтэй холбогдуулан эсвэл хүчин төгөлдөр болсноос хойш үүссэн допингийн эсрэг хууль зөрчсөн аливаа үйлдлүүдийг тухайн үеийн хүчин төгөлдөр байсан допингийн эсрэг хуулиуд зөрчсөн талаар гомдол мэдүүлсэн өдрийн талаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжуудын үндсэн дээр шийдвэрлэнэ. Гэхдээ зөвлөлөөс тухайн хэргийг лекс митёор зарчмын дагуу хэрэгжүүлнэ гэж тооцвол тухайн нөхцөлийн дагуу хэргийг шийдвэрлэнэ.

**25.3 2015 оны хуулиас өмнө гаргасан шийдвэртэй холбоотой өргөдлүүд**

Энэхүү хуулинд заасан хүчин төгөлдөр хугацаанаас гарсан допингийн эсрэг хуулийг зөрчсөн талаарх эцсийн шийдвэр гаргасан хэргүүдийн тухай тухайн хүчин төгөлдөр болох өдрөөс өмнө үйлдэгдсэн хэрэг гэж үзэхээс гадна тамирчин

болон бусад этгээдүүд эрх хасуулсан хугацаандаа байгаа гэж Үзэхийн зэрэгцээгээр тамирчин буюу бусад этгээдүүд нь үр дүнгийн менежментийн хариуцлага хүлээсэн допингийн эсрэг байгуулагуудад давж заалдаж болно. Ингэснээр энэ нь 2015 оны хуулийн дагуу эрх хасах хугацааг бууруулах үндэслэл болж болно. Ийм өргөдлийг эрх хасуулсан хугацаа дуусахаас өмнө гаргасан байх ёстой. Допингийн эсрэг байгууллагаас гаргасан шийдвэрийг энэхүү хуулийн 13.2 зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ. 2015 оны хууль нь допингийн эсрэг хууль зөрчсөн талаарх хэргийн талаар эцсийн шийдвэр буюу эрх хасах хугацаа аль дууссан тохиолдолд ямар нэгэн өргөдлийг хүлээн авахгүй.

25.4 2015 оны 1 дүгээр сарын 1-нээс өмнө гарсан анхны удаагийн зөрчилтэй холбоотой хэд хэдэн удаагийн үйлдэл.

Энэхүү хуулийн 10.7.1 хэсэгт хоёрдахь удаагийн зөрчлийн хувьд эрх хасах хугацааг тогтоох зорилгоор анхны зөрчил гаргасантай холбогдуулан үүсэх шийтгэлийг 2015 оны хуулиас өмнө гарсан хуулиудаар тооцох бөгөөд эрх хасах хугацааг 2015 оны хуулиар эхний зөрчил гарсанаас өмнө болсон хэрэг хэмээн тооцож тогтооно.

*25.4 зүйл хийх тайлбар: Энэхүү хуулийн 25.4-т тайлбарласан нөхцөл байдлаас бусад тохиолдолд эцсийн шийдвэрээр тухайн хуулийг батлахаас өмнө допингийн эсрэг хууль зөрчсөн гэж үзвэл энэхүү хуулийн дагуу 2015 оноос өмнө хучин төгөлдөр үйлчилж байсан хуулийн дагуу эрх хасах хугацааг бутэн эдэлж дууссан гэж үзвэл 2015 оны хуулиар энэхүү өмнө нь хэрэг зөрчсөн үйлдлийг дахин ашиглаж анхаарч үзэхгүй.*

## 25.5 Хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах

Энэхүү хуулинд орсон аливаа нэмэлт өөрчлөлтүүд нь энэхүү хуулийн 23.7-д заасны дагуу хучин төгөлдөр болно.

## **ХАВСРАЛТ 1 – ТОДОРХОЙЛОЛТ**

### **Тодорхойлолтууд**

**АДАМС:** АДАМС буюу Допингийн Эсрэг Удирдлага Менежментийн Систем гэдэг нь өгөгдөл хадгалах хууль дүрмийн дагуу допингийн эсрэг үйл ажиллагаа явуулахад хөрөнгө оруулагч болон ДДЭА-д туслах зориулалттай өгөгдөл оруулах, хадгалах, хуваарилах болон тайлагнахад зориулсан веб-д суурилсан өгөгдлийн менежментийн хэрэгсэл юм.

**Захирах** гэдэг нь хориотой бодис болон хориотой аргыг хэн нэгэн өөр этгээд ашигласан буюу ашиглахыг завдсан хэргийг хангах, хангалт хийх, удирдах, дэмжих болон бусад байдлаар оролцохыг хэлнэ. Гэхдээ энэхүү тодорхойлолтонд жинхэнэ болон хууль ёсны эмчилгээний зорилгоор ашиглагдсан хориотой бодис болон хориотой аргыг хамарсан эмнэлгийн ажилтны үйлдлийг багтаахгүй. Түүнчлэн энэхүү хориотой бодис нь спортын гүйцэтгэлийг сайжруулах зорилготой буюу жинхэнэ болон хууль ёсны эмчилгээний зорилгоор ашиглагдаагүй гэдгийг бүхэлдээ харуулах нөхцөл байдлаас бусад тэмцээнээс гадуур шинжилгээнд ашиглагдахыг хориглоогүй хориотой бодисыг хамруулсан үйлдлүүдийг энэхүү тодорхойлолтод багтаахгүй.

**Сөрөг анализик үзүүлэлт:** ДДЭА-ийн магадлан итгэмжлэгдсэн лаборатори буюу бусад ДДЭА-аас хүлээн зөвшөөрөгдсөн лабортаториудын Олон улсын лабораторийн стандарт болон холбогдох бичиг баримтуудад заасны дагуу явуулсан дээжинд хориотой бодис, түүний метаболитууд болон маркерууд (эндогени бодисуудын нэмэгдсэн дүнгээр) эсвэл хориотой арга хэрэглэсэн нотлох баримт байгааг тодорхойлсон шинжилгээ

**Сөрөг паспортын өгөгдөл:** Холбогдох олон улсын стандартад заасан Сөрөг паспортын өгөгдөл хэмээн тодорхойлсон тайлан

**Допингийн эсрэг байгууллага:** Допингийн хяналтын процессын аль нэг хэсгийг санаачлах, мөрдөх журмыг хэрэгжүүлэх үүрэгтэй гарын үсэг зурсан тал болно. Үүнд: жишээ нь Олон Улсын Олимпийн Хороо, Олон Улсын Паралимпийн Хороо, өөрсдийн тэмцээнд зориulan допингийн шинжилгээ хийж байгаа Томоохон Үйл Ажиллагаа Зохион Байгуулагчид, ДДЭА, Олон Улсын Холбоод болон Допингийн Эсрэг Үндэсний Байгууллагууд тус тус багтана.

**Тамирчин:** Үндэсний/үндэсний допингийн эсрэг байгууллагын тодорхойлсоноор/ болон олон улсын /аль нэг олон улсын холбооны тодорхойлсоноор/ хэмжээнд аль нэг спортын төрлөөр өрсөлдөж байгаа этгээдийг хэлнэ. Допингийн эсрэг байгууллага нь олон улсын ч, үндэсний ч хэмжээний тамирчин биш этгээдэд ч допингийн эсрэг хууль хамааралтай учраас тэднийг тамирчин гэсэн тодорхойлолтод багтаана. Олон улсын ч, үндэсний ч хэмжээний тамирчин биш этгээдийн хувьд допингийн эсрэг байгууллага нь хязгаарлагдмал шинжилгээ явуулах буюу огт шинжилгээ хийхгүй байх, хориотой жагсаалтын заримыг нь оролцуулан дээжийг шинжлэх, хязгаарлагдмал буюу ямар ч мэдээлэл өгөхгүй байхыг шаардах эсвэл урьдчилсан эмчилгээний зориулалтаа ашиглах эмийн жагсаалтыг шаардахгүй байх зэрэг сонголтыг хийж болно.

Гэхдээ хэрэв тамирчин нь энэхүү хуулийн 2.1, 2.3, 2.5 зүйлүүдэд заасан допингийн эсрэг хуулийг зөрчсөн үйлдэлд үндэсний болон олон улсын түвшиний эрхтэй допингийн эсрэг байгууллагууд шийтгэл оногдуулсан бол энэхүү хуулийн 14.3.2-т зааснаас бусад үр дүнгүүд үүснэ. Энэхүү хуулийн 2.8, 2.9 зүйлүүдэд заасан зорилгоор болон допингийн эсрэг мэдээлэлд боловсрол олгох зорилгоор гарын үсэг зурсан талууд түүний засгийн газар эсвэл бусад спортын байгууллагуудын эрх мэдлийн дагуу спортын тэмцээн уралдаанд оролцож буй энэхүү хуулийг хүлээн зөвшөөрсөн этгээдийг тамирчин гэнэ.

*Тамирчин гэсэн нэр томъёонд оруулах тайлбар: Энэхүү тодорхойлолт нь энэхүү хуулийн допингийн эсрэг заалтын дагуу үндэсний болон олон улсын хэмжээний тамирчид гэж хэнийг хэлэх вэ гэдгийг Олон улсын холбоод Допингийн Эсрэг Үндэсний байгууллагуудын тодорхойлолтын дагуу нарийвчлан тодорхойлох боломжийг олгоно.*

Энэхүү тодорхойлолтоор мөн допингийн эсрэг үндэсний байгууллага нь үндэсний болон олон улсын тэмцээн уралдаанд оролцож байгаа тамирчдад үйлчлэх допингийн эсрэг хөтөлбөрийг өргөтгөн доод түвшиний тэмцээн уралдаанд оролцож байгаа тамирчин болон зөвхөн чийрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцож байгаа дахин тэмцээн уралдаанд оролоцохоо больсон этгээдүүдэд бас энэхүү допингийн эсрэг хууль нь хамааралтай байхаар өргөтгөж өгсөн. Тиймээс допингийн эсрэг үндэсний байгууллага

нь сонирхогчийн түвшинд уралдаж байгаа тамирчдыг бас шалгаж болох ч урьдчилсан эмчилгээний зориулалтаар хориотой бүтээгдэхүүн ашигласан эсэхийг урьдчилан шалгахыг шаардаггүй. Гэхдээ сөрөг аналитик үзүүлэлт болон допингийн дээжинд нөлөөлсөн зэрэг допингийн эсрэг хууль зөрчсөн зэрэг үйлдлүүд нь энэхүү хуульд заасны дагуу (Энэхүү хуулийн 14.3.2-оос бусад) аливаа үр дүн шийтгэл үүсгэж болно. Энэхүү шийтгэл нь чийрэгжүүлэх үйл ажиллагаа явуулж байгаа сонирхогчдын түвшиний тамирчдад хамаарах эсэх шийдвэрийг допингийн эсрэг үндэсний байгууллага гаргана. Ийм байдлаар томоохон үйл ажиллагаа зохион байгуулагчид нь мастеруудын түвшиний тэмцээнд оролцож байгаа оролцогчдод дээжийн шинжилгээ хийж болох ч бүрэн цэсээр дээж шинжлэхгүй. Бүх төрлийн тэмцээн уралдаанд оролцож байгаа хүмүүс допингийн эсрэг мэдээлэл, боловсрол олж авах ёстой.

**Тамирчны биологийн паспорт:** Олон улсын тест шинжилгээ хийх стандарт болон Олон улсын лабораторийн стандартад заасанчлан өгөгдөл цуглуулах, боловсруулах, аргачлал, хөтөлбөр

**Тамирчныг дэмжих этгээд:** Аливаа шүүгч, дасгалжуулагч, менежер, төлөөлөгч, багийн ажилтанууд, албан хаагч, эмнэлэгийн, пара эмнэлэгийн ажилтнууд, эцэг эхчүүд болон спортын тэмцээн уралдаанд оролцож буюу бэлтгэж байгаа тамирчинтай хамтран ажиллаж эмчилж тусалж байгаа бусад этгээд

**Оролдлого:** Допингийн эсрэг хууль зөрчсөн гэж тооцогдох аливаа үйлдлийг төлөвлөн хийх томоохон алхамыг зорилготойгоор хийх үйлдэл юм. Гэхдээ аливаа этгээд өөрийн дүрэм зөрчихийг завдсан оролдлогыг дүрэм зөрчихийг оролдоогүй хэн нэгэн гуравдагч этгээд зарлахаас өмнө допингийн эсрэг хуулийг зөрчих оролдлого хийсэн талаар өөрөө мэдэгдвэл үүнийг допингийн эсрэг хууль зөрчсөн гэж тооцохгүй.

**Хэвийн бус үзүүлэлт:** Лабораторийн шинжилгээний талаарх олон улсын стандарт болон холбогдох техникийн бичиг баримтад заасны дагуу сөрөг аналитик үзүүлэлтийг тогтоохоос өмнө цаашдын судалгаанд шаардлагатай ДДЭА-гийн магадлан итгэмжлэгдсэн лаборатори болон ДДЭА-гаас хүлээн зөвшөөрөгдсөн бусад лабораторийн хариу

**Сөрөг Паспортын үзүүлэлтүүд:** Холбогдох олон улсын стандартад сөрөг пасспортын үзүүлэлт хэмээн тодорхойлсон сөрөг пасспортын үзүүлэлтүүд.

**CAS:** Спортын Арбитрийн шүүх

**Хууль:** Дэлхийн допингийн эсрэг хууль

**Тэмцээн:** Ганцаарчилсан уралдаан, тэмцээн, тоглолт, болон спортын нэг төрлийн тэмцээн. Жишээ нь: Сагсан бөмбөгийн тоглолт болон олимпийн 100 метрийн уралдааны финалын шатууд. Үе шаттай уралдаанууд болон шагналыг өдөр өдөрт нь буюу үе шаттайгаар олгодог спортын бусад тэмцээн уралдаануудын хувьд үйл ажиллагаа болон тэмцээний хоорондын ялгааг холбогдох олон улсын холбооны журамд заасны дагуу тооцно.

**Допингийн эсрэг хууль зөрчсөний үр дүн:** Тамирчин болон бусад этгээд допингийн эсрэг хууль зөрчсөн тохиолдолд дараах хариуцлагыг хүлээнэ. Үүнд:

- A. *Хүчингүй болгох гэдэг нь тамирчны тодорхой тэмцээн буюу үйл ажиллагаанд гаргасан амжилтыг хүчингүй болгох. Ингэснээр холбогдох үр дүнгүүд буюу медаль, оноо, шагналуудыг хураан авахыг хэлнэ.*
- B. *Эрх хасах:* Тамирчин буюу бусад этгээд допингийн эсрэг хууль зөрчсөн нь тодорхой хугацаанд аливаа тэмцээн болон энэхүү хуулийн 10.12.1-д заасан бусад үйл ажиллагаа санхүүжүүлэлтэд оролцох эрхийг хасна гэсэн үг юм.
- C. *Хэсэгчлэн хүчингүй болгох гэдэг нь тамирчин болон бусад этгээд энэхүү журмын 8-р зүйлд заасны дагуу хуралдаан явуулан эцсийн шийдвэр гаргахаас өмнө аливаа тэмцээн уралдаанд оролцохыг түр зуур хориглоно гэсэн үг юм.*
- D. *Санхүүгийн үр дагавар гэдэг нь допингийн эсрэг хууль зөрчсөний төлөө оногдуулах санхүүгийн шийтгэл буюу допингийн эсрэг хууль зөрчсөнтэй холбоотой нөхөн төлөх аливаа зардлыг хэлнэ.*
- E. Олон нийтэд зарлах буюу олон нийтэд мэдээлэх гэдэг нь энэхүү хуулийн 14.4-р зүйлд заасан эрт мэдээлэл

авах эрхтэй бусад этгээдүүд буюу олон нийтэд мэдээлэл дамжуулах, задруулахыг хэлнэ. Багийн спорт дахь баг нь энэхүү хуулийн 11-р зүйлд заасанчлан Үр Дүнг хариуцна.

**Халдвартай бүтээгдэхүүн:** Бүтээгдэхүүний шошго болон интернэтийн хайлтаас гарч ирсэн мэдээллээс олож харах боломжгүй, хориотой агууламж агуулсан бүтээгдэхүүн.

**Допингийн хяналт:** Мэдээлэл, дээж цуглуулах болон зохицуулах лабораторийн шинжилгээ, эмчилгээний зориулалтаар хэрэглэгдэх бүтээгдэхүүн, үр дүнгийн менежмент сонсгал зэрэг зүйлүүдийн хооронд төрөл бүрийн үе шат болон процессуудтай холбоотой аливаа гомдол давж заалдахтай холбогдуулан шинжилгээг хуваарилах төлөвлөх бүх үе шатууд.

**Үйл ажиллагаа:** Олимпийн тоглолт, Дэлхийн аварга, Пан Америкийн аварга гэх мэтийн аль нэг байгууллагын удирдлага дор явуулж байгаа хэд хэдэн цуврал тэмцээн.

**Үйл Ажиллагааны дараалал:** Тухайн үйл ажиллагааг зохион байгуулагчдаас боловсруулсан үйл ажиллагааны дараалал.

**Алдаа:** Алдаа гэдэг нь тодорхой нөхцөл байдалд холбогдох анхаарал халамж тавиагүй буюу үүрэг хариуцлагаа зөрчсөн үйлдэл. Тамирчин болон бусад этгээдийн алдааны түвшинг үнэлэхдээ тооцон үзэх хүчин зүйлүүдэд тамирчин буюу бусад этгээдийн туршлага, тамирчин буюу бусад этгээд насанд хүрсэн эсэх, тахир дутуу зэрэг тусгай нөхцөл байгаа эсэх эрсдэлийн хэмжээ болон шинжилгээ асаргаа хийх түвшин зэргийг тооцон үзнэ.

Тамирчин буюу бусад этгээдийн алдааны түвшинг үнэлэхдээ үүссэн нөхцөл байдал нь өвөрмөц, тамирчин буюу бусад этгээд нь яагаад стандарт ёс журмыг зөрчсөн талаар тайлбаруудыг анхаарч үзнэ. Жишээ нь: Аль нэг тамирчин эрх хасуулсан хугацаандаа их хэмжээний мөнгийг олох боломжоо алдсан буюу тухайн тамирчинд хэдхэн жилийн карьер үлдсэн, эсвэл спортын нас нь дуусч байгаа зэрэг нь энэхүү хуулийн 10.5.1 болон 10.5.2 зүйлд заасан эрх хасуулсан хугацааг багасгахад тооцон үзэх холбогдолтой хүчин зүйлс болохгүй.

**Алдаа хэсэгт хийх тайлбар:** Тамирчны алдааны түвшинг үнэлэх

шалгуур нь алдааг тооцон үзэх зүйлүүдтэй ижил байна. Гэхдээ энэхүү хуулийн 10.5.2 зүйлд зааснаар алдааны түвшинг үнэлэн үзэж тамирчин болон бусад этгээдийн зүгээс ямар нэгэн ноцтой алдаа буюу санамсаргүй алдааг гаргаагүй гэсэн дүгнэлт нь шийтгэлийг бууруулах үндэслэл болохгүй.

**Санхүүгийн үр дагавар:** Дээр дурьдсан допингийн эсрэг хууль зөрчсөний үр дагавар гэсэн хэсгийг харна уу.

**Тэмцээний явц дахь:** Олон улсын холбооны хууль дүрэм болон холбогдох үйл ажиллагааг зохион байгуулагчдын журамд өөрөөр заагаагүй бол тэмцээний явц дахь гэсэн нэр томьёо нь тамирчины оролцохоор хувиарлагдсан тэмцээн эхлэхээс 12 цагийн өмнөх хугацаа буюу тухайн тэмцээнтэй холбоотой дээж цуглуулсан хугацааг хэлнэ.

**Бие даасан ажиглагчийн хөтөлбөр:** ДДЭА-гийн удирдлаган дор тодорхой үйл ажиллагаа нь допингийн хяналтын процессийг хэрхэн дагаж мөрдөж байгаа болон өөрсдийн ажиглалтын талаар тайлан бичиж байгаа ажиглагчдын багийг хэлнэ.

**Хувь хүний спорт гэдэг нь** багийн бус спортын төрлүүдийг хэлнэ.

**Эрх эдлэх:** Дээр дурьдсан допингийн эсрэг хууль зөрчсөний үр дүнгийн талаар үзнэ үү.

**Олон улсын үйл ажиллагаа:** Олон Улсын Олимпийн Хороо, Олон Улсын Паралимпийн Хороо, Олон Улсын Холбоо, томоохон үйл ажиллагаа зохион байгуулж, үйл ажиллагаатай холбоотой техникийн ажилтнуудыг томилно.

**Тэмцээний явц дахь хэсэгт хийх тайлбар:** Олон Улсын Холбоо болон үйл ажиллагааг зохион байгуулагчид нь тодорхойлсоноор тэмцээний явц дахь гэдэг нь тэмцээний үеэс ялгаатай үе байна.

**Олон улсын хэмжээний тамирчин:** Олон улсын шинжилгээний стандартын дагуу олон улсын холбооноос тодорхойлсоноор олон улсын түвшний спортын тэмцээн уралдаан өрсөлдөж байгаа тамирчин

**Олон улсын стандарт:** Энэхүү хуулийг дэмжих зорилгоор ДДЭА-гаас баталсан стандарт. Олон Улсын Стандартыг дагаж мөрдөхийн тулд олон улсын стандартанд заасан дүрэм журмыг дагаж мөрдөхөд хангалттай. Олон улсын стандартанд энэхүү

стандартын дагуу боловсруулсан техникийн бичиг баримтуудыг багтаана.

**Томоохон үйл ажиллагаа зохион байгуулагчид:** Тивийн бүс нутгийн болон бусад олон улсын үйл ажиллагааг зохион байгуулах үүрэгтэй үндэсний олимпийн хороодыг багтаасан тивийн холбоод болон бусад олон улсын байгууллагууд

**Шинж тэмдэгүүд:** Хориотой бодис болон хориотой арга хэрэгслэснийг заах биологийн бодисууд, тэдгээрийн нэгдэл болон нэгдлүүд.

**Метаболит:** Био хувирлын процесийн явцад үүссэн аливаа бодис

**Насанд хүрээгүй хүүхэд:** 18 нас хүрээгүй хүн

**Олон улсын тамирчин** гэсэн нэр томьёонд хийх тайлбар шинжилгээний олон улсын стандартын дагуу олон улсын холбоо нь тамирчдыг олон улсын хэмжээний тамирчин хэмээн ангилахад ашиглах шалгуурыг өөрсдөө чөлөөтэй сонгох эрхтэй бөгөөд олон улсын тодорхой үйл ажиллагаанд оролцсон эсэх, зэрэг цол, лицензийн төрөл зэргийг сонгож болно. Гэхдээ эдгээр шалгууруудыг тодорхой ойлгомжтой хэлбэрээр хэвлэн тамирчид ямар үед өөрсдийгөө олон улсын хэмжээний тамирчин гэж тооцогдохоор тодорхой мэдэх боломжтой болгох ёстой

**Жишээ нь:** Энэхүү шалгуур үзүүлэлтэд тодорхой олон улсын үйл ажиллагаанд оролцноо хэмээн заасан бол олон улсын холбооноос тэдгээр үйл ажиллагаа тэмцээн уралдаануудын жагсаалтыг гаргах ёстой.

**Допингийн эсрэг үндэсний байгууллага:** Улс орон бүрээс допингийн эсрэг хуулийг батлан хэрэгжүүлэх, дээж авах, дээжийн үр дүнгийн менежмент, үндэсний түвшинд сонгол явуулах эрх үүрэг бүхий байгууллага. Хэрвээ холбогдох эрх мэдэл бүхий байгууллагаас нарийвчлан заагаагүй бол ийм байгууллага нь тухайн улсын Үндэсний Олимпийн Хороо буюу түүнээс томилсон байгууллага байна.

**Үндэсний тэмцээн уралдаан:** Олон улсын хэмжээний бус дотоодын болон олон улсын түвшиний тамирчидыг оролцуулсан спортын үйл ажиллагаа буюу тэмцээн

**Үндэсний хэмжээний тамирчин:** Допингийн Эсрэг Үндэсний

байгууллагаас Олон Улсын Шинжилгээний стандартын дагуу тодорхойлсоноор үндэсний түвшний спортын тэмцээн уралдаанд оролцож байгаа тамирчин.

**Үндэсний Олимпийн Хороо:** Олон улсын олимпийн хорооноос хүлээн зөвшөөрөгдсөн байгууллага. Үндэсний Олимпийн Хороо гэсэн нэр томьёо нь допингийн салбарт үндэсний олимпийн хорооны үндсэн үүргийг Үндэсний Спортын Холбооноос заадаг улс орнуудын Үндэсний Спортын Хороог бас багтаана.

**Алдаа гаргаагүй буюу санамсаргүй үйлдэл:** Тамирчин буюу бусад этгээд хориотой бодис буюу хориотой арга хэрэглэсэн, допингийн эсрэг хууль зөрчсөн үйлдлүүдээ мэдээгүй санамсар болгоомжгүй харьцсан, тэр ч бүү хэл тодорхой шалтгаантайгаар энэхүү үйлдлээ мэдэж сэжиглээгүй гэж тамирчин буюу бусад этгээд баталж байгаа үйлдлийг хэлнэ. Насанд хүрээгүй хүүхдээс бусад тохиолдолд энэхүү хуулийн 2.1 зүйлийг зөрчсөн тамирчин нь хориотой бодис хэрхэн түүний хodoодонд орсоныг батлан харуулах ёстой.

**Ноцтой алдаа гаргаагүй буюу санамсаргүй үйлдэл:** Ерөнхий нөхцөл байдал болон алдаа гаргаагүй буюу санамсаргүй үйлдэл гэсэн тодорхойлолтод үндэслэн тамирчин буюу бусад этгээд нь алдаа гаргасан буюу санамсаргүй байдлаар хориотой бүтээгдэхүүн хэрэглэсэн нь допингийн эсрэг хуулийг зөрчсөнтэй тийм ч чухал хамааралгүй нөхцөл байдлыг хэлнэ. Насанд хүрээгүй хүүхдээс бусад тохиолдолд энэхүү хуулийн 2.1 зүйлийг зөрчсөн тамирчин нь хориотой бодис хэрхэн түүний хodoодонд орсоныг батлан харуулах ёстой.

**Тэмцээнээс гадуурх:** Тэмцээнд оролцоогүй байсан үеийг хэлнэ.

**Оролцогч:** Тамирчин буюу тамирчиныг дэмжих этгээдийг хэлнэ.

**Этгээд:** Байгалийн хүн буюу аливаа байгууллага аж ахуй нэгжийг хэлнэ.

**Эзэмших:** Бодит буюу бодит бус (Тухайн этгээд тодорхой хяналтай буюу хориотой бодис буюу хориотой аргыг, тухайн хориотой бодис буюу хориотой арга хадгалагдаж байсан байшин барилгыг хянах зорилготой байсан буюу) эзэмшил. Хэрвээ тухайн этгээд нь тухайн хориотой бодис буюу хориотой арга оршин тогтнож байсныг мэдэж байсан ч тэдгээрийг хянах

зорилготой байсан тохиолдолд бодит бус хяналт үүссэн гэж үзнэ. Гэхдээ тухайн этгээд нь допингийн эсрэг хууль зөрчсөн талаар ямар нэгэн мэдэгдэл хүлээн авахаас өмнө тухайн хориотой бодис болон аргыг эзэмших ямар нэгэн зорилго байгаагүй бөгөөд ийм бодис эзэмшсэн талаараа допингийн эсрэг байгууллагад сайн дураараа мэдэгдэж байсан бол тухайн этгээдийг допинг эзэмших тухай допингийн эсрэг хуулийн заалтыг зөрчөөгүй гэж үзнэ.

### **Эзэмших гэсэн зүйлд хийх тайлбар:**

Энэхүү тодорхойлолтоор тамирчны машинаас илэрсэн стероидын талаар тамирчин нь өөрийнх нь машиныг нь өөр хүн эзэмшин хэрэглэж байсан баталгааг гаргаж чадахгүй бол допинг хэрэглэж байсан гэсэн баталгааг үүсгэх ба ийм тохиолдолд допингийн эсрэг байгууллага нь тамирчин машинаа бүрэн хянах боломжгүй байсан ч гэсэн стероидын талаар мэдэж байсан ба стероидыг хянах ёстой байсан гэдгээ батлах ёстой. Үүний адилаар тамирчин болон гэр бүлийн хүний хамтарсан хяналтын дор гэрийн эмийн санд нь стероидын жишээ илэрсэн тохиолдолд тухайн эмийн санд стероид байхыг тамирчин мэдсэн ба түүнийг хянахыг оролдож байсан гэдгээ тайлбарлах ёстой. Хориотой бодис дангаар нь худалдан авсан үйлдэл нь жишээ нь тэр бодисыг авчраагүй өөр нэгэн хүлээн авсан буюу хэн нэгэн гуравдагч этгээдийн хаягаар илгээсэн ч гэсэн тухайн бодисыг эзэмшсэн үйлдэл болно.

**Алдаа гаргаагүй буюу санамсаргүй үйлдэл зүйлд хийх тайлбар:** Каннабисын хувьд тамирчин нь спорттой хамааралгүй шалтгаанаар тухайн бодисыг хэрэглэж байсан гэдгээ тодорхой баталж чадвал тухайн тамирчныг алдаа гаргаагүй буюу санамсаргүй үйлдэл хийсэн гэж үзнэ.

**Хориотой жагсаал:** Хориотой бодис болон хориотой аргыг тодорхойлсон жагсаалт

**Хориотой арга:** Хориотой жагсаалтад багтсан аливаа арга

**Хориотой бодис:** Хориотой жагсаалтад засан аливаа бодис буюу бодисын ангилаал

**Хэсэгчлэн сонсох:** Энэхүү хуулийн 7.9 зүйлд заасан зорилгоор тамирчинд аман болно бичгийн хэлбэрээр сонсгол хийх мэдэгдэл болон боломж өгнө гэсэн 8-р зүйлийн дагуу сонсгол хийхээс

өмнө хураангуйлсан болон хялбаршуулсан сонсгол хийж болно.

*“Хэсэгчлэн сонсох” зүйлд хийх тайлбар: хэсэгчлэн сонсох гэдэг нь хэргийн баримтын талаар бүрэн сонсгол хийхээс өмнө урьдчилсан хэлбэрээр хийж байгаа үйлдэл юм. Хэсэгчлэн сонссоны дараа тамирчин нь хэргийн талаар бүрэн сонсгол хийх эрхтэй. Эсрэгээрээ хурдавчилсан сонсгол гэдэг нь 7.9 зүйлд заасны дагуу хурдасгасан цагийн хуваариар явуулах бүрэн сонсгол юм.*

**Хэсэгчлэн хүчингүй болгох:** Дээр дурьдсан допингийн эсрэг хууль зөрчсөний үр дагаврыг үзнэ үү.

**Олон нийтээс хаах буюу олон нийтэд мэдэгдэх:** Дээр дурьдсан допингийн эсрэг хууль зөрчсөний үр дагаврыг үзнэ үү.

**Бүс нутгийн допингийн эсрэг байгууллага:** гишүүн орнуудаас байгуулсан өөр өөрийн төлөөлдөг нутаг дэвсгэрийн допингийн эсрэг хөтөлбөрийг хариуцах бүс нутгийн байгууллага нь допингийн эсрэг хуулийг батлах болон хэрэгжүүлэх, дээж авах ажлыг төлөвлөх ба дээж авах, үр дүнгийн менежмент, эмчилгээний зорилгоор ашиглах бодисыг хянах, сонсголын журам, бүс нутгийн хэмжээний боловсролын хөтөлбөр явуулах зорилготой бүс нутгийн байгууллага

**Бүртгэлтэй шинжилгээний сан:** Олон Улсын шинжилгээний стандарт болон энэхүү хуулийн 5.6 зүйл заасны дагуу шардлагатай мэдээлэл хүргүүлэх болон Олон улсын холбоо ба допингийн эсрэг үндэсний байгууллагын шинжилгээ хуваарилах төлөвлөгөөний нэг хэсэг болгон тэмцээний үеийн болон тэмцээний бус үеийн шинжилгээ хариуцсан олон улсын холбооноос олон улсын түвшинд гаргасан, допингийн эсрэг үндэсний байгууллагаас үндэсний түвшинд тус тус гаргасан дээд зэрэглэлийн тамирчдын талаарх мэдээллийн сан

**Дээж:** Допингийн хяналтын зорилгоор цуглуулсан аливаа биологийн материал

**Гарын үсэг зурсан талууд:** Энэхүү хуулийн 23-р зүйлд заасанчлан энэхүү хуулийг дагаж мөрдөхийг хүлээн зөвшөөрч гарын үсэг зурсан талууд

**Тусгай бодисууд:** 4.2.2 зүйлийг хар

*Дээжс гэсэн заалтад хийх тайлбар: Заримдаа цусны дээж*

*авах нь зарим шатны болон соёлын бүлгүүдийн занийл журмыг зөрчдөг гэж үздэг. Тиймээс энэ төрлийн тайлбар өгөх үндэслэлгүй гэж үзсэн.*

Хатуу үүрэг хариуцлага энэхүү хуулийн 2.1 болон 2.2 хэсгүүдэд заасанчлан санамсаргүй болон санаандгүй үйлдэл, тамирчны зүгээс мэдэж байсан эсэх нь допингийн эсрэг хууль зөрчсөн эсэхийг тогтоохийн тулд допингийн эсрэг байгууллагаас заавал үзүүлэх шаардлагагүй.

**Томоохон туслалцаа:** Энэхүү хуулийн 16.1 заасан зорилгоор томоохон туслалцаа үзүүлж байгаа этгээд нь:

1. допингийн эсрэг хууль зөрчсөн талаар өөрийн мэдэж байгаа бүх мэдээллээ бичгэн хэлбэрээр бүрэн задруулах ёстой.
2. тухайн мэдээлэлтэй холбоотой допингийн эсрэг байгууллага болон бусад холбогдох зөвлөлөөс байцаалт өгөх болон бусад шаардлагатай хэлбэрээр хэргийг мөрдөхөд бүх шаардлагатай туслалцааг үзүүлж хамтран ажиллах ёстой. Хүргүүлсэн мэдээлэл нь тухайн хэргийн чухал зайлшгүй хэсгийн нэг болох ёстой бөгөөд хэрэв хэрэг үүсгээгүй бол тухайн асуудлыг шийдсэн гол үндэслэл нь болох ёстой.

**Залилан:** Аливаа бүтээгдэхүүнийг хууль бус зорилгоор буюу хууль бус хэлбэрээр ашиглах бусад зүй бус нөлөө үзүүлэх, үйл ажиллагаан зүй бусаар оролцох, саад болох, буруу мэдээлэл өгөх, аливаа залилангийн шинжтэй шинжилгээний хариу болон хэвийн үйл ажиллагаанд нөлөөлсөн үйлдэл.

**Зорилтот шинжилгээ:** Шинжилгээ өгөх олон улсын стандартанд заасан шаардлагын дагуу тамирчныг шалгах тусгай тестийг сонгох.

**Багийн спорт:** Тэмцээний үеэр тамирчдыг солих боломжтой спортын төрөл

**Шинжилгээ:** Шинжилгээ хуваарилах төлөвлөгөө, дээж цуглуулах, дээжийг зохицуулах болон лаборатори руу дээжийг тээвэрлэх асуудлуудыг багтаасан дээжийн хяналтын процессийн хэсгүүд

**Хил давуулсан хориотой наймаа:** Тамирчин, тамирчныг

дэмжих этгээд, бусад этгээдүүд допингийн байгууллагын хууль дүрмийн дагуу хэн нэгэн гуравдагч этгээдэд хориотой бодис болон хориотой аргыг бодитоор, цахим болон бусад хэлбэрээр эзэмшүүлэх зорилгоор худалдах, өгөх, тээвэрлэх, илгээх, хүргэх, буюу хувиарлах үйлдлүүдийг хэлнэ. Гэхдээ энэ тодорхойлолтод хориотой бодисыг хуулинд зөвшөөрсөн цэвэр эмчилгээний зорилгоор буюу бусад хүлээн зөвшөөрөгдсөн зорилгоор ашиглаж байгаа “*Bona fide*” эмнэлэгийн ажилтны үйлдлүүдийг багтаахгүй. Түүнчлэн, тухайн эмчилгээний зориулалттай ашиглах бодисыг спортын гүйцэтгэл сайжруулах болон цэвэр эмчилгээний зорилгоор тэмцээнээс гадуур хориглогдоогүй хэлбэрээр ашиглаж байгаа тохиолдолд энэхүү үйлдэл нь хориотой бодистой холбоотой үйлдэлд хамаarahгүй.

**Эмчилгээний зорилгоор ашиглах:** Энэхүү хуулийн 4.4 хэсэгт заасан эмчилгээний зорилгоор ашиглаж байгаа тохиолдол

**Юнескогийн конвенци:** 2005 оны 10 сарын 19-ны өдрийн ЮНЕСКО-гийн ерөнхий комиссийн 33-р хуралдаанаас баталсан спортом допингийн эсрэг олон улсын конвенци түүнчлэн энэхүү конвенцийн гишүүн орнуудаас тухайн конвенцид оруулсан аливаа нэмэлт өөрчлөлт болон спорт дахь допингийн эсрэг олон улсын конвенцид нэгдэн орсон талуудын хуралдаанаас баталсан нэмэлт өөрчлөлт

**Хэрэглээ:** Хориотой бодис буюу хориотой аргыг ямар нэгэн байдлаар хэрэглэх, ашиглах, залгих, тарих болон бусад ямар нэгэн аргаар ашиглах.

**WADA:** Дэлхийн Допингийн Эсрэг Байгууллага

**Тодорхойлолт хэсэгт хийх тайлбар:** Энэхүү нэр томьёонд энэхүү ашиглагдсан нэр томьёонуудын ганц ба олон тооны хэлбэр, хамаатуулах хэв, бусад үгсийн сангийн хэлбэрээр ашиглагдсан хувилбарууд тус тус багтана.

## **ХАВСРАЛТ 2**

### **10-р зүйлийг ашиглах жишээнүүд**

#### *Жишээ 1*

**Баримт:** Энэхүү 2.1 зүйлд заасан тэмцээний явц дах шинжилгээгээр Анаболик Стеройд илэрсэн гэсэн сөрөг аналитик үзүүлэлт. Тамирчин нь допингийн эсрэг хууль зөрчсөнөө хүлээн зөвшөөрсөн. Тамирчнаас ноцтой алдаа байгаагүй буюу санамсаргүй үйлдэл байсан гэдгийг заасан. Тамирчин их хэмжээний туслалцааг үзүүлсэн.

#### **Үр дагаврыг хянах:**

1. Энэхүү тамирчин нь допингийн эсрэг хууль зөрчсөн үйлдэл нь санаатай үйлдэл биш байсан гэдгийг харуулах энэхүү хуулийн 10.2.1.1 болон 10.2.3 зүйлүүдэд заасан хангалттай шалтгааныг үүсгэх ноцтой алдаа байгаагүй гэсэн баталгааг үзүүлсэн учраас 10.2.2 зүйлд зааснаар эрх хасах хугацаа нь 4 жил биш 2 жил болсон.
2. Хоёрдахь үе шатанд зөвлөлөөс болон энэхүү хуулийн 10.4 болон 10.5 зүйлүүдэд заасанчлан алдаатай холбоотой бууруулах нөхцөл байна уу гэдгийг шалгах шаардлагатай. Учир нь анаболик стеройд нь хориотой бодисын жагсаалтанд багтах ба шийтгэл оногдуулах хүрээ нь 2 жилээс нэг жил хүртэл хугацаагаар бууруулах боломжтой. Зөвлөлөөс энэхүү хүрээнд тамирчны гаргасан алдааны түвшингээс хамааран эрх хасах хугацааг тодорхойлно. (Энэхүү жишээ нь зөвлөлөөс эрх хасах хугацааг 16 сараар олгож болох жишээг харуулахыг зорьсон юм.)
3. Гуравдахь үе шатанд зөвлөлөөс 10.6 зүйлд (Алдаатай холбоогүйгээр хугацааг бууруулах) зүйлд зааснаар шийтгэлийг бууруулах буюу боломж байна гэж үзсэн. Энэ тохиолдолд зөвхөн 10.6.1 (Томоохон туслалцаа үзүүлэх) зүйл үйлчилнэ. 10.6.3 яаралтай хүлээн авах заалт үйлчлэхгүй учир нь 10.6.3 зүйлд заасан 2 жилээс бага эрх хасах хугацааг аль хэдийн заасан. Томоохон туслалцаа үзүүлсэн учраас эрх хасах хугацаа нь 16 сараас  $\frac{3}{4}$  хэмжээгээр буурах боломжтой. Тиймээс эрх хасах хамгийн бага хугацаа нь 4 сар байх боломжтой. (Энэхүү

жишээнд үзүүлсэн 10 сарын хугацааг зөвлөлөөс хассан тохиолдолд эрх хасах хугацаа нь 6 сар болно гэдгийг харуулахыг оролдсон юм.

4. Энэхүү хуулийн 10.11-т зааснаар эрх хасах хугацаа нь зарчмын хувьд эцсийн шийдвэр гаргасан өдрөөс эхэлдэг. Гэвч тамирчнаас допингийн эсрэг хууль зөрчсөнөө нэн даруй хүлээн зөвшөөрсөн учраас эрх хасах хугацаа нь арай эрт буюу дээж авсан өдрөөс тооцогдох боломжтой боловч тамирчин шийдвэр гарсанаас хойш (10.11.2 зүйлд заасны дагуу) эрх хасах хугацааны талыг (ө.х.3 сарыг) эдэлсэн байх ёстой.
5. Сөрөг аналитик үзүүлэлт нь тэмцээний үеэр гарсан учраас зөвлөлөөс тэмцээн гэсэн 9-р зүйлд заасанчлан тэмцээний үр дүнг автоматаар хүчингүй болгох ёстой.
6. 10.8 зүйлд зааснаар шударга ёсны журамд шаардсанаас бусад тохиолдолд тамирчны дээж авах өдрөөс эрх хасах хугацаа эхлэх хүртэлх хугацааны бүх тэмцээний үр дүнгүүдийг хүчингүй болгоно.
7. 10.13 зүйлд заасан шийтгэлийн зайлшгүй нэг хэсэг болдог учраас тамирчин насанд хүрээгүй байхаас бусад тохиолдолд 14.3.2 зүйлд заасан мэдээллийг олон нийтэд задруулах ёстой.
8. Энэхүү хуулийн 10.12.1 зүйлд зааснаар тамирчны эрхийг хассан хугацаанд гарын үсэг зурсан талууд болон түүний салбаруудын эрх мэдлийн хүрээнд тамирчныг тэмцээн буюу аливаа спорттой холбоотой үйл ажиллагаанд оролцохыг зөвшөөрөхгүй. Гэхдээ тамирчин нь
  - А. Эрх хасуулсан хугацааны сүүлийн 2 сард,
  - Б. 10.12.2 зүйлд заасан эрх хасах хугацааны сүүлийн  $\frac{1}{4}$  хугацаанд тус тус гарын үсэг зурсан талууд болон түүний салбаруудын аливаа клуб, бусад гишүүн байгууллагуудын тоног төхөөрөмжийг ашиглан багтайгаа хамт дасгал сургууль хийж болно. Тиймээс тамирчин нь эрх хасах хугацааны сүүлийн 1-1.5 сарын дотор бэлтгэл сургуулилтдаа эргэн ирж болно.

## *Жийнээс 2*

**Баримтууд:** Тэмцээний явцад хийсэн шинжилгээгээр тусгай бодисуудын стимулянтууд байгаагаас үүсэх сөрөг аналитик үзүүлэлт /2.1 зүйл/. Допингийн эсрэг байгууллагаас тамирчин нь тэмцээнээс гадуур спорттой хамааралгүй шалтгаанаар аливаа хориотой бүтээгдэхүүнийг ашигласан гэдгээ батлах боломжгүй байсан. Тамирчин допингийн эсрэг хууль зөрчсөнөө нэн даруй хүлээн зөвшөөрөхгүй байх, тамирчин нь томоохон туслалцаа үзүүлэх

### **Үр дагаврыг хянах:**

1. Энэхүү тамирчин нь допингийн эсрэг хууль зөрчсөн үйлдэл нь санаатай үйлдэл байсан ба тэмцээнээс гадуур тухайн бодисыг ашиглахыг зөвшөөрсөн гэдгийг энэхүү хуулийн 10.2 зүйлд заасанчлан үзүүлсэн учраас бүтээгдэхүүний хэрэглээ нь тамирчны 10.2.3 зүйлд заасан гүйцэтгэл болон 10.2.1.2 хэсэгт заасан эрх хасах хугацаа нь 4 жил байхын шаарддаг.
2. Хууль зөрчсөн үйлдэл нь санаатай үйлдэл байсан болохоор алдаанд тулгуурлан хугацааг бууруулах (Энэхүү хуулийн 10.4 болон 10.5 зүйлүүд үйлчлэхгүй) үндэслэл байхгүй. Томоохон туслалцаанд үндэслэн нийт 4 жилийн хугацааны  $\frac{3}{4}$  хүртэл хэмжээгээр бууруулж болно. Хамгийн бага хугацаа нь 1 жил байна.
3. Энэхүү хуулийн 10.11д заасны дагуу ийм эрх хасах хугацаа нь эцсийн шийдвэр гарган тооцсон өдрөөс эхлэн тооцно.
4. Тэмцээнд дээрх сөрөг аналитик хариу гарсан болохоор зөвлөл нь автоматаар тэмцээнд гаргасан амжилтыг хүчингүй болгож болно.
5. 10.8 зүйлд заасанчлан дээж авсан өдрөөс эрх хасах хугацаа хүртэлх бүх тэмцээний амжилтыг шудрага байдлын журамд өөрөөр заагаагүй бол хүчингүй болно.
6. Энэхүү хуулийн 14.3.2-т заасан мэдээллийг тухайн тамирчин нь насанд хүрээгүйгээс бусад тохиолдолд 10.13 зүйлд заасан шийтгэлийн нэг хэсэг болгон олон нийтэд мэдээлнэ.

7. Энэхүү хуулийн 10.12.1-д заасан тамирчны эрх хасах хугацааны явцад гарын үсэг зурсан талууд буюу түүний салбаруудын эрх мэдлийн хүрээнд аливаа тэмцээн буюу спортын холбоотой үйл ажиллагаанд тухайн тамирчныг ямар нэгэн байдлаар оролцохыг зөвшөөрөхгүй. Гэхдээ тамирчин нь
  - А. Эрх хасулсан хугацааны сүүлийн 2 сард,
  - Б. 10.12.2 зүйлд заасан эрх хасах хугацааны сүүлийн  $\frac{1}{4}$  хугацаанд тус тус гарын үсэг зурсан талууд болон түүний салбаруудын аливаа клуб, бусад гишүүн байгууллагуудын тоног төхөөрөмжийг ашиглан багтайгаа хамт дасгал сургууль хийж болно. Тиймээс тамирчин нь эрх хасах хугацааны сүүлийн 1-1.5 сарын дотор бэлтгэл сургуулилтандаа эргэн ирж болно.

### Жишиг 3

**Баримтууд:** Тэмцээнээс гадуур хийсэн шинжилгээгээр анаболик стероид байгаагаас үүсэх сөрөг анализатор үзүүлэлт (2.1 зүйл). Тамирчин нь ноцтой алдаа буюу санаандгүй үйлдэл байсан гэдгээ батласан. Тамирчин халдвартай бүтээгдэхүүнээс шалтгаалан сөрөг анализатор үзүүлэлт гарсан гэдгээ баталсан.

#### Үр дагаврыг хянах:

1. Эхлэлийн цэг нь энэхүү хуулийн 10.2 зүйл байсан. Учир нь тамирчин нь допингийн эсрэг хууль зөрчсөн үйлдэл нь санаатай үйлдэл байгаагүй, өөрөөр хэлбэл халдвартай бодис ашигласан нь ноцтой алдаа байгаагүй (10.2.1.1 болон 10.2.3 зүйлүүд) гэдгийг нотлох баримтаар баталж чадвал 10.2.2 хэсэгт заасан эрх хасах хугацаа нь 2 жил байна.
2. Хоёр дах үе шатанд зөвлөл нь алдаанд тулгуурлан хугацааг бууруулах (Энэхүү хуулийн 10.4 болон 10.5 зүйлүүд) боломжийг судлана. Тамирчин нь допингийн эсрэг хууль зөрчсөн үйлдэл нь халдвартай бүтээгдэхүүнээс шалтгаалсан болохоор өөрийн зүгээс энэхүү хуулийн 10.5.1.2 зүйлд заасанчлан ноцтой алдаа байгаагүй буюу санамсаргүй үйлдлээс болон гэдгийг баталвал холбогдох эрх хасах хугацааг хоёр жилээс хүчингүй болгох хүртэл бууруулж болно. Зөвлөлөөс

тамирчны алдааны түвшинд үндэслэн энэ хооронд эрх хасах хугацааг тогтооно. (Энэхүү жишээгээр зөвлөл нь эрх хасах хугацааг 4 сар хүртэл бууруулж болно гэдгийг харуулах зорилготой)

3. Энэхүү хуулийн 10.8 зүйлд заасанчлан дээж авсан өдрөөс эрх хасах хугацаа хүртэлх бүх тэмцээний амжилтыг шудрага байдлын хуульд өөрөөр заагаагүй бол хүчингүй болно.
4. Энэхүү хуулийг 14.3.2-т заасан мэдээллийг тухайн тамирчин нь насанд хүрээгүйгээс бусад тохиолдолд 10.13 зүйлд заасан шийтгэлийн нэг хэсэг болгон олон нийтэд мэдээлнэ.
5. Энэхүү хуулийн 10.12.1-д заасан тамирчны эрх хасах хугацааны явцад гарын үсэг зурсан талууд буюу түүний салбаруудын эрх мэдлийн хүрээнд аливаа тэмцээн буюу спортын холбоотой үйл ажиллагаанд тухайн тамирчныг ямар нэгэн байдлаар оролцохыг зөвшөөрөхгүй. Гэхдээ тамирчин нь
  - А. Эрх хасуулсан хугацааны сүүлийн 2 сард,
  - Б. 10.12.2 зүйлд заасан эрх хасах хугацааны сүүлийн  $\frac{1}{4}$  хугацаанд тус тус гарын үсэг зурсан талууд болон түүний салбаруудын аливаа клуб, бусад гишүүн байгууллагуудын тоног төхөөрөмжийг ашиглан багтайгаа хамт дасгал сургууль хийж болно. Тиймээс тамирчин нь эрх хасах хугацааны сүүлийн 1-1.5 сарын дотор бэлтгэл сургуултандaa эргэн ирж болно.

#### Жишиг 4

**Баримтууд:** Сөрөг аналитик үзүүлэлт хэзээ ч гарч байгаагүй тамирчинд өөрийн гүйцэтгэлийг сайжруулах зорилгоор анаболик стероид ашигласнаа хүлээн зөвшөөрсөн. Тамирчин нь бас томоохон туслалцаа үзүүлсэн.

#### Үр дагаврыг хянах:

1. Тамирчин нь допингийн эсрэг хууль зөрчсөн үйлдэл нь санаатай үйлдэл байсан болохоор 10.2.1.1 зүйлийг баримтлан эрх хасах үндсэн хугацаа нь 4 жил байна.

2. Тамирчны допингийн эсрэг хууль зөрчсөн үйлдэлтэй холбогдуулан холбогдох эрх хасах байхгүй. (энэхүү хуулийн 10.4 болон 10.5 зүйлүүд үйлчлэхгүй)
3. Энэхүү хуулийн 10.6.2 зүйлд заасанчлан тамирчин өөрийн үйлдлээ ганцаараа хүлээсэн тохиолдолд 4 жилийн хугацааг хагас хүртэл хэмжээгээр бууруулж болно. Зөвхөн 10.6.1 зүйлд заасанчлан тамирчнаас үзүүлсэн томоохон туслалцаанд үндэслэн эрх хасах хугацааг 4 жилийн  $\frac{3}{4}$  хэмжээгээр цуцалж болно. 10.6.4 зүйлийн дагуу томоохон туслалцаа болон хэргээ хүлээсэн нөхцөлийг хамтад нь тооцон үзээд шийтгэлийн хэмжээг бууруулж болох хамгийн дээд хэмжээ нь 4 жилийн хугацааны  $\frac{3}{4}$  байна. Эрх хасах хугацааны хамгийн бага хэмжээ нь 1 жил байна.
4. Энэхүү хуулийн 10.11-т зааснаар эрх хасах хугацаа нь зарчмын хувьд эцсийн шийдвэр гаргасан өдрөөс эхэлдэг. Гэвч тамирчнаас допингийн эсрэг хууль зөрчсөнөө нэн даруй хүлээн зөвшөөрсөн учраас эрх хасах хугацааг бууруулах боломжтой ч 10.11.2 зүйлд заасны дагуу эрх хасах хугацааг эрт эхлэхийг зөвшөөрдөггүй. Энэхүү зүйл нь тамирчинг ижил нөхцөл давхар боломж эдлэхээс сэргийлдэг. Гэхдээ хэрэв томоохон туслалцаа үзүүлсэний үндсэн дээр эрх хасах хугацааг багасгасан бол 10.11.2 зүйл хүчинтэй хэвээр байх ба эрх хасах хугацаа нь тамирчны хамгийн сүүл анаболик стероид хэрэглэсэн өдрөөс эхэлнэ.
5. Энэхүү хуулийн 10.8 зүйлд заасанчлан дээж авсан өдрөөс эрх хасах хугацаа хүртэлх бүх тэмцээний амжилтыг шудрага байдлын журамд өөрөөр заагаагүй бол хүчингүй болно.
6. Энэхүү хуулийг 14.3.2-т заасан мэдээллийг тухайн тамирчин нь насанд хүрээгүйгээс бусад тохиолдолд 10.13 зүйлд заасан шийтгэлийн нэг хэсэг болгон олон нийтэд мэдээлнэ.
7. Энэхүү хуулийн 10.12.1-д заасан тамирчины эрх хасах хугацааны явцад гарын үсэг зурсан талууд буюу түүний салбаруудын эрх мэдлийн хүрээнд аливаа тэмцээн буюу спортын холбоотой үйл ажиллагаанд тухайн тамирчныг ямар нэгэн байдлаар оролцохыг зөвшөөрөхгүй. Гэхдээ тамирчин нь

- А. Эрх хасуулсан хугацааны сүүлийн 2 сард,
- Б. 10.12.2 зүйлд заасан эрх хасах хугацааны сүүлийн  $\frac{1}{4}$  хугацаанд тус тус гарын үсэг зурсан талууд болон түүний салбаруудын аливаа клуб, бусад гишүүн байгууллагуудын тоног төхөөрөмжийг ашиглан багтайгаа хамт дасгал сургууль хийж болно. Тиймээс тамирчин нь эрх хасах хугацааны сүүлийн 1-1.5 сарын дотор бэлтгэл сургуулилтандaa эргэн ирж болно.

## Жишиг 5

**Баримтууд:** Тамирчныг дэмжих этгээд нь тамирчинд худлаа нэрээр тэмцээнд орсонтой холбогдуулан олгосон эрх хасах шийтгэлээс чөлөөлөгдөхөд нь туслана. Допингийн эсрэг байгууллагаас хууль зөрчигдсөн талаар мэдэгдэл ирүүлэхээс өмнө 2.9 зүйлд заасанчлан допингийн эсрэг хууль зөрчсөн талаар мэдэгдэнэ.

### Үр дагаврыг хянах:

1. Энэхүү хуулийн 10.3.4 зүйлд заасанчлан тамирчин нь допингийн эсрэг хууль зөрчсөн үйлдэл нь хир зэрэг ноцтой байснаас хамааран эрх хасах хугацаа нь 2-4 жил байна. (Энэ нь зөвлөлөөс тамирчинд оногдуулсан эрх хасах хугацаа нь 3 жил байж болно гэдгийн жишээг харуулах зорилготой)
2. Энэхүү хуулийн 2.9 зүйлд заасан допингийн эсрэг хууль зөрчсөн элемент нь сэдэл байсан болохоор алдаатай холбоотой эрх хасах хугацааг бууруулах үндэслэл байхгүй. (10.5.2 зүйлд заасан тайлбарыг үз)
3. Энэхүү хуулийн 10.6.2 зүйлд заасанчлан тамирчин өөрийн үйлдлээ ганцаараа хүлээсэн тохиолдолд эрх хасах хугацааг хагас хүртэл хэмжээгээр бууруулж болно. (Энэ нь зөвлөлөөс тамирчинд оногдуулсан эрх хасах хугацаа нь 18 сар хүртэл байж болно гэдгийн жишээг харуулах зорилготой)
4. Энэхүү хуулийг 14.3.2-т заасан мэдээллийг тухайн тамирчин нь насанд хүрээгүйгээс бусад тохиолдолд 10.13 зүйлд заасан шийтгэлийн нэг хэсэг болгон олон нийтэд мэдээлнэ.

## Жишээ 6

**Баримтууд:** Тамирчныг дэмжих этгээд нь допингийн эсрэг хууль анх удаа зөрчсөнтэй холбогдуулан олгосон эрх хасах хугацаа нь 14 сар байснаас томоохон туслалцаа гэсэн заалтаар шийтгэлийг 4 сараар багасгасан. Одоо допингийн эсрэг хуулийн 2.1 хэсэг тэмцээний үеэр авсан допингийн шинжилгээгээр тусгай бодисын жагсаалтад байдаггүй стимулянт байсантай холбогдуулан допингийн эсрэг хуулийг хоёрдахь удаагаа зөрчсөн болсон. Тамирчин нь томоохон алдаа буюу санаатай үйлдэл байгаагүй гэдгийг харуулсан ба тамирчнаас томоохон туслалцаа үзүүлсэн. Хэрэв энэ нь анхны зөрчил байсан бол зөвлөлөөс тамирчинд эрх хасах хугацаа 16 сар байхаар тогтоож томоохон туслалцаа үзүүлсэнийх нь төлөө 6 сарыг хассан.

### Үр дагаврыг хянах:

1. Энэхүү хуулийн 10.7.4.1 болон 10.7.5 зүйл үйлчлэх учир допингийн эсрэг хуулийг хоёрдахь удаагаа зөрчсөн нь 10.7 зүйлд хамаарна
2. Энэхүү хуулийн 10.7.1 зүйлд заасанчлан эрх хасах хугацаа дор дурьдсанаас дээш хугацаагаар байна. Үүнд:
  - a. 6 сар
  - b. Энэхүү хуулийн 10.6 зүйлд заасан аливаа эрх хасах хугацааг с. бууруулсаныг тооцохгүйгээр допингийн эсрэг хууль анх удаа зөрчсөнтэй холбоотой оногдуулах шийтгэл нь 1/2 дахин бага байна. (энэ тохиолдолд 14 сарын талтай тэнцүү буюу 7 сар байна)
  - c. Хоёрдогч удаагаа допингийн эсрэг хууль зөрчсөнтэй холбогдуулан эрх хасах хугацааг анх удаа зөрчил гаргаж байгаа мэтээр тооцон энэхүү хуулийн 10.6 зүйлд заасан ямар нэгэн эрх хасах хугацааг тооцохгүйгээр 2 дахин нэмэгдүүлэн тооцно. (Энэ жишээн дээр 16 сарын 2 удаагаа нэмэгдүүлсэн буюу  $16 \times 2 = 32$  сар байна)

Тиймээс хоёрдахь удаагийн үйлдлийн төлөө шийтгэл оногдуулах хугацаа нь a,b,c- аас их буюу эрх хасах хугацаа нь 32 сар байна.

3. Дараагийн шатанд зөвлөлөөс энэхүү хуулийн 10.6 зүйлд (алдаагүй байсантай холбогдуулан эрх хасах

хугацааг бууруулах) заасан эрх хасах хугацааг бууруулах боломжийг судалсан. Хоёрдахь удаа зөрчил гаргасан тохиолдолд зөвхөн 10.6.1 (Томоохон туслалцаа) заалт л хамаарна. Томоохон туслалцаанд үндэслэн эрх хасах хугацааг 32\* сарын 3/4-р бууруулж болно. Гэхдээ эрх хасах хамгийн бага хугацаа нь 8 сар байна. (Энэхүү жишээгээр зөвлөл нь томоохон туслалцаа үзүүлсэний төлөө 2 жилээр эрх хасах хугацааг 8 сар хүртэл бууруулж болно гэдгийг харуулах зорилготой.)

\*Тусгай нөхцөлд ДДЭА-аас баталсанаар томоохон туслалцаа үзүүлсэний төлөө эрх хасах хамгийн дээд хугацаа нь нийт хугацааны  $\frac{3}{4}$ -с их байж болох ба мэдээлэх, хэвлэх үйлдлүүд хойшилж болно.

4. Тэмцээн дээр Сөрөг Аналитик хариу гарсан болохоор зөвлөл нь тэмцээн дээр гаргасан амжилтыг автоматаар хүчингүй болгоно.
5. Энэхүү хуулийн 10.8 зүйлд заасанчлан дээж авсан өдрөөс эрх хасах хугацаа хүртэлх бүх тэмцээний амжилтыг шудрага байдлын журамд өөрөөр заагаагүй бол хүчингүй болно.
6. Энэхүү хуулийг 14.3.2-т заасан мэдээллийг тухайн тамирчин нь насанд хүрээгүйгээс бусад тохиолдолд 10.13 зүйлд заасан шийтгэлийн нэг хэсэг болгон олон нийтэд мэдээлнэ.
7. Энэхүү хуулийн 10.12.1-д заасан тамирчны эрх хасах хугацааны явцад гарын үсэг зурсан талууд буюу түүний салбаруудын эрх мэдлийн хүрээнд аливаа тэмцээн буюу спортын холбоотой үйл ажиллагаанд тухайн тамирчныг ямар нэгэн байдлаар оролцохыг зөвшөөрөхгүй. Гэхдээ тамирчин нь
  - А. Эрх хасуулсан хугацааны сүүлийн 2 сард,
  - Б. 10.12.2 зүйлд заасан эрх хасах хугацааны сүүлийн  $\frac{1}{4}$  хугацаанд тус тус гарын үсэг зурсан талууд болон түүний салбаруудын аливаа клуб, бусад гишүүн байгууллагуудын тоног төхөөрөмжийг ашиглан багтайгаа хамт дасгал сургууль хийж болно. Тиймээс тамирчин нь эрх хасах хугацааны сүүлийн 1-1.5 сарын дотор бэлтгэл сургуулилтандаа эргэн ирж болно.